Если в 2014 году объем двусторонней торговли составил 1,6 млрд. долларов США, то в 2016 году объем двусторонней торговли снизился и составил 936 млн. долларов США. Необходимо отметить, что при этом сохраняется серьезный дисбаланс между экспортом и импортом: на российские поставки приходится более 90 % всего объема двусторонней торговли. Ведущее место здесь привычно занимают нефтепродукты и электроэнергия. В частности, ОАО «Роснефть» обеспечивает более 98 % потребностей Монголии в автомобильном бензине, авиационном и дизельном топливе.

В настоящее время на региональные и приграничные субъекты Российской Федерации, куда входят республики Бурятия, Тыва и Алтай, а также Иркутская, Кемеровская, Новосибирская, Омская и Забайкальская области, приходится более 70 процентов общего товарооборота между Монголией и Россией. Необходимо оценить роль регионов в развитии торговли и других форм экономического сотрудничества России с Монголией. Сотрудничество российских регионов с Монголией в наши дни не только не утратило своего значения, но и приобрело дополнительные возможности для реализации основных целей российско-монгольских торгово-экономических отношений, включая использование преимуществ международного разделения труда для развития хозяйственных потенциалов обеих сторон.

Инвестиционное сотрудничество между Монголией и Российской Федерацией. Что касается инвестиционного сотрудничества Монголии с Россией, то в рамках Межправительственной комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству определены приоритетные отрасли двустороннего сотрудничества: строительство железной дороги, горнорудная промышленность, добыча, переработка урана, геологоразведка, строительная индустрия, производство строительных материалов, агропромышленный комплекс, жилищно-коммунальное хозяйство, здравоохранение и медицина.

Многие инвестиционные проекты осуществляются малым и средним бизнесом на региональном и приграничном уровне.

Создаются совместные предприятия как в Монголии, так и в России.

Перспективным направлением является участие российских компаний в развитии зоны свободной торговли «Алтанбулаг» с инвестированием во вновь создаваемые производственные предприятия.

Однако, в отличие от советского периода, эти отрасли становятся объектами сотрудничества Монголии с другими странами и международными организациями; РФ сталкивается с их конкуренцией за присутствие на инвестиционном рынке Монголии.

Объем российских инвестиций в монгольскую экономику растет невысокими темпами. За 1991-2015 гг. общий объем инвестиции из России составил 300 млн.долларов США по 18 отраслям Монголии. Из них 27.2% направлены на геологоразведку, 15.5% - на строительство и в промышленность строительных материалов, 12.3% - финансовые организации, 9.7% - пищевую промышленность, 6.5% -на транспорт, 6.3% - торговлю и услуги.

В Монголии зарегистрировано более 700 российских и российско-монгольских компаний (в том числе 51 - в геологоразведке, горнодобывающей и перерабатывающей промышленности, 34 – в пищевой промышленности, 55 – в строительстве и производстве стройматериалов, 106 – в легкой промышленности, 40 – в энергетике, 21 – в транспорте, 12 – в туризме), однако реально работают лишь 50-60. Ярким проявлением взаимовыгодного сотрудничества между Монголией и Российской Федерацией явилось деятельность совместных монголо-российских предприятий: горнообогатительного медно-молибденового комбината «Эрдэнэт», который является флагманом монгольской индустрии и входит в десятку крупнейших подобных предприятий в мире; Объединения «Монголросцветмет» по добыче и производству плавиковошпатовой продукции; АО «Улаанбаатарская железная дорога». Российская сторона летом с.г. продала монгольской стороне принадлежавшие ей 49 процентов первых двух предприятий.

Перспективы роста экспорта мяса из Монголии. В самый расцвет торгово-экономического сотрудничества Монголии и Советского Союза со второй половины 60-х гг. и до 80-х гг. прошлого века экспорт мясного скота из Монголии в СССР составлял около 40 % от всего экспорта. После развала СССР резко уменьшился экспорт мяса из Монголии. 20 лет назад в 1996 году в России производилась 4,5 млн. т мяса, т.е. половина необходимого для нужд населения, другая половина импортировалась. В настоящую время Россия экспортирует курятину и свиннину.

<i>Виды мяса</i>	<i>Импортировалось в РФ в 90-х гг. XX в.</i>	<i>Ныне производится в РФ</i>
Курятина	1,5 млн.т	4,8 млн. т
Свинина	1,5 млн.т	2,96 млн. т
Говядина	1,5 млн.т	1,315 млн. т

Сегодня вся говядина, производимая в России, составляет 1,315 млн. т, удовлетворяет спрос лишь на 80%, остальное 20 % или 325 тыс. т завозится из-за рубежа, , из них 90 % или 292.5 тыс. т из Бразилии, 10 % - 32,5 тыс. т из других стран, в том числе из Монголии.

С 1 декабря с.г. запрещен ввоз из Бразилии из-за обнаружения в говядине стимуляторов роста мышечной массы. Её место займут экспортёры из Аргентины, Парагвая и Уругвая.

Монголия могла бы поставлять до 100 тыс. т говядины, но российские ветеринарно-санитарные нормы не позволяют этого делать, немного говядины поставляется для тепловой переработки на мясокомбинаты Иркутска и Улан-Удэ.

Чтобы увеличить поставки мяса КРС из Монголии в Российскую Федерацию необходимо повысить конкурентоспособность монгольского мяса. Для этого нужно проделать огромную работу по оздоровлению и улучшению продуктивности скота, находящегося в частных аратских хозяйствах.

Необходимо расширение международной географии продаж мяса и стратегическое развитие экспортного потенциала Монголии в области сельского хозяйства.

1. Наладить поставку баранины в страны мусульманского мира: в Синьцзян-Уйгурский АО, страны Центральной Азии, в которые при социализме традиционно поставлялся мелкий рогатый скот из Монголии, в страны Ближнего и Среднего Востока, арабские страны. Для этого необходимо провести переговоры с представителями этих стран, а также изменить систему заготовки скота, т.е. в мусульманских странах ставят требования забоя скота и заготовки их мяса халяльным способом в соответствии с мусульманскими обычаями.
2. Россия импортирует картофель из Египта, а Монголия экспортирует его в Японию. Для Монголии лучше поставлять картофель в Россию.
3. В отдельных областях Сибири и в ДВО до сих пор сохраняется

реальная нехватка свежей, экологически чистой тепличной продукции. В Монголии необходимо развивать тепличное хозяйство с современной энергосберегающей технологией, используя сравнительное преимущество в наличии большого количества солнечных дней в году. Для этого необходимо создавать СП с российскими компаниями. Например, то же АО “Ренова”, которое было заинтересовано инвестировать в горнорудную промышленность Монголии и которое строит тепличное хозяйство в Республике Коми, могло бы инвестировать в сельское хозяйство Монголии, где очень много солнца и нет еще серьезных конкурентов.

4. Необходимо создание в Монголии дорожной карты профильного направления, разработать программу Национальной технологической инициативы и запрос на развитие новых технологических направлений в агропромышленном комплексе и органической сельхозпродукции. Для этого нужна инициатива и активная позиция некоторых министерств и ведомств Монголии и РФ в привлечении российских инвесторов, предоставление субсидий, т.е. нужна активная государственная поддержка.
5. Необходимо развитие монгольско-российской инициативы в создании мясных, овощных, молочных, зерновых кластеров на территории Монголии. Для этого прежде всего необходимо определить регионы и найти потенциальных российских инвесторов, в том числе из тех, кто возвращает свои капиталы из заграницы в РФ.

Заключение. Таким образом, историю торгово-экономического сотрудничества между Монголией и Россией можно подразделить на три периода:

- I. Период с 1921 по 1990 гг. Необходимо отметить, что многообразное торгово-экономическое сотрудничество Монголии с СССР, продолжавшееся почти 70 лет, явилось определяющим фактором социально-экономических преобразований в отсталой феодальной Монголии и важнейшей предпосылкой ее экономического роста.

В этот период торгово-экономические отношения Монголии с Советским Союзом в значительной степени диктовались политическими, идеологическими и стратегическими причинами, стремлением показать успехи социально-экономического развития Монголии по социалистическому пути. Торгово-экономическое сотрудничество, вместе с тем, безусловно, учитывало

и отражало взаимные возможности и потребности сторон, поскольку поставки из Советского Союза обеспечивали Монголию важнейшими товарами производственного и потребительского назначения, а импорт из МНР животноводческого сырья, продукции горнодобывающей, легкой и пищевой промышленности отвечал потребностям советского рынка.

Таким образом, из истории зарождения и развития торгово-экономических отношений видно, что Монголия поставляла северному соседу в основном непереработанное животноводческое сырье. Особенно поставки такого сырья увеличивались во время двух мировых войн.

Так, обобщая опыт и особенности экономического сотрудничества Монголии с Россией следует отметить, что наряду с несомненными и значительными достижениями в комплексе двусторонних связей был сформирован ряд нерешенных проблем, который в конце концов стал оказывать сдерживающее влияние на возможности дальнейшего их развития с достаточно высокой эффективностью для партнеров.

II. Период с 1991 по 1999 гг. - период, который можно было бы назвать застойным. В начале 90-х гг. прошлого века в системе внешнеэкономических связей России и Монголии произошла смена приоритетов, ослабление взаимного интереса к торгово-экономическому сотрудничеству, сопровождавшееся существенными изменениями в его содержании и формах: важнейшими среди них следует считать деидеологизацию сотрудничества, отмену государственной монополии внешней торговли, переход на расчеты в свободно конвертируемой валюте по ценам мирового рынка, прекращение льготного государственного кредитования экономического развития Монголии. Эти изменения наряду с серьезными внутриэкономическими трудностями в обеих странах предопределили сокращение монголо-российского торгово-экономического сотрудничества. За эти годы Россия утратила свою позицию на монгольском рынке, за исключением рынка нефтепродуктов. После развала СССР двусторонний товарооборот между Монголией и Россией существенно сократился, что было связано с воздействием ряда факторов:

- 1) осуществление мер по стимулированию притока в экономику страны зарубежного капитала;
- 2) ухудшение экономического положения, падение производства в обеих странах в связи с трудностями перехода к рыночным методам регулирования народного хозяйства;
- 3) переход с 1991 года на расчеты в торговле в свободно конвертируемой валюте (СКВ) по ценам мирового рынка (обе стороны испытывали

дефицит СКВ);

- 4) свертывание инвестиционного сотрудничества на условиях льготного кредитования Россией программ экономического развития Монголии;
- 5) усилия монгольской стороны по диверсификации географической структуры внешнеэкономического сотрудничества;
- 6) разрыв сложившихся хозяйственных связей;
- 7) нерешенность проблемы урегулирования задолженности страны по предоставленным ей ранее кредитам.

К концу 2003 года удалось окончательно урегулировать на взаимоприемлемой основе проблему так называемого «большого долга» Монголии по советским кредитам в переводных рублях.

III. Период с 2000 по настоящее время - период постепенного восстановления торгово-экономических связей между двумя странами, но сохраняется огромный дисбаланс в торговле.

Необходимы новые области и современные формы сотрудничества.

ЛИТЕРАТУРА

На монгольском языке.

1. Белая книга экономики и внешней торговли Монголии. Торгово-промышленная палата Монголии. Улаанбаатар, 2008.
2. П.Бямбацэрэн, Н.Мишигдорж “Монголия в социально-экономическом развитии мира”. Улаанбаатар, 2009.
3. Д.Галсандорж, Х.Буд “Краткая история внешнеэкономических связей Монголии /1921-2000/”. Улаанбаатар, 2001.
4. Громова А.В. Сферы иностранного влияния в экономике Монголии. М., 2002.
5. Калинин А. Революционная Монголия. М., : Госиздат, 1926. С.54.
6. С.Лувсандорж, БНМАУ-д худалдаа хөгжсөн нь. (Развитие торговли в МНР). УБ., 1959, 17-р талд.
7. Материалы и документы заседаний Монгольско-Российской межправительственной комиссии по торгово-экономическому и научно-техническому сотрудничеству 1992-2017.
8. Сборник монгольско-российских договоров и соглашений (1990-2001). Улаанбаатар, 2001.

МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

*Ё.Жаргалсайхан**

Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын найрсаг харилцаа тогтоох тухай гэрээг 1921 оны 11 дүгээр сарын 5-нд байгуулан, албан ёсоор дипломат харилцаатай болсноос хойш бараг 100 жил болох гэж байна. 1923 оны 12-р сард БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд худалдааны анхны Хэлэлцээр байгуулсан нь үндэсний худалдааг хөгжүүлэх, манай хоёр орны харилцан бараа гүйлгээг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1923-1924 онд Монгол Улсын гадаад худалдааны экспортын 14% ЗХУ-д ноогдож байсан бол 1928-1929 онд 85,5% болж өсч, Зөвлөлт Холбоот Улс 1931 оноос монголын мах, түүхий эд импортлогч, манай улсад үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн экспортлогч гадаад худалдааны гол түнш орон болсон байлаа.

“Монгол Улсын Засгийн газар, Зөвлөлт Холбоот Улсын Засгийн газар хоорондын худалдааны гэрээ”-г 1957 онд урт хугацаагаар байгуулж, уг гэрээгээр худалдааны тааламжтай нөхцөл болон төрөл бүрийн хөнгөлөлтийг харилцан олгосон. Энэхүү гэрээний үндсэн дээр бараа эргэлтийн болон худалдааны төлбөрийн тухай хэлэлцээрийг таван жилээр, худалдааны Протоколыг жил жилээр байгуулан хэрэгжүүлдэг байсан юм.

1960-аад оноос Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл байгуулагдаж, социалист орнууд “эдийн засгийн интеграцлал”-д эрчимтэй орсноор манай гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бусад социалист орнуудаар хүрээгээ тэлсэн билээ.

1990 оныг хүртэл БНМАУ, ЗХУ нь социалист системийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай улс байсан бөгөөд 1991 оноос ЗХУ задарч, ОХУ бий болсон, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хөгжүүлэх болсон. Хоёр улсад нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт, шинэчлэлт явагдаж байсан он жилүүдэд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хумигдаж, зогсонги байдалд орсон боловч 2010 оноос хойш харилцаа аажмаар сэргэж эхлэх хандлага гарах болсон. Хэдийгээр 2 улсын хооронд улс төрийн хувьд ямар нэг маргаантай асуудал байхгүй, төрийн дээд, өндөр хэмжээнд, Засгийн газар хооронд, иргэд, аж

* Доктор /Ph.D./

ахуйн нэгжийн хоорондын харилцаа туйлын тааламжтай байгаа ч худалдаа, эдийн засгийн харилцаанд дорвитой өсөлт хөгжил гарч чадахгүй байна.

Монгол Улсын эдийн засгийн байдлыг 2016 оны дүнгээр авч үзвэл дотоодын нийт бүтээгдэхүүн 23.935,8 тэрбум төгрөг болж, хэдийгээр эдийн засгийн хүндрэл бэрхшээл дунд байсан ч 2010 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оноос 1,2 хувиар өссөн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 20,1 хувийг уул уурхайн олборлолтоос, 11,7 хувийг хөдөө аж ахуй, 11,2 хувийг бөөний болон жижиглэнхудалдаа, 8,3 хувийг бүтээгдэхүүний татвар, 7,2 хувийг боловсруулах үйлдвэр, 6,7 хувийг үл хөдлөх хөрөнгө, 5,2 хувийг санхүү даатгал, 5,1 хувийг тээвэр, агуулахын үйлчилгээ, 4,0 хувийг барилгын салбар эзэлж байна. Уул уурхай, хөдөө аж ахуй 31,9 хувийг бүрдүүлэн, зонхилох салбарууд болж байгаа нь манай улс мал сүрэг, байгалийн баялаг арвинтай ч эдийн засаг нь түүхий эдэд суурилсан, үйлдвэрлэл сул хөгжсөн орон болохыг харуулж байна.

Сүүлийн 10 жилийн эдийн засгийн үзүүлэлтийг тухайн оны үнийн дүнгээр тооцож харьцуулбал, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 4,8 дахин нэмэгдсэн бөгөөд энэ хугацаанд уул уурхай 3,6, хөдөө аж ахуй 3,1 дахин нэмэгдсэн бол бөөний худалдаа хамгийн өндөр буюу 313,2 тэрбум төгрөгөөс 2.677,8 тэрбум төгрөг болж 11,7 дахин, барилга 8,9 дахин, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 8,6 дахин өсч, хурдацтай хөгжиж буй салбарууд болж байна. Боловсруулах үйлдвэрлэлийн салбар энэ хугацаанд 5,6 дахин нэмэгдсэн боловч нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ бага /7,2%/ хэвээр байна.

Сүүлийн 10 жилийн дүнгээр авч үзвэл манай улсаас 5 тивийн 110 оронд 1.947,5-4.916,3 сая ам. долларын бүтээгдэхүүнийг экспортолсон байна. Европын 27 орон руу 118,8-645,6 сая ам. долларын бүтээгдэхүүн экспортолж байгаа нь нийт экспортын 9,5-19,0%, Азийн 37 орон руу 1.468,0-3.925,8 сая ам. долларын бүтээгдэхүүн нийлүүлсэн нь нийт экспортын 76,0-93,6%, Африкийн 15 орон руу 0,026,0-2,0 сая ам. долларын бараа экспортолж, 0,000006-0,0004%, Америк тивийн 13 оронд 98,5-279,2 сая ам. долларын барааны экспорт хийж, 2,0-14,3%, Австрали улс руу 0,3-3,1 сая ам. долларын бүтээгдэхүүн экспортолсон нь нийт экспортын 0,0001-0,0006% болж байна. Гол экспорт Ази тивд ноогдож байгаа бол Европ, Америк тив рүү харьцангуй багавтар, Африк, Австрали руу маш бага бүтээгдэхүүн нийлүүлж байна. Экспортын гол урсгал БНХАУ руу чиглэж байгаа бөгөөд жилдээ 1.393,9-4.439,9 сая ам. долларын экспорт хийсэн нь нийт дүнгийн 73,9-92,2% болж байна. АНУ, Канад улс зарим нэг жилд 114,2-178,6 сая ам. доллар хүртэл дүнтэй Монголын бараа бүтээгдэхүүнийг авсан боловч зарим жилдээ энэ

үзүүлэлт 1,2-3,6 сая ам. доллар болтол буурч, тогтвортой биш байжээ.

2016 оны дүнгээр 1.562,0 мянган тн зэсийн баяжмалыг экспортолж, 1.607,7 мянган ам. долларын орлого олсон нь нийт экспортын орлогын 32,7% болж тэргүүлж байгаа бол 25,8 сая тн нүүрснээс 973,0 сая ам. долларын орлого орж, 19,8%, 19,2 тн алтны экспортоос 758,4 сая ам. долларын борлуулалт хийсэн нь 15,4%, 8.015,9 мянган баррель нефтээс 337,2 сая ам. доллар орж 6,9%, 6,1 сая тн төмрийн хүдрээс 249,9 сая ам. доллар олсон нь 5,1%, цайрын баяжмал 126 мянган тн-ыг борлуулж, 145,5 сая ам. доллар оруулсан нь 3,0% болж, эдгээр уул уурхайн чиглэлийн 6 бүтээгдэхүүн нийт экспортын 82,9%-ийг эзэлсэн байна. Үхрийн хөлдүү мах, адууны мах, үхрийн шир, адууны шир, хонины самнаагүй ноос, бохир болон самнасан ноолуур зэрэг мал ахуйн гаралтай 7 бүтээгдэхүүн экспортолж, 266,5 сая ам. доллар оруулж ирсэн нь 5,4% болж байна. Үндсэндээ түүхий эдийн борлуулалтаас экспортын орлогын 88,3%-ийг бүрдүүлжээ.

Аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнээс сүлжмэл футболка, майка, свитер, пуловер, жемпер, жилет болон сүлжмэл гадуур хувцас, оёмол гадуур хувцас, оёмол дотуур хувцас, хөнжил ба аяны хөнжил гэсэн 5 төрлийн барааг экспортод гаргаж, ердөө 7,6 сая ам. долларын орлого олсон нь экспортын орлогын 0,15% болж байна. Энэ нь манай улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр байтугай хөрш орнуудад ч өрсөлдөх чадвар сул, борлуулалтгүй байгааг илтгэнэ.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай улсад 5 тивийн 128 орноос 2.061,8-6.738,8 сая ам. долларын бүтээгдэхүүнийг импортолсон байна. Европын 39 орноос 1.013,6-2.803,4 сая ам. долларын бүтээгдэхүүн импортолж байгаа нь нийт импортын 41,6-49,2%, Азийн 38 орноос 908,7-3.155,8 сая ам. долларын бүтээгдэхүүн авсан нь нийт импортын 42,5-46,8%, Африкийн 20 орноос 1,0-14,8 сая ам. долларын бараа импортолж, 0,0005-0,0022%, Америк тивийн 26 орноос 76,4-706,5 сая ам долларын барааны экспорт хийж, 3,7-10,7%, Австрали улсаас 18,7-111,3 сая ам долларын бүтээгдэхүүн экспортолсон нь нийт экспортын 0,6-1,7% болж байна. Импортын урсгал Европ, Ази тивээс бараг ойролцоо хэмжээтэй ирж байгаа бөгөөд үүнээс гол нийлүүлэгч болох ОХУ 745,0-1.847,4 сая ам. долларын бүтээгдэхүүн нийлүүлсэн нь нийт импортын 24,6-38,2%-ийг эзэлж байсан бол БНХАУ 538,6-2.023,9 сая ам. долларын борлуулалт хийж 25,2-36,6%-ийг нийлүүлсэн бөгөөд энэ нь 2 улсын импорт ойролцоодуу дүнтэй байжээ. 2007-2010 онд ОХУ-ын импорт давамгайлж байсан бол 2011-2016 онд Хятадын импортлогчид манай зах зээлээс илүү орлого олжээ.

2016 оны байдлаар импортоор орж ирсэн гол бүтээгдэхүүн нь дизель түлш /254,8 сая ам. доллар/, суудлын автомашин /219,7 сая ам. доллар/, автобензин /192,9 сая ам. доллар/, цахилгаан эрчим хүч /125,3 сая ам. доллар/, телефон аппарат /104,2 сая ам. доллар/, эм /72,4 сая ам. доллар/, янжуур /50,0 сая ам. доллар/, ачааны автомашин /46,5 сая ам. доллар/, шороо чулуу холих ялгах машин /37,4 сая ам. доллар/, дугуй /36,4 сая ам. доллар/, бульдозер /31,0 сая ам. доллар/, улаан буудай /33,3 сая ам. доллар/, мэдээлэл боловсруулах машин /29,2 сая ам. доллар/, амтлаг гурилан зүйлс /28,4 сая ам. доллар/, элсэн чихэр /25,5 сая ам. доллар/, өргөгч ачигчийн эд анги /25,1 сая ам. доллар/, телевизор /24,0 сая ам. доллар/ болно.

Сүүлийн 10 жилийн гадаад худалдаанд 2007-2013 онд 114,3-2.353,7 сая ам. долларын алдагдалтай байсан бол 2014-2016 онд 537,6-1.558,4 сая ам. долларын ашигтай худалдаа хийсэн байна. Энэ нь эдийн засгийн нийт тэлэлтийн дараа хямрал тохиолдож, гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны эргэлт багассан ч уул уурхайн бүтээгдэхүүний экспорт харьцангуй уналт багатай, зарим үед нэмэгдэж байсантай холбоотой байна.

1990 оноос өмнөх үеийн гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, үүнээс Монгол-Оросын экспорт, импортын хэмжээг тухайн үеийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй харьцуулахад нилээд сонирхолтой үр дүн харагддаг. 1960-1990 онд гадаад худалдаанд импорт давамгайлж, 88,5-1.210,2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Экспортын бүтэц, хэмжээ, 1981-1990 оны байдлаар:

	1981-1985 он		1986-1990 он		Харьцуулсан %
	Сая руб.	Эзлэх %	Сая руб.	Эзлэх %	
Уул уурхайн бүтээгдэхүүн	774,4	38,7	1006,7	41,1	129,9
Мал, мах, махан бүтээгдэхүүн	391,0	19,5	363,0	14,8	92,8
Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн	417,0	20,8	590,3	24,1	141,5
Барилгын материал	103,0	5,1	160,5	6,5	155,9
Арьс шир, ноос үс	202,5	10,1	160,9	6,6	79,5
Бусад бараа	114,0	5,8	168,2	6,9	147,9
Дүн	2001,9	100	2249,6	100	122,4

Монгол улсын гадаад худалдааны өсөлт: сая төгрөгөөр

	1960	1970	1980	1985	1990
Гадаад худалдааны нийт эргэлт	676,7	820,6	2830,7	5314,2	4718,5
Экспорт	289,6	337,6	1199,5	2052,0	1967,0
Импорт	387,1	482,8	1631,2	3262,2	2751,0
Зөрүү /алдагдал/	-88,5	-145,2	-431,7	-1.210,2	-784,0

1980-1990 оны экспортын дүнг харахад аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт бараг 40 гаруй хувьд хүрч байсан нь, уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг боловсруулж бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байсныг харуулж байна.

Импортын барааны ангиллын бүтэц, хэмжээ:

	1981-1985		1986-1990	
	Сая руб.	Эзлэх %	Сая руб.	Эзлэх %
Үйлдвэрлэл-техникийн бараа	2475,2	82,2	3301,2	83,1
үүнээс:Нефть бүтээгдэхүүн	656,1	21,8	990,7	24,9
Өргөн хэрэглээний бараа	535,4	17,8	672,1	16,9
Дүн	3010,6	100	3971,3	100

Монгол-Оросын хооронд худалдааны эргэлт 1990 онд 1233.7 сая ам. доллар болж нийт эргэлтийн 70 орчим хувь байсан бол 1991 онд 473.5 сая ам. доллар болж, 2.6 дахин буурсан, түүнээс хойш энэ уналт үргэжилсээр 1998 онд 198 сая ам. доллар болтлоо багасчээ. Монгол улс-ОХУ-ын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа эрс багассан нь хоёр улсын аль алинд нийгэм, эдийн засгийн харилцааны гүн гүнзгий өөрчлөлт гарч, удирдлагууд өөрчлөгдсөн, баримтлах бодлого чиглэлд өөрчлөлт орсон, ялангуяа манай талаас ОХУ-тай худалдаа, эдийн засгийн харилцааг үргэжлүүлэх оролдлого хийгээгүй, аль болох хөндийрөх хандлагатай болсон нь ихээхэн нөлөөлсөн байна.

Монгол улсаас ОХУ-ад гаргаж байсан экспорт 1990 онд 517.5 сая ам. доллар байснаа 2001 онд ердөө 39.7 сая ам доллар болтлоо 13 дахин багасчээ. Энэ нь ОХУ-ын зүгээс Монголын экспортын бараанд гаалийн өндөр татвар ноогдуулах болсон, мал, мах нийлүүлэх хэмжээ эрс багассан, урьд нь савхин, үслэг болон нэхий эдлэл, хивс, сүлжмэл зэрэг оросын талд ихээхэн эрэлт хэрэгцээтэй байсан монголын уламжлалт барааны нийлүүлэлт үндсэндээ зогссон зэрэг байдлаас шалтгаалсан юм. 2016 онд ОХУ-ад 55,8 сая ам. долларын бараа борлуулсан нь нийт экспортын 1,1% болж байгаагаас гол

бүтээгдэхүүн нь жонш /39,1 сая ам. доллар/, молибден /0,5 сая ам. доллар/, мөн зарим жил багахан хэмжээний нүүрс, хонины ноос гаргасан байдаг.

Импортын хувьд Монгол улс хойд хөршөөс асар их хэмжээний машин техник, сэлбэг хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, материал түүхий эд, өргөн хэрэглээний бараа зэрэг 716.2 сая ам. долларын бүтээгдэхүүн импортолж байсан бол эдүгээ тэр олон нэр, төрлийн бараа бүтээгдэхүүн эрс багасч, нефть бүтээгдэхүүний импорт голлох болсон. 2016 онд ОХУ-аас 880,4 сая ам. долларын бараа оруулж ирснээс гол бүтээгдэхүүн нь дизель түлш /248,7 сая ам. доллар/, автобензин /189,2 сая ам. доллар/, цахилгаан эрчим хүч /125,3 сая ам. доллар/, гурил /6,3 сая ам. доллар/, цагаан будаа /5,8 сая ам. доллар/, маргарин /5,3 сая ам. доллар/, тахианы мах /1,9 сая ам. доллар/, ачааны автомашин /1,8 сая ам. доллар/, нийтийн тээврийн хэрэгсэл /1,0 сая ам. доллар/, суудлын автомашин /0,6 сая ам. доллар/ зэрэг бараа бүтээгдэхүүн байна.

Социализмын үед Монгол улсын мал сүргийн тоо 23,0-25,8 сая толгойгоос хэтэрдэггүй, хамгийн олон мал тоологдсон 1941 онд малын тоо 27.5 сая толгойд хүрч байжээ. 1940-өөд оны үед ОХУ руу гаргах гол экспорт нь мал байсан бөгөөд түүний нийлүүлэлтийг 4,0 саяас давуулах шаардлага тулгарч, мал сүргийн тоо толгойг өсгөх явдлыг гол зорилт болгон, удаа дараа төлөвлөсөөр ирсэн боловч биелүүлэхэд тун хүнд даалгавар байсан юм.

Монголын мал сүргийн тоо: мянган толгой

Он	Нийт мал	Үүнээс малын төрөл				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1930	23.676.2	480.9	1.566.9	1.887.3	15.660.3	4.080.8
1940	26.204.8	643.4	2.358.1	2.722.8	15.384.2	5.098.3
1950	22.702.2	844.2	2.317.0	1.987.8	12.574.8	4.978.6
1960	23.000.5	859.1	2.502.7	1.905.5	12.101.9	5.310.3
1970	22.574.9	633.5	2.317.9	2.107.8	13.311.7	4.204.0
1980	23.771.4	591.5	1.985.4	2.397.1	14.230.7	4.566.7
1990	25.856.9	537.5	2.262.0	2.848.7	15.083.0	5.125.7
2010	32.729,5	269,6	1.920,3	2.176,0	14.480,4	13.883,2
2016	61.549,2	401,3	3.635,5	4.080,9	27.856,6	25.574,9

Монголын малын зарлага хэрэглээ асар их, тоо толгой нь олигтой өсөхгүй байсан тул Монгол Улсын Засгийн газраас ЗХУ-ын Засгийн газартай хэлэлцээ хийж тохиролцсоны дүнд 1988-1990 онуудад 3 жил дараалан жил тутам 28 мянган тн-оор багасгаж, оронд нь үр тариа, төмс хүнсний ногоо,

малын тэжээл өгөх замаар малын зарлагыг багасгаснаар 1990 онд 25.8 сая толгой малтай болсон байна. Харин 1990 оноос хойш малыг хувьчилж, малчид мал аж ахуйг бие даан эрхлэх болсноор малын тоо толгой эрчимтэй өсч, 2016 онд 61,5 саяд хүрч, 2,38 дахин нэмэгджээ.

Манай орны мал аж ахуйн бүтээгдэхүүн нь 5 төрлийн малын мах сүү, ноос, ноолуур, хөөвөр, хялгас болон арьс шир зэргээс бүрэлдэж байсан. 1990 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, амины аж ахуйтан махны хэрэгцээнд малаа амьдаар нь нийлүүлдэг, тийм учир мах үйлдвэрлэлийн хэмжээг малын амьдын болон нядалгааны жингээр тооцдог байв. Мал бэлтгэлийн амьдын жингээс нядалгааны жин буюу махны гарц нь дунджаар 2.06 дахин бага байдаг тул махны жилийн хэрэглээг хангахын тулд малын төрөл тус бүрийн амьдын болон нядалгааны дундаж жинг харгалзан ямар төрлийн, хичнээн тооны мал бэлтгэх тооцоо, төлөвлөгөөг аймаг тус бүрээр тогтоодог байжээ.

Мал бэлтгэл, махны үйлдвэрлэлийн хэмжээ: мянган тн

Он	Мал бэлтгэл		Махны үйлдвэрлэл	
	Амьдын жин	Өсөлт, %	Нядалгааны жин	Өсөлт, %
1940	230.7	-	111.0	-
1950	324.9	140.8	157.3	141.7
1960	382.8	117.8	184.5	117.3
1970	375.5	98.1	179.8	97.4
1980	466.0	124.6	226.8	126.1
1990	512.1	109.4	248.9	109.7
2010				
2016				

Мал бэлтгэлийн хэмжээг малын төрөл тус бүрээр үзүүлбэл: мянган тн

[illegible]

Дээрх байдлаас үзвэл нийт махны хэрэглээнд хонины мах зонхилох хувийг эзэлдэг, дараа нь үхрийн мах орж байна. Мал, мах бэлтгэлийн нийт дүнд эзлэх хувь нь хэлбэлзэл багатай боловч социализмын сүүлийн 20-30 жилд хонь, тэмээний махны бэлтгэл биет хэмжээгээр болон хувийн жингээр ахиутай нэмэгдсэн байдал ажиглагдаж байгаа юм.

Дээр дурдсан малын махнаас гадна 1980-аад оны сүүлчийн хагаст гахай, шувууны мах нилээд нэмэгдсэн юм. 1980 онд гахай, тахианы махны үйлдвэрлэлийн хэмжээ 2.000 тн байсан бол 1990 онд 13.600 тн болсон байна.

Ноос, ноолуурын үйлдвэрлэл нь мал аж ахуйн бас нэг чухал бүтээгдэхүүн байв. Малыг ноос, ноолуур, хөөвөр хялгасын бэлтгэлийн хэмжээ зарим жилүүдэд өсөлт, бууралттай байсан гол шалтгаан нь зуд болсон жилүүдэд малын их хэмжээний хорогдол буюу өнтэй жил өссөнтэй холбоотой байна. Харин ноолуурын хэмжээ 1980-аад оноос ихээхэн нэмэгдсэн нь энэ үед “Товь” комбинат байгуулагдаж, ноолуураар сайн чанартай, өндөр үнэтэй бүтээгдэхүүн хийдэг болсонтой холбоотой байна. 1990-2016 оны хооронд хонины тоо 84,7% өссөн ч ноосны хэмжээ дөнгөж 5,8% нэмэгдсэн бол ямааны тоо 5,0 дахин, ноолуурын хэмжээ 5,3 дахин өсчээ.

Малын ноос үйлдвэрлэлийн хэмжээ: тн

Он	Хонины ноос	Тэмээний ноос	Ямааны ноолуур	Ямааны ноос	Бодын хөөвөр	Бодын хялгас
1940	18,400	2894.1	1039.6	902.0	995.9	1061.9
1950	15,000	3798.1	1013.8	880.4	845.4	897.9
1960	15,200	3488.9	1169.7	1141.8	1046.5	1449.3
1970	19,000	3313.9	1027.9	902.7	1447.3	1563.3
1980	20,100	3089.2	1314.3	884.9	1328.2	1140.0
1990	21,100	2430.6	1464.4	847.4	1349.9	917.7
2010	17,118		6515,8			
2016	22,319		7726,9			

Малын арьс ширний бэлтгэлийн хэмжээ: мян. ширхэг

Он	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Нийт
1940	3.1	31.5	84.0	1003.7	540.6	1.662,9
1950	3.5	104.4	119.8	888.6	652.4	1.765,7
1960	20.2	111.2	195.1	1277.3	863.6	2.467,4
1970	21.1	97.6	301.9	2376.0	942.1	3.738,7
1980	26.5	115.1	462.1	3879.5	1228.1	5.711,3
1990	21.4	390.7	371.2	3058.8	930.4	4.772,5
2010						8.126,4
2016						9.196,1

Төрөл бүрийн малыг махны хэрэглээнд нядлах явцад болон мөн үхэл хорогдлын үед нилээд хэмжээний арьс шир гарч, дотоодын хэрэглээний болон экспортын чухал бүтээгдэхүүн болсоор ирсэн юм.

1950-иад оны эцсээс манай улс газар тариаланг ихээхэн хэмжээгээр өргөтгөж, тариалангийн талбайн хэмжээг 4 дахин нэмэгдүүлж, 300.0 мянган га-д хүргэх, улмаар гурилын дотоодын хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах зорилт тавьж байжээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх үүднээс ЗХУ-тай хэлэлцээр байгуулж, олон мянган трактор, комбайн, бусад техник хэрэгсэл зээлээр авч, олон зуун мэргэжилтэн урьж авчирч ажиллуулж байснаас гадна дотоодын дээд ба тусгай мэргэжлийн ажилтнуудыг бэлтгэж байв. Төв, Сэлэнгэ, Булган, Дорнод, Увс аймгуудад олон арван сангийн аж ахуй байгуулагдан, үр тариа боловсруулах хадгалах зориулалттай гурилын үйлдвэрүүдийг үр тариа, гурил хадгалах агуулах, элеваторын хамт барьж ашиглах болсон байна.

Он	Тариалсан талбай, мянган га					Хураасан ургац, мянган тн			
	Нийт, үүнээс	Үр тариа	Төмс	Хүнс ногоо	тэжээл	Үр тариа	Төмс	Хүнс ногоо	тэжээл
1960	265.5	246.7	2.21	0.83	15.7	259.4	18.5	18.5	6.9
1965	480.6	420.0	2.73	1.46	56.4	353.9	24.3	15.0	94.7
1970	454.6	419.5	2.87	1.42	30.8	326.5	22.0	12.6	47.5
1975	510.0	437.0	4.30	1.96	66.6	536.3	42.3	19.1	164.4
1980	704.0	557.5	7.45	2.36	136.7	286.8	39.3	26.0	102.8
1985	789.6	636.2	10.34	3.33	139.7	886.2	113.8	41.2	601.2
1989	837.9	673.4	12.62	4.21	147.6	839.1	155.5	41.7	551.0
1990	787.7	654.1	12.17	3.65	117.8	718.3	131.0	59.5	527.1
2010	291,1	259,2	13,8	7,0	11,1	355,1	168,0	82,3	34,8
2016	401,9	377,8	15,0	9,1	29,9	483,5	165,3	94,4	53,4

Үүний үр дүнд 1985-1990 он гэхэд жил тутам 543.3-688.4 мянган улаанбуудай хураан авч, жилдээ 175-200 мянган тн гурил үйлдвэрлэж, хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй зарим жил 90 гаруй мянган тн буудай экспортолж байснаас гадна 30-аад мянган тн гурилыг ч гадаадад гаргаж байв. Түүнчлэн 1985 оноос хойш жилдээ 120-155 мянган тн төмс хураан авч, дотоодын хэрэгцээгээ хангаад, ЗХУ-ад 30 мянган тн төмс экспортоор гаргаж байсан юм.

Хүнсэнд хэрэглэсэн малын зарлага 1986-1990 онуудад ЗХУ-ад нийлүүлж байсан 2.5-3.0 сая малыг оролцуулаад, жилд дунджаар 7.5 сая

байсан. Мал хувьчлагдсан 1991-1992 онуудад хэдийгээр экспортод мал гаргаагүй боловч 7.7-8.9 сая мал хүнсэнд хэрэглэж байжээ. 1993-1995 онуудад хүнсний зарлага багасч 6.3-6.6 сая байснаа 1998-2000 онд 7.5-8.7 сая болж дахин нэмэгдсэн. Сүүлийн 10 жилийн хугацаанд 8,3-12,7 сая малыг дотоодын хэрэгцээнд хэрэглэж буй статистик мэдээлэл гарсан байна.

2016 онд 27,9 сая хонь, 25,6 сая ямаа, 4,1 сая үхэр, 3,6 сая адуу, 0,4 сая тэмээ, нийт 61,5 сая толгой мал тоологдсон бөгөөд үүнээс 10,0 сая хонь, 8,0 сая ямаа, 1,1 сая үхэр, 0,7 сая адуу, нийт жилдээ 19,8 сая толгой малын мах, арьс шир, дагалдах түүхий эдийг эргэлтэд оруулж, зах зээлд нийлүүлэх боломж байна. Үүнээс дотоодын хэрэгцээг хасахад, 10,0-12,5 сая малын махыг экспортлох боломжтой. Тэгвэл бид 2016 онд үхрийн мах ердөө 0,7 тн /3,0 мянган толгой орчим/, адууны мах 8,0 мянган тн /32,0 мянган толгой/ экспортолжээ. Энэ нь бид боломжийнхоо ердөө 0,3-4,6%-ийг ашигласан байна.

Малыг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээ орхигдсноос 1960-1970-аад онд бүрэн эмчлэгдэж, алга болсон мялзан, боом, шүлхий зэрэг өвчин дахин гарах болж, мал сүргийг өвчлүүлж устгалд оруулахад хүргэх, цаашилбал гадаадад экспортод малын бүтээгдэхүүнийг гаргахад саад учруулах боллоо.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ:

Бүтээгдэхүүн	х.н.	2003	2004	2005	2006	2010	2016
Нядалгааны мах, Үүнээс:	Мян. тн	147.9	195.2	183.9	170.7		
Үхрийн	Мян. тн	41.1	53.6	45.3	44.2	3,9	1,6
Хонь, ямааны	Мян. тн	80.0	96.2	93.4	88.4		2,7
Гахайны	Мян. тн	0.2	0.2	0.2	0.2		
Арьс, шир, Үүнээс:	Мян. ш	6.134.4	6.655.2	6.927.1	6.374.0	8.126,4	9.126,4
Адууны	Мян. ш	256.1	317.9	328.0	273.2	342,2	415,0
Үхрийн	Мян. ш	469.0	462.2	404.3	383.8		45,4
Хонины	Мян. ш	3.434.7	3.243.4	3.038.3	2.935.6		
Ямааны	Мян. ш	1.578.3	2.445.1	2.793.4	2.445.4		
Хонины ноос	Мян. тн	13.5	13.4	14.2	15.2	8,0	14,1
Ноолуур	Мян. тн	2.7	3.2	3.7	4.0	4,0	5,9
Сүү	Мян. тн	347.2	406.3	425.9	479.4		
Өндөг	сая ш	7.1	16.0	21.3	19.0		

Шилжилтийн үед хамгийн их унасан салбар бол боловсруулах аж үйлдвэр юм. Манай улсын аж үйлдвэрийн төдийгүй эдийн засгийн гол

салбар байсан хөнгөн үйлдвэр мал аж ахуйн түүхий эдийг боловсруулдаг ноосон нэхмэл, арьс ширэн эдлэхүүн болон оёдлын үйлдвэрүүд байлаа. Тус салбар үндэсний нийт орлого, гадаад худалдааны эргэлтэд эзэлж байсан хувь хэмжээгээрээ уул уурхайн салбараас 2 дахин илүү байсан юм. 1989 онд уул уурхайн салбарын нийт бүтээгдэхүүн 901.5 сая төгрөг байхад хөнгөн үйлдвэрийн салбаруудын нийт бүтээгдэхүүн 1992.3 сая төгрөг болж байжээ. 2016 онд уул уурхайгаас 4.808,4.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол боловсруулах үйлдвэрийн салбараас 1.735,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Энэ хугацаанд ноосон нэхмэл, арьс ширэн эдлэл, оёдлын үйлдвэрийн салбар бүрэн уналтад орсноор нийт бүтээгдэхүүний хэмжээ 2016 онд 1989 оныхоос 21,6 дахин буурсан байна.

**Арьс шир боловсруулах салбарын гол нэр
төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ**

Бүтээгдэхүүн	1989	1990	1993	1995	2000	2010	2016
Шеврет мян. м кв	1151.1	1510.5	287.2	193.5	4.6	1,6	3,9
Шевро мян. м кв	413.2	418.4	64.4	35.9	0.8	1,2	2,1
Гутлын улны шир тн	1000.0	1000.0	200.0	-	-	0,8	6,5
Арьсан гутал мян. ш	4140.0	4222.5	1030.8	245.5	5.6	2,2	34,1
Савхин дээл мян. ш	41.6	35.7	9.4	12.7	0.1	5,6	10,6
Савхин хүрэм мян. ш	212.8	264.5	160.1	18.9	0.1	0	0,3
Нэхий дээл мян. ш	180.2	138.1	86.6	16.8	1.0	16,6	9,2

Монгол улс 1989 онд 25 сая толгой малтай байхдаа жилдээ 1560.0 мянган кв метр шевро, шеврет савхи, үхрийн ширээр 1000 тн гутлын шир хийж байсан бол 2016 онд бараг 60 гаруй сая мал тоолсон мөртлөө 6,0 мянган кв. метр арьс л боловсруулж, бүтээгдэхүүний хэмжээ 250 дахин унажээ. Түүгээр үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний хэмжээ ч бас хэдэн арав дахин унасан буюу үйлдвэрлэл нь бүрэн зогссон байна. Эндээс бид ийм их хэмжээний арьс ширийг боловсруулж, өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг жил тутам алдаж байна. Эдгээр түүхий эд дотоодод боловсрогдохгүй, БНХАУ-ын үйлдвэрүүдэд нийлүүлэгдэн, тэднийг л дэмжсэн үйл ажиллагаа болж байна. Харин сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих санаачлага гарч, зарим бүтээгдэхүүнд өсөлт мэдрэгдэх болсон ч энэ нь 27 жилийн өмнөх үзүүлэлтэд хүртэл маш хол зайтай байна.

Мөн ноосон нэхмэлийн бүтээгдэхүүн, ялангуяа угаасан ноос 30%, сүлжмэл эдлэл 5,1 дахин, ноосон даавуу 5,1 дахин, хивс 4,8 дахин, эсгий 7,3 дахин, эсгий гутал 1184 дахин буурсан бөгөөд 2000 оноос тус салбар сэргэх хандлага гарч байгаа боловч бүтээгдэхүүний хэмжээ дорвитой нэмэгдэхгүй байна.

**Ноосон нэхмэлийн үйлдвэрийн салбарын гол нэр
төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ:**

Бүтээгдэхүүн	1989	1990	1993	1995	2000	2010	2016
Угаасан ноос, мян. тн	10.1	9.7	3.5	1.2	1.4	2,3	7,0
Самнасан ноолуур, тн	250.0	340.1	121.5	420.8	450.9	824,7	776,3
Ээрсэн утас, тн	2962.4	2285.4	737.8	344.9	40.8	90,2	
Сүлжмэл эдлэл мян. ш	4110.5	4248.6	990.7	522.7	1233.5	731,1	812,5
Тэмээний ноосон хөнжил, мян. ш	91.6	91.2	48.7	19.4	28.5	15,3	12,2
Ноосон даавуу, мян. м	1978.2	1111.3	289.9	71.1	21.0	330,2	391,7
Хивс, мян. м	2128.1	1971.2	1000.1	595.7	704.8	609,6	439,1
Эсгий, мян. м	649.7	745.1	241.4	76.5	113.9	104,5	89,4
Эсгий гутал, мян. хос	592.3	588.5	252.1	79.0	34.0	19,2	0,5

Харин дэлхийн зах зээл дээр ямааны ноолуур, ноолууран бүтээгдэхүүний үнэ ханш өндөр байгаатай холбоотойгоор ямаан сүрэг эрс өсч, ноолуурын хэмжээ ихээхэн нэмэгдсэн бөгөөд самнасан ноолуур гэхэд л 1989 оны хэмжээнээс 2016 онд 3,1 дахин өсч, ноолууран бүтээгдэхүүн ч нэмэгдсэн байна.

Бүтээгдэхүүн	1989	1990	1993	1995	2000	2010	2016
Малын мах, мян тн	61.7	57.8	17.3	11.3	6.4	11,7	63,3
Махан консерв, тн	1682.3	1108.54	358.3	431.7	-	178,4	158,0
Хиам, мян тн	5.8	5.5	1.2	0.6	0.7	1,7	4,6
Сүү, сүүн бүт. сая л	62.0	59.6	13.0	5.2	1.5	42,0	63,3
Гурил, мян тн	199.7	189.8	175.5	196.0	40.2	143,1	209,7
Талх, мян. тн	66.7	63.3	46.0	36.8	20.2	19,4	22,3
Чихэр, боов, мян. тн	45.7	41.6	12.0	10.8	7.6	11,7	16,0
Гоймон, тн	751.0	732.0	-	2245.3	865.9	2.055,7	4.050,5
Спирт, сая л	3.4	3.5	2.2	2.1	3.8	8,4	8,6
Архи, ундаа, сая л	4.9	6.4	5.2	3.7	6.6	20,4	23,9
Пиво, сая л	12.1	12.6	-	1.3	3.2	44,9	75,7

Хүнсний үйлдвэрийн салбар 1989 онд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 35 хувийг эзэлдэг томоохон салбар байлаа. Тухайн үед төр, засгаас хүн амын хүнсний гол 3 хэрэглээ болох мах, сүү, гурилаар хангах зорилт тавьж, мах комбинат, гурилын үйлдвэрийг бүсчилсэн байршлаар

байгуулсан, Улаанбаатар, Дархан зэрэг томоохон хотуудад төрөлжсөн үйлдвэрүүд байгуулагдсан, аймгийн төв хотуудад хүнсний комбинатуудыг өргөтгөн шинэчилсэн буюу шинээр байгуулж байсан билээ. 1989 оны Улсын статистикийн бүртгэл, мэдээлэлд тусгагдсан 10 гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг 2016 онтой харьцуулж үзэхэд мах, архи, пиво, спирт, гурил, гоймон, сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, махан консерв, хиам, талх, чихэр боовны хэмжээ буурсан байна.

Монгол-Оросын худалдаанд гол хүндрэл учруулж буй саад бэрхшээл нь ОХУ-ын зах зээлд гаргах боломжтой манай экспортын бүтээгдэхүүн болох мах, дайвар маханд 23%, сүлжмэл хувцас, согтууруулах болон согтууруулах бус ундаа, бүтээгдэхүүнд 22,8-27,7% хүртэл импортын тариф ноогдуулдагд оршино. Энэ нь Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн Оросын зах зээлд өрсөлдөж борлогдох боломжийг хааж буй гол хүндрэл болоод байна. Мөн тарифын хүндрэлээс гадна эрүүл мэнд, мал эмнэлэг, ургамал, эрүүл ахуй, хорио цээр, стандартын нөхцөл шаардлага, хяналт, хориг хязгаарлалт, квот, хил гаалийн үзлэг шалгалт, хүнд суртал зэрэг тарифын бус арга хэмжээний олон саад бэрхшээл тулгарч байна. Манай талаас ОХУ-тай тарифын ба тарифын бус саад бэрхшээлийг арилгах талаар олон яриа хэлэлцээ хийж буй боловч ОХУ- нь 2015 оноос БНКазУ, БНБелУ, Армен, Киргиз улсуудтай нэгдэн Евразийн эдийн засгийн холбоог байгуулан, интеграцчлалд орж байгаа тул тус холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар асуудлыг шийдэх боломжтой болж байна.

Манай махны бүтээгдэхүүний хамгийн том хүндрэл бол мал, амьтны эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага бөгөөд мал, амьтан, хүнд халдварладаг шүлхий, мялзан, цэцэг, бруцеллёз зэрэг олон төрлийн халдварт өвчин ялангуяа сүүлийн жилүүдэд маш их гарах болсон. Гэтэл хөгжингүй орнууд ийм өвчний халдвар тархсан бол халдварлагдсан бүх малыг устгалд оруулж, хэдэн саяар нь хяддаг билээ. Хэрэв уг өвчин гаднаас санаатайгаар тархагдсан байх байдал тогтоогдвол учирсан хохирлыг буруутай этгээд төлөхөөс гадна гадаад худалдаа, улс хоорондын төдийгүй олон улсын харилцаанд маш таагүй үр дагавар авчирна. Тэгэхээр бид мах экспортлохдоо ашиг харахаасаа өмнө гарах үр дагаварт маш хянамгай, хариуцлагатай хандаж, эрүүл ахуй, халдваргүйжилт, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг дээд зэргээр хангах шаардлагатай. Хэдийгээр 5,0-10,0 сая тун вакцин оруулж тарилга хийж буй боловч 60,0-70,0 сая малд бүрэн хүрэлцэхгүй, дээр нь малчид, ченжүүд мал, махыг ачааны автомашинаар чөлөөтэй зөөвөрлөж, аймаг-хотын хооронд тээвэрлэж байгаа тул халдваргүй аймаг, бүс байгуулах

нь үндсэндээ боломжгүй юм.

Олон улсын стандартын шаардлагад нийцсэн, эрүүл, аюулгүй махан бүтээгдэхүүн экспортод гаргах арга зам бол гадаад орчноос бүрэн тусгаарлагдаж, ариутгагдсан фермерийн аж ахуй байгуулах явдал юм. Монголын бэлчээрийн малын мах нь бусад хөгжилтэй орнуудын фермерийн аж ахуйн махыг бодвол өөх холестерин ихтэй, булчинлаг хатуу, болц удаан, хурц үнэр, амттай, эрүүл ахуйн хувьд ч гэсэн шимэгч паразит бактери агуулах магадлалтай байдаг. Манай үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээ, хэрэглэгчийн хүсэл сонирхол, тавих шаардлага зэрэг гол хүчин зүйлийг судлах хандлага сул байна. Гадаадын хэрэглэгчдийн хүнсэндээ хэрэглэх мах нь эрүүл, цэвэр, зажлуур багатай, зөөлөн, мах өөх алагласан, гэхдээ өөх багавтар, хурц амт, үнэргүй, болц хурдан байх шаардлагатай байдаг. Тэгэхээр манай хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээ, судалгаа байгууллага, эрдэмтэд монголын малыг экспортод гаргах технологи, стандартыг боловсруулж, төр, засгаас фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай бүхий л талын дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай. Үүнд экспортод гаргах малын нас, хүйс, жинг сонгох, тэжээх горим, хуваарь, хоол тэжээлийн орц хэмжээ, чанар, байранд тавигдах нөхцөл шаардлага, нядалгааг явуулах, боловсруулах, хадгалах, битүүмжлэх, савлах, тээвэрлэх бүхий л шат дамжлагын технологийг нарийвчлан тодорхойлж, стандартыг гаргах шаардлагатай. Үүний дүнд импортлогчид эрүүл, аюулгүй хүнс авах баталгаа нь хангагдаж, бид нэмүү өртөг шингэсэн үндэсний бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд найдвартай, байнга тогтвортой нийлүүлэх боломж бүрдэнэ.

Монголд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн нөхцөл шаардлага олон улсын стандартын түвшинд хүрдэггүй. Дэлхийн худалдааны байгууллагын хийсэн судалгаагаар манайд одоо мөрдөгдөж байгаа 5900 стандартын талаас илүү нь хуучин ЗХУ-ын үеийн ГОСТ системд суурилсан нь олон улсын ISO шаардлагад нийцдэггүй байна. Одоогийн стандартуудыг нэг дор бүгдийг нь шинэчиллээ гэхэд үндэсний үйлдвэрлэгчид түүнд нийцүүлж техник технологи, хүчин чадлаа сайжруулж нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэр хүрэлцэхгүй хүндрэл бэрхшээл үүсэх магадлалтай.

“Иргэд харилцан визгүй зорчих тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн Хэлэлцээр”-ийн дагуу манай улсын иргэд 30 хүртэл хоногийн хугацаанд харилцан визгүй зорчих болон дамжин өнгөрөх эрхтэй болоод

байна. Визгүй болсон анхны жил буюу 2014 оны 12 сарын 1-нээс 2015 оны 12 сарын 1-ны хооронд давхардсан тоогоор монголын 500 мянга орчим иргэд ОХУ-д төрөл бүрийн зорилгоор зорчжээ. Монголын иргэд зөвхөн наймаа худалдаа гэлтгүй амрах, суралцах, цагийг зугаатай өнгөрүүлэх төрөл бүрийн арга хэмжээ, албан ба албан бус сургалт семинар, уралдаан тэмцээн гээд олон төрлийн харилцаагаар ОХУ-ын хотуудад зорчих болсон. Үүний дүнд Буриад Улс, Улан-Үд хот монголчуудад зориулж худалдааны сүлжээг өргөжүүлж, олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулж чадсанаар Оростоо хамгийн өндөр дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгож чадсан байдаг. Зөвхөн гадаад худалдаанаас гадна аялал жуулчлал, амралт сувилал, эмчилгээ, худалдаа үйлчилгээний салбараас 2 улс ихээхэн ашиг орлого олох боломжтой.

ДҮГНЭЛТ

1. Монгол, Оросын хооронд дипломат, худалдаа, эдийн засгийн харилцаа тогтсон 100-аад жилийн түүхэнд Монгол улсын хөдөө аж ахуй, газар тариалан, уул уурхай, аж үйлдвэрийн салбарууд амжилттай хөгжиж, ЗХУ-ад нийлүүлэх манай бүтээгдэхүүний хэмжээ нийт экспортын 70-85 хувийг эзлэж байлаа. 1990 оноос өмнө жилдээ 2,5-4,0 сая толгой мал, 90,0 мянган тн үр тариа, 30,0 мянган тн төмс, 30,0 мянган тн гурил, мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос үс, барилгын материал, савхин, үслэг эдлэл, нэхий, сүлжмэл эдлэл, хивс зэрэг олон нэр төрлийн барааг ЗХУ руу экспортолж байжээ.
2. Харин 1990 оноос хоёр орны улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоонд гарсан эрс өөрчлөлтийн улмаас улс орны удирдлагын арга барил, гадаад харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хандлага өөрчлөгдснөөр Монгол-Оросын хоорондын гадаад худалдааны цар хүрээ, хэмжээ эрс хумигдсан байна. Өнгөрсөн 27 жилийн хугацаанд Монголын экспортын бүтээгдэхүүний түүхий эдийн нөөц, тухайлбал, малын тоо 2,4 дахин, түүнийг дагалдаг гарах арьс шир, ноос ноолуур, мах, сүү, нэмэгдсэн боловч Орос руу гаргах экспортын бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ 517,5 саяас 55,8 сая ам. доллар хүртэл 9,3 дахин буурсан байна.
3. Хэдийгээр Монголоос ОХУ-д гаргах экспортын хэмжээ маш бага болсон ч өнгөрсөн хугацаанд бидэнд урьд нь байгаагүй их уул уурхай, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн потенциал бий болсон. Мал аж ахуйд гэхэд 19,8 сая толгой малын мах, арьс шир, дагалдах түүхий эдийг боловсруулж,

3. Суходолов А. П., Дорж Т., Болдбаатар Б., Кузьмин Ю. В., Манжигеев А. Ф. Россия и Монголия: концептуальные вопросы российско-монгольских отношений (дипломатия, экономика, наука): сб. науч. тр. Иркутск: БГУ, 2015 – 416 с.
4. Суходолов А. П., Дорж Т., Болдбаатар Б., Кузьмин Ю. В., Манжигеев А. Ф. Россия и Монголия: новый взгляд на историю (дипломатия, экономика, культура): сб. науч. тр. Иркутск: БГУ, 2015 – 376 с.
5. Мясников В. С. Договорными статьями утвердили. Дипломатическая история русско-китайской границы XVII—XX вв. М.: Институт Дальнего Востока РАН, 1996. - 482 с.
6. Моисеев В. А. Россия и Китай в Центральной Азии: вторая половина XIX в.— 1917 г. Барнаул: АзБука, 2003. - 346 с.

7. Лузянин С. Г. Россия—Монголия—Китай в первой половине XX в. Политические взаимоотношения в 1911—1949 гг. М.: ОГНИ, 2000. - 320 с.
8. Дацышен В. Г. Очерки истории российско-китайской границы во 2-й половине XIX—начале XX в. Кызыл: Республиканская типография, 2000. - 216 с.
9. Дацышен В. Г. История российско-китайских отношений в конце XIX—начале XX в. Красноярск: РИО КГПУ, 2000. - 472 с.
10. Белов Е. А. Россия и Китай в начале XX в. Русско-китайские противоречия в 1911—1915 гг. М.: Ин-т востоковедения РАН, 1997. - 314 с.
11. Формирование границы между Россией и Цинским Китаем. Кн. 1-5. М.:АН СССР, 1970.
12. Прозрачные границы. Безопасность и международное сотрудничество в поясе новых границ России. Волгоград: Волгоградский государственный университет, 2002. - 347 с.
13. Мясников В.С., Степанов Е.Д. Границы Китая: история формирования. М.:Рос.акад. наук. Ин-т Дал. Востока,2001 - 470 с.
14. Россия и Китай: четыре века взаимодействия.История, современное состояние и перспективы развития российско-китайских отношений М.: Весь Мир,2013. - 704 с.
15. Современные российско-монгольские отношения: модели и сценарии, отв. ред. В.А. Родионов. Улан-Удэ: Изд-во БГУ, 2013. - 248 с.
16. Батжаргал Д., Дашбал Б. Современное состояние минерально-сырьевой базы Монголии // Молодой ученый. - 2012. - №3. - С. 122-127.
17. Миронов Ю.Б. Уран Монголии. СПб.: Анатолия, 2006. – 328 с.
18. Берзина А.П., Болд Д. и др. Металлогения Монгольской Народной Республики (в 3т.). Новосибирск: Институт геологии и геофизики СО АН СССР, 1985.
19. Очирбат П. Стратегия.развития минерально-сырьевого комплекса Монголии. М.: Горная книга, 2001 - 275 с.
20. Гундсамбуу Ц. Геология и закономерности размещения месторождений олова, вольфрама и молибдена.-Улан-Батор: 2004. -225 с.
21. Нямзагд С. Стратегическое управление экономикой Монголии. Диссертация на соискание ученой степени доктора экономических наук.- Иркутск: 2002.- 334 с.

МОНГОЛ-ХЯТАД-ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХОНГИЛ: МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АШИГ СОНИРХОЛ.

Р.Батмэнд*

Хураангуй: ОХУ-ын эдийн засаг сэргээж, цэргийн хүч чадал зузаарч, БНХАУ дэлхийн хоёрдох том эдийн засагтай орон болохын хирээр дүрвэгсдийнхөлд дарагдаж, дотоод хямралдаа идэгдэж буй Европын зүг чиглэх эдийн засгийн сонирхол буурч, дэлхий дахины анхаарал Евразийн чигт эргэв. Тоглолтын энэ тавцанд БНХАУ давамгайлж, ОХУ уг тавцанд тэргүүлэх үүрэгтэй үлдэх гэсэн оролдлого хийсээр байна. Энэ чиглэлд БНХАУ-ын дарга Си Жиньпингийн санаачилсан “Эдийн засгийн бүсийн шинэ торгоны зам” төсөл бүс нутгийн орнуудын анхаарлыг ихээхэн татаж байна. Энэ төслийн хүрээнд “Нэг бүс-Нэг зам” санаачлага дэвшүүлсэн ба үүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн 6 коридор байгуулахаар ажиллаж байна. Үүнээс Хятад-Орос-Монголын эдийн засгийн коридор манай улсын сонирхолыг ихэд татаж байгаагийн дээр энэ хонгилыг байгуулах талаар анхны алхамууд хийгджээ. Энэхүү эдийн засгийн коридорт өөрийн байр суурийг баттай эзлэх нь Монгол Улсын хувьд олон талын ач холбогдолтой юм. Ийм учраас энэхүү үгүүлэлд Еврази дахь эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцчлалын байдал, төлөвийг Монгол Улсын гео политик, эдийн засгийн эрх ашгийн үүднээс товч боловч шинжлэн дүгнэж байна.

Түлхүүр үг: Еврази, торгоны зам, эзэнт гүрэн, гео бодлого, марафон, эдийн засгийн бүс, нэг бүс-нэг зам, далайн торгоны зам, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, ашиг сонирхол.

1. *Еврази, түүний түүхэн өв*

Арван есдүгээр зууны төгсгөлөөс дэлхийн нэгдүгээр дайн хүртэл Балкан болоод улам бүр суларч байсан Османы эзэнт гүрэн, Ойрхи Дорнотыг хэрхэх тухай асуудал Европын газар зүйн бодлогод давамгайлж байлаа. Гэтэл одоо дорнын тухай асуудал Евразийн асуултаар солигдож, дэг журмын тухайд их гүрний өв бүхний манлайд гарлаа [1]. Тийм бөгөөс Еврази гэж чухам хэн болоод юу вэ? Тэр их гүрний үлдээсэн өв юу болох тухай товч

* Профессор, Доктор (Ph.D.) Гео политикийн хүрээлэн.

үгүүлсүгэй.

Номхон далайгаа Адритын тэнгис хүртлэх хойт талаараа нэвтрэшгүй их ой тайга, уст их намаг, хойт туйлын их хүйтнээр, өмнө талаараа асар өндөр уул нурууд, элсэн цөлөөр хаагдсан тасралтгүй үргэлжлэх тал нутгийн тогтолцоог Евроази буюу их нүүдэлчдийн нутаг гэмой. Яагаад нүүдэлчдийн нутаг гэж буй хэмээвээс Европын нам дор газарт нутаглаж, далай тэнгис болон, Балтийн тэнгисээс Хар тэнгис хүртэл гол мөрний дагуу аж төрж байсан суурьшмал иргэдэд еврази шиг тийм уудам тал нутгийг эзэмших сонирхол ч, шилжшин нүүх чадал, боломж ч байгаагүй юм. Харин нүүдэлчдийн хурдан шаламгай хөдөлгөөн, хөсөг тээврийн бололцоо гагцхүү энэ нутагт зохицсон байлаа.

Энэ тал нутагт монголчуудын их эзэн Чингис Хаан, түүний үр ач нар хойт талдаа Алтан ордны улс, өмнө талдаа Юань гүрэн, баруун этгээдэд Ил хаант улсыг багтаасан эзэнт гүрнээ байгуулсан билээ.

Алтан ордны улстай хил нийлсэн улс бол Москвагийн оросууд байсан ба орос хүмүүсийн оюун санааны дарамт, үндэстний өөрийн хүндлэлийн доройтол зэргээс үүдэн агуу их харь гүрний төрт ёсны санаа тэдэнд цоо шинэ бодол сэтгэл төрүүлсэн юм [2]. Тэднийг төрт ёс, шашин шүтлэг, өвөрмөц соёлтой болж, Орос их гүрэн байгуулах суурийг Чингис хааны эзэнт гүрний тэнгэрт захирагдах ёс, урван тэрслэгчийг үл тэвчдэг, зохих тохирох эрдэм ухаан, чадалтай л бол энгүүн нэгийг ч бол төр барилцахад оролцуулдаг үл ялгаварлах шудрага ёс, дээрээсээ доош хүртэл итгэл хүлээлгэж, түүнд үнэнч байх захирах, захирагдах зарчим, төрийн хууль зэрэг өв санг багтаасан төрт ёс тавьж өгсөн юм.

Монголын эзэнт гүрний их эзэн хаан Чингис цэрэг эрийн баатарлаг дайчин алдар суу, хэлсэн үг, тохиролцсон зүйлдээ үнэнч байх явдлыг онцгой өндрөөр үнэлдэг байв. Энэ жишгийг ч Орос дагасан юм. Харин Орос оронд Византийгаас авсан үнэн алдартны шашны итгэл үнэмшлийг ахуй орчинд хүртэл дэлгэрүүлж чадсан нь татаруудад ч нөлөөлж Орос гүрэн өндийв. Ингээд оросын төрт ёс, оросын хааны дээд эрх мэдэл *үзэл сурталдаа* оршиж, шашны ертөнцийг үзэх үзэл оросын ахуй соёлтой салшгүй нягт холбогдсон юм. Энэ үеэс эхлэн Москвагийн оросууд нийт Орос орныг нэгтгэн газар нутгаа Балтийн тэнгисээс Номхон далай хүртэл тэлж, эцэст нь ЗХУ хэмээх эзэнт гүрнийг байгуулсан билээ. Ийнхүү Чингисийн евроазийн их өвийг Оросын эзэнт гүрэн уламжлан авчээ.

Монголын эзэнт гүрний Юань улс Евразиар дамжсан торгоны зам, цайны зам зэрэг евразийн эдийн засаг, худалдааны зам харилцаа бий болгож,

өртөө шуудангийн үйлчилгээ байгуулсан билээ. Энэ нь европын арга техникийг дорнодод авч ирэх, дорнын тансаг сайхан эд барааг европ хүргэх, улс төр, цэргийн харилцааг шуурхай гүйцэтгэхэд ихээхэн дөхөм болж, дэлхий нийтийг холбож өгсөн нэг ёсны даяаршил болсон юм.

Ийнхүү Еврази бол Хүннүгээс эхлээд Их Монголын эзэнт гүрнээр дамжин их гүрнүүдийн өсч өндийн хүчирхэгждэг, хаалттай тогтолцоог задлаж, дэлхийн дэг журмыг эрс өөрчилдөг өв сангийн өлгий нутаг юм. Ер нь бол дэлхий дахиныг нэгэн дэг журмын дор захирах гэсэн их гүрнүүд бий болсоор, мандан бадарсаар, гандан буурсаар ирсэн билээ. Тухайлбал, Их Британийн эзэнт гүрэн дэлхий колончлолын тогтолцоог бий болгосон бол түүний эсрэг эрх чөлөө тусгаар тогтнолынхоо төлөө боссон америкчууд АНУ хэмээх өнөөгийн хүчирхэг “эзэнт” гүрнийг байгуулж, дэлхийн дэг журмыг тогтоож байна.

Германы их сэтгэгч нарын нэг Крафт Эрикийн хэлсэнчлэн “дэлхий бол хязгаарлагдмал нөөцтэй хаалттай тогтолцоо биш, харин орчлонт ертөнцийн салшгүй хэсэг нь бөгөөд хүмүүн төрөлхтний бүтээлч үйл болбоос энэ орчлонгийн бодит хийгээд бүтээн байгуулагч хүч мөн” [8], түүнчлэн энэтхэгийн ведийн сударт үгүүлснээр “бид нэгэн гэр оронтой” гэсэн сургаалиудыг тэмдэглэсүгэй.

2. *Еврази дахь өнөөгийн нөхцөл байдал*

2.1. *Хятадын гео бодлого, эдийн засгийн ашиг сонирхол*

БНХАУ-ыг тунхагласны 100 жилийн ой 2049 онд болно. Үүнтэй уялдуулаад зарим судлаачид Хятад улс “Хятадын зуун жилийн марафон” хэмээх бодлого, стратеги баримталж ирснийг дурдаж байна [3]. Түүний хүрээн дэх Хятадын стратегийн 9 зорилтыг тодорхойлжээ. Үүнээс заримыг дурдвал: Өөрийн сөргөлдөгчөө сэрэмжлэхээс зайлсхийж санаа зовохгүй байгаагаа ямагт ятган харуулж бай. Бусдаар хэт хүрээлүүлэх, бусдад хууртаххаас сэргийлж, цаг ямагт сонор бай. Ши-гийн санааг харцнаасаа бүү алд [Мөн тэнд] гэх мэт байна. Иймэрхүү стратегийг орчин үеийн цэргийн мэргэжилтнүүд хуучин судар, сургаалиасаа уудлан гаргаж байна. Үүнээс харвал Хятад улс эдийн засгийн болон орчин үеийн бусад асуудлыг **хуучин аргаар** шийдвэрлэж болно хэмээн үзэж байх шиг. Сунь Цы, Күнз болон бусад сэтгэгч, цэргийн жанжин нарын судар бичгийг эрчимтэйгээр дахин хэвлэж тодорхой хүрээнийхэнд зориулж байгаа нь цэргийн зэвсэг, хүчээ зузаатгахад ч хувь нэмэр болж байна.

БНХАУ-ын Коммунист намын 19 дүгээр их хурлаас Хятадад түүний онцлогтой социализм байгуулах тухай асуудлыг онолын түвшинд бататгаад зогсоогүй Си Зиньпинийн онолыг намын дүрмэнд оруулан түүнийг дараагийн үеийн удирдагчийн түвшинд аваачлаа. Энэ бол 100 жилийн марафонд ялалт байгуулахад **нэг удирдагч** буюу автократ удирдлага нэн чухал болохыг харууллаа.

Хятадын эдийн засаг удааширч байгаа хэдий ч дэлхийн хамгийн өсөлттэй эдийн засгийн нэг хэвээрээ байна. Түүний жилийн дундач өсөлт 6.5 хувиас доош орохгүй байгаа нь үүнийг гэрчилнэ. Гэвч байгаль орчны бохирдол, эдийн засгийн хүч чадлын дутуу ашиглалт, эрчим хүчний дутагдал, усан болон хуурай замын хязгаарлалт зэрэг нь түүний экспорт, импортод бэрхшээл учруулсаар байна. Үүнийг чадвал арилгах, наандаж зөөлрүүлэх арга нь Евразийн бүс болоод Европт нэвтрэх саадгүй гарцуудыг бий болгоход оршиж байна.

Ийм учраас БНХАУ-ын дарга Си Зиньпин 2013 онд Казахстанд айлчлах үеэрээ “Торгоны замын эдийн засгийн бүс” хэмээх бодлогоо Астанад зарласан байна. Тэхдээ энэхүү төслийг хэрэгжүүлэх “бодит харилцан ажиллагаа”, “улс төрийн яриа хэлэлцээ, газар нутгийн хил залгаа байдал, эдийн засгийн харилцан нөхөх чадварыг хамтран ажиллах, тогтвортой хөгжин, харилцан ашигтай байдалд суурилан нийтлэг ашиг сонирхол, нийтийн үр ашиг бий болгоход ашиглах шаардлагатай байгааг” цохон тэмдэглэжээ.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн даалгавраар 2015 онд “XXI зууны Торгоны зам болон Далайн торгоны замын эдийн засгийн бүс хамтран байгуулах сайхан ирээдүй ба бодит үйл ажиллагаа” хэмээх бичиг баримт гаргав. Энэхүү баримт бичиг “Нэг бүс-нэг зам” төслийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилготой байв. Энд зааснаар бол “Нэг бүс-нэг зам” төсөл бүх орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагад нээлттэй бөгөөд түүнчлэн БНХАУ сонирхогч орнуудтай эдийн засгийн талаар хамтран ажиллах суурь болох ёстой аж.

“Торгоны замын эдийн засгийн бүс” ийн үндсэн чиглэл нь:

- Хятадаас Төв Азиар дайрч Оросоор дамжин Европ, Балтийн тэнгис хүрэх,
- Хятадаас гарч Төв Ази, Баруун Азиар дамжин Персийн булан, Газар дундын тэнгис хүрэх,
- Хятадаас Зүүн өмнөт Ази, Өмнөт Ази, Энэтхэгийн далай хүрэх юм байна


Харин XXI зууны далайн торгоны зам:

- Хятадын далайн боомтуудаас Өмнөт Хятадын тэнгисээр дамжин Энэтхэгийн далай, цаашаа Европ хүртэл.
- Хятадын далайн боомтуудаас Өмнөт Хятадын тэнгисээр дамжин Номхон далайн өмнөт хэсэг хүрэх зам аж.

Энэхүү чиглэлийн хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааны 6 олон улсын коридор байгуулах юм. Үүнд:

- ✓ Хятад-Монгол-Оросын коридор.
- ✓ Хятад-Төв Ази-Баруун Азийн коридор.
- ✓ Хятад-Энэтхэг хятадын коридор.
- ✓ Хятад-Пакистанын коридор.
- ✓ Бангладеш-Энэтхэг-Мьянмар-Хятадын коридор орно.

Эдийн засгийн зоридоруудыг Зураг 1-ээс харна уу?



Зураг 1. Хятадын эдийн засгийн коридорууд

Хятадын “Нэг бүс-Нэг зам” санаачлага 60 гаруй орныг хамарсан 113 тэрбум долларын хөрөнгө оруулалт бүхий асар том төсөл бөгөөд одоо байгаа дэд бүтцийг сайжруулах болон шинээр барьж байгуулахыг зорилготой байна. Түүнийг санхүүжүүлэх зорилгоор 100 тэрбум долларын гарааны капитал хөрөнгөтэй Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, 10

тэрбум долларын анхны капиталтай Торгоны замын сан байгуулаад байна.

Энэ оны 5 дугаар сард Бээжин хотноо болж өнгөрсөн “Нэг бүс-Нэг зам” форум дээр Си Зиньпин хэлэхдээ “Бид энэхүү төслийн дөнгөж эхэнд байгаа ч түүний шинэ аялалд хамтдаа гарахад бэлэн байна” гээд “нийтлэг алсын хараандаа хүрэхийн тулд ухралгүй, зогсолгүй урагшилж чадвал бид хоорондоо илүү их холбогдож, бие биесийн хөгжлөөс илүү их үр ашиг хүртэх болно” гээд “цагаан галуу салхи, шуургыг сөрөн алс хол, аюул осолгүй нисч чаддаг нь хошууран нисч бие биедээ туслан нэг баг болдогт байдаг” [4] хэмээсэн нь хамтын ажиллагаагаар дамжуулан тохиолдох арцалдааныг туулж, илүү сайн хөгжиж болно гэсэн дохио өгчээ.

Гэвч энэхүү төсөл нь Хятадаас гадна холбогдох бусад орнуудаас ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардах юм. Зарим тооцоогоор 3-8 их наяд долларын хөрөнгө оруулалт шаардана гэж байгаа бол Дэлхийн тэтгэврийн зөвлөлийн мэргэжилтнүүдийн тооцоогоор ойрын 10 жилд 900 тэрбум доллар шаардагдана гэж үзжээ. Үүнээс харвал Хятад хөрөнгө оруулалт хийлээ ч гэсэн энэ төсөлд хамрагдах орон бүр **өндөр өртөг** төлөх бөгөөд тэр нь тухайн оронд ихэнхдээ өр болон үлдэх өндөр эрсдэлтэй юм.

Түүнчлэн БНХАУ бол энхийн цагаан тагтаа хараахан биш. Бүс нутагтаа нутаг дэвсгэрийн маргаантайн дээр Хойт Солонгосын асуудал бол үнэхээр хоолойд нь тээгэлсэн яс болоод байна. Түүний дээр АНУ, Япон зэрэг барууны орнууд Хятадын хүчирхэгжилтэд дуртай бус байгааг дурдах нь зүйтэй. БНХАУ ОХУ-тай стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж байгаа хэдий ч, ялангуяа Төв Ази, Баруун Азид, **далд өрсөлдөх** шинжтэй байгааг шинжээчид нэг бус удаа дурьдаж байна. Эцэст нь Хятад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулж босгосон эдийн засгийн хонгилоо хамгаалалтгүй орхино гэдэг нь магадлал багатай юм. Зарим эх сурвалжийн дурьдаж байгаагаар одоо яригдаж байгаа эдийн засгийн 6 хонгилын хүрээнд 5000 гаруй цэргийн мэргэжилтнүүд “барилгын ажилчин” нэрээр үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор Монгол Улс ч багтаж байгаа юм байна [3].

Энэхүү санаачлагын хүрээний төслүүдийг хэрэгжүүлэхэд 32 жил хэрэгтэй гэж байгаа ба 2049 онд буюу БНХАУ-ыг байгуулсны 100 жилийн ойгоор дуусгана хэмээн үзэж байна. “Хятадын 100 жилийн марафон” ийнхүү үргэлжилнэ.

2.2. *Оросын Холбооны Улсын эдийн засгийн сэрэгэлт хийгээд ганцаардал, дорно зүг харах хүсэл, хясал*


ОХУ-ын үндэсний баялаг XXI-ны эхэнд 340-380 их наяд доллароор үнэлэгдсэн байна [4]. Гэтэл нэг талаас ЕХ-ы эдийн засгийн үйл ажиллагаа ОХУ-ын оролцоогүй шахам (нефть, газаас бусад) өрнөж, нөгөө талаас Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаанд тийм ч их нөлөөтэй оролцож чадахгүй байна. Үүний дээр АНУ тэргүүтэй барууны орнуудын эдийн засгийн хориг арга хэмжээ Оросын эдийн засагт ихээхэн хүндрэл учруулж байна. Ийнхүү гаж гэмээр нөхцөл байдал үүсээд байна. Юу гэвэл Европт ч, Азид ч бодитойгоор оршдог, тэдгээрт амин чухал ашиг сонирхол бүхий Орос улс хамтын ажиллаганы замд амжилт олж байгаа **өөрийнхээ хөршүүдээс тодорхой хэмжээгээр тусгаарлагдаад** байна [Мөн тэнд].

ОХУ-ын бүс нутгийн хөгжил тэнцвэртэй бус байна. Хүн амын суурьшил, нягтрал Уралаас зүүн тийш маш сийрэг байхад түүнээс баруун тийш өндөр нягтралтай, дүрвэгсэд, шилжих хөдөлгөөн ихтэй байна. Энэ үзэгдэл Украйны үйл ядлаас хойш улам нэмэгдэв. Цэргийн бус салбарт аж үйлдвэрлэлийн хөгжил сул, холбогдох чадвар дорой байна. Өмнө дурьдсан болон бусад хүчин зүйлээс үүдэн ОХУ эдийн засгийн бодлогоо дорно зүг эргүүлж, тухайлбал, Евразийн бодлогоо идэвхижүүлэх шинжтэй байна.

Энэ чиглэлд хийсэн анхны томоохон алхам бол “Гаалийн холбоо, эдийн засгийн нэгдсэн орон зай” хэмээх Орос-Беларусь-Казахстаныг хамтарсан холбоог 2010 онд байгуулсан явдал юм. Гаалийн холбооны гэрээ хүчин төгөлдөр болмогц Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн дээд хэмжээний уулзалт зохион байгуулж, Беларусь, Казахстан, Оросын эдийн засгийн нэгдсэн орон зайн хүрээнд Евразийн эдийн засгийн холбоо байгуулах шийдвэр гаргажээ. Энэ холбоонд өмнөх гурван орноос гадна Армени, Киргиз улсууд шинээр гишүүн болсноор 5 улсыг хамарч байна. Монгол Улс тус холбоонд ажиглагчийн эрхтэй оролцож, чөлөөт худалдааны бүс байгуулах, улмаар уг холбоонд элсэх тухай асуудлыг хэлэлцэж байна. Уг холбоонд одоо 7 орон ажиглагчийн эрхтэй оролцдог бөгөөд 50 гаруй орон нэгдэх хүсэлтэй байгаагаа илэрхийлээд байна.

Уг холбоог байгуулсан цагаас эхлэн түүний үндсэн зорилго нь Азийг Европтой холбох эцсийн зорилго бүхий Хятадын “Нэг бүс-Нэг зам” санаачлагтай шүргэлцэж ирсэн юм. Тиймээс уг холбоо бүс нутгийн энэхүү төсөлд нэгдэх боломж илүү харагдаж байгаа хэдий ч зарим талаараа Оросын хувьд санаа зовоох асуудал юм.


Үүний нэг илрэл нь ОХУ Транс-Евразийн бүсийн “Развитие” хэмээх төслийг 2015 онд зарласан явдал юм. Энэ төслөөр бол өндөр хурдны 40 мянган км төмөр зам, 120 мянган км авто зам, 23 мянган км шилэн кабель тавих аж. Ингэснээр ирэх 20 жилд шинээр 20 000 ажлын байр бий болгоно гэж үзжээ.



Зураг 2. ОХУ-ын Транс-Евразийн бүсийн “Развитие” төсөл

Энэхүү төсөл стратегийн хоёр том зорилт агуулж байгаа аж. Нэгдүгээрт, Европыг зүүн Азитай холбох дамжин өнгөрүүлэх (транзит) хонгил байгуулах, хоёрдугаарт, Оросын аж үйлдвэрийн эдийн засгийн хөгжлийн коридорийн сүлжээ байгуулж, хөгжүүлэх явдал юм байна [6].

ОХУ-ын нөгөө нэг чухал төсөл бол эдийн засгийнхаа дотоод холбогдолтыг сайжруулахад чиглэсэн дэд бүтцийн төсөл юм. Энэхүү төслийн хүрээнд дор дурьдсан шугам хонгилуудыг байгуулах ажээ.



Зураг 3. ОХУ-ын бүс хооронд холбогдох дэд бүтцийн төсөл

Цайвар ягаан: Ливантын шугам. Энэ нь далайн тээврийн шугам бөгөөд Крымыг Тартус, Синайтай холбох бөгөөд Жибути хүртэл өргөжүүлж, 100 сая хүнтэй арабын зах зээлд хүрэх боломжтой.

Хүрэн: Умард- Өмнөдийн коридор. Мумбайгаас гарах ачааг Москва хүргэх, замдаа Иран, Азербайжаныг дайран гарна. Цаашдаа зүүн Европ хүрэх боломжтой.

Ягаан: Евразийн эх газрын шугам. Хятадаас Санкт Петербург хүрэх хурдан галт тэрэгний зам.

Улаан шар: Төв Азийн коридор. Казань-Новосибирск-Ташкентийн зам. Цаашдаа Төв Азийн орнууд хүрэх боломжтой.

Хар: Транс-Сибирийн төмөр зам. Европыг Азитай холбодог хамгийн олон жил ажиллаж байгаа төмөр замын шугам.

Ногоон: Алтайн эрчим хүч, усны коридор. Алтайгаас Шинжаны Үрэмч хүртэл эрчим хүч, ус дамжуулах хоолойн шугам.

Чернилэн ягаан: Байгалиас Улаан-Үүд, Улаанбаатараар дамжин Бохайн булан хүрэх төмөр зам.

Хөх: Азийн тэнгисийн замын нум.

Улаан: Солонгосын хойгийн коридор.

Шар: Хойт тэнгисийн усан зам.

Шар ногоон: Тикигээс Тикши хүрэх зам.

Хэдийгээр эдгээр төслүүд хэтийн төлвийн шинж чанартай ч гэсэн эдийн засгийн өсөлт бараг байхгүй, нефть, хийн үнэ тогтвортой бус,

барууны орнуудын эдийн засгийн хориг үргэлжилсээр байгаа нөхцөлд тэдгээрийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байх болно. Мөн ЕАХ-ны үйл ажиллагаа тогтворжиж, харилцан бүрэн үр ашигтай болоогүй байна. Түүний зэрэгцээ Төв Азийн орнуудад Хятадтай хамтран ажиллах үйл явц Оросын хяналтын дор явагдахгүй байгаа нь түүний санааг зовоож байна [7].

ОХУ Төв Азийн орнуудтай хүмүүнлэгийн болон цэрэг-улс төрийн салбарт нягт холбоотой ажилладаг хэвээрээ байна. Үүний нэг жишээ бол ОХУ-ын цэргийн бааз Тажикстан, Киргизэд байдаг бөгөөд энэ гурван улс Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ОДКБ)-ын гишүүн юм. Гэтэл эдгээр орнуудад Хятадын эдийн засаг, улс төрийн нөлөө өсөн нэмэгдэж байна. Энэ нь Оросын оролцоотойгоор санаачилсан Евразийн хамтын интеграцийн үйл ажиллагааг Бээжингийн санаачлага шууд хөндөж байна хэмээн оросын тал үзэж байна. Түүгээр ч барахгүй Москва болон Бээжингийн санаачилсан интеграцийн төслүүд ихэнхдээ хоорондоо өрсөлдөх шинжтэй байна [5]. ЕАЭЗХ болон Хятадын хооронд чөлөөт худалдааны бүс байгуулах асуудалд уг холбоо болгоомжтой, түүгээр ч барахгүй хүйтэн хандаж байгаа нь тохиолдлын зүйл биш билээ.

Нөгөө нэг хүчин зүйл нь ЕАЭЗХ олон улсын байгууллага бөгөөд ихээхэн зохион байгуулалттай хүнд суртал ихтэй байгууллага юм. Гэтэл Хятадын интеграцийн санаачлагуудад байгууллагажсан, хуульчилсан зохион байгуулалт бараг байхгүй. Ийм учраас Хятадын санаачлага өрсөлдөх чадвар сайтай байна. Түүнчлэн Евразийн эдийн засгийн холбоо Шинэ торгоны замын эдийн засгийн бүсийн санхүүгийн эх үүсвэрийн дэргэд даруухан тоогоор илэрхийлэгдэнэ. Иймээс төслүүдээ дэмжих мөнгөн эх үүсвэр багатай юм.

Гагцхүү Хятадтай хил залгаа орнууд, ялангуяа Төв Азийн орнууд, эдийн засгаа өөрсдөө бие дааж хөгжүүлэх сонирхолтой байна. Үүний улмаас улам бүр нэмэгдэж байгаа Бээжингийн улс төр, эдийн засгийн нөлөөг тэнцвэржүүлэх зорилгоор өөр томоохон тоглогчийн оролцоог нэмэгдүүлэх бодолтой аж. Түүгээр ч барахгүй Төв Азийн орнуудад хятадыг үзэн ядах (синофобия) үзэл газар авч байна. Ийм нөхцөл байдлыг ОХУ хэрхэн ашиглахаас Хятад-Оросын харилцаа ихээхэн шалтгаална.

Ийнхүү ОХУ Евразийн тавцан дахь их гүрэн байх эсэх нь хожмын өдөр харагдах бизээ.

3. *“Нэг бүс-Нэг зам” төсөл дэх Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын ач холбогдол*

3.1. *Түгжигдмэл Монгол Улс, эдийн засгийн байдал*

Их эзэн богдын өвийг уламжлах ёстой байсан Монгол Улс тусгаар тогтнолоо дахин тунхагласнаас хойш бараг зуун жил болох гэж байна. Хорьдугаар зууны эхэнд гарсан хувьсгалын нөлөөгөөр тус улс хоёр их гүрэн ОХУ, Хятадын хооронд байрлах **газарзүйн хувьд хаагдмал орон** болж үлдсэн юм. Энэ нь тус улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн дарамт болдгийн дээр улс төр, эдийн засгийн олон хувилбарт бодлого, үйл ажиллагаа явуулахад хүргэдэг өртөг зардал өндөртэй, үр нөлөө нь хязгаартай асуудал билээ.

Нутаг дэвсгэрийн газарзүйн мөн чанар өөрт нь тулгаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадаж байвал тэр улс гүрэн амьдрах чадвартай байдаг аж [3]. Үүнээс харвал манай улсын газар зүйн байршил бидэнд стратегийн ямар асуудал тулгаж байна вэ? Энэ нь **нэгдүгээрт**, эдийн засгийн орон зайгаа тэлэх, **хоёрдугаарт**, улс төрийн харилцааны хил хязгаарыг өргөтгөх, **гуравдугаарт**, хоёр их хөршийн газар нутгаар дамжин газар зүйн саад бэрхшээлийг даван туулахыг шаардаж байна.

Үүнээс харвал бидний явуулж байгаа “гуравдах хөрш”-ийн бодлого үр ашиг муутай байна. Энэхүү бодлогын улмаас хоёр хөрштэйгээ зай барьж, бусдын зээл тусламжинд дулдуйдсан, эдийн засгийн өсөлтийг хангаж чаддаггүй бодлоготой орон болоод байна. Гэвч, энд гуравдах хөршийн бодлогыг дэмжих гол хөшүүрэг нь хоёр хөрштэй явуулах эдийн засгийн төрөл бүрийн харилцаа, улс төрийн итгэлцэл, эдийн засгийн хоёр ба гурван талын хамтын ажиллагаа, түүгээр дамжуулан олон талын хамтын ажиллагааг эдийн засагтаа хэвшүүлэн явуулах явдал юм. Энэ тухай АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бэйкерийн бидэнд сануулж байсныг эргэн санах нь зүйтэй.

Манай улс дэлхийн 200-гаад улс дотор дундаас доош орлоготой орны тоонд багтаж, хүн амынх нь бараг 40 хувь нь ядууралд өртөөд байна. Ялангуяа, сүүлийн 10-аад жилд, 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас хойш, эдийн засгийн байдал уналтад орлоо. Энэ нь дотоод гадаадын олон төрлийн хүчин зүйлээс шалтгаалж байгаа ч гэсэн бид сүүлийн 30 орчим жилд эдийн засгийн хувьд ерөнхийдөө ядуу орны тоонд ордог хэвээрээ байна.

Монгол Улс дотооддоо дэд бүтцийнхээ асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна. Аймгийн төвүүдийг холбосон хатуу хучилттай авто зам барих, төмөр замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, шинэ төмөр зам барих, эрчим хүчний шинэ эх үүсвэр барих, эрчим хүчний чадлыг тогтворжуулах

зэрэг ажилд урагш ахих нь удаан, зарим талаар үргэлжилсэн их ярианаас хэтрээгүй байна.



Зураг 4. Монголын төмөр замын сүлжээг хөгжүүлэх бодлого

Дээр дурьдсан хүндрэл бэрхшээл, стратегийн зорилтоос харвал Монгол улс Евразийн тавцанд эдийн засгийн хамтын ажиллагааны шийдвэртэй алхам хийх нь зайлшгүй болж байна. Үүний эхний бөгөөд шийдвэрлэх алхам нь “Нэг бүс-Нэг” зам төслийн хүрээнд “Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” төслийг амжилттай хэрэгжүүлэх явдал байж магадгүй.

Гэвч энэ нь хөрш хоёр орон “түлхүүр гардуулах” зарчмаар Монголд зүгээр хийгээд өгчих ажил биш бөгөөд энэ төслийг хэрэгжүүлэх ажилд хөрөнгө хүч ихээхэн шаардагдах болно.

Гурван орны төрийн тэргүүн нарын Ташкентэд 2016 онд тохирсон ёсоор бол бүс нутгийн дэд бүтэц, гурван улсын худалдаа, эдийн засгийн харилцааг тэтгэн дэмжих зорилготой Хятад-Монгол-Оросын эдийн засгийн хонгил (коридор) байгуулагдана. Энэ хүрээнд дэд бүтэц, түүний логиستيкийг хамарсан 32 төсөл хэрэгжүүлэх аж. Эдгээрээс товч дурдвал:

- Улаан-Үүдээс Тянжин хүртлэх хос замтай төмөр замын шугам барих
- Кызылээс Тянжин хүртлэх болон Үрэмч хүрэх баруун чиглэлийн төмөр зам.
- Боржоос Соловьевск, Чойбалсанг дайрч Жиньжоу орох зүүн бүсийн төмөр зам.
- Азийн хурдны авто зам АНЗ-ын Монгол дахь хэсгийг барих.

- Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг Хятад, Орост байгуулж аж үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт үндсэн төслүүдийн зэрэгцээ хил, гааль, хяналт, хүн, мал эмнэлгийн харилцааг зохицуулах төслүүд оржээ.

Эдгээр төслийн амьдрах чадварыг турших зорилгоор зарим нэг туршилт ч хийсэн байна. Тухайлбал, олон улсын авто замаар ачаа тээвэрлэх TIR тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Тянжинээс Улаан-Үүд хүртэл энэ тогтолцоонд тохирсон авто хөсгөөр тээвэр хийсэн байна. Энэ талаар олон улсын IRU байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Умберто де Претто “Азийн авто замын сүлжээг бэхжүүлснээр Монголын худалдааны потенциал бүс нутгийн тогтвортой хөгжилд илүү стратегийн шинжтэй болно. Хятадтай TIR тогтолцоог нэвтрүүлснээр бүс нутгийн холбогдох чадвар мэдэгдэхүйц сайжирч, ингэснээрээ эдийн засгийн илүү их өсөлт бий болгоно” гэжээ.

Одоогоор эдгээр төслийн аль нь ч эхлээгүй байгаа ба зөвхөн хэлэлцээрийн болоод судалгааны шатанд байна. Гэтэл энэ хооронд сонирхогч талуудын стратеги өөрчлөгдөж болох юм. Тухайлбал, ОХУ Алс Дорнодыг хөгжүүлэх чиглэлд онцгой анхаарч байгаатай уялдан манай төмөр замтай Манжуурын төмөр зам өрсөлдөж болно.

Нөгөө талаар, гурван улсын төсөлд хэт анхаарсны уршгаар дотоодын тээврийн тогтолцоог хөгжүүлэх асуудал хоцорч хожимоо эдийн засгийн өсөлт, хөгжилд чөдөр тушаа болох магадлалтай. АНУ-ын Индианагийн их сургуулийн профессор Алиша Кэмпи “Монгол Улсад урагшаа хөдлөхийн өмнө дотооддоо шийдвэрлэх олон асуудал байгаа хэмээн үнэлж байгаа ч үнэн билээ” гэжээ.

3.2. *“Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор” дахь Монгол Улсын ашиг сонирхол*

Дээрхи төслүүдийг хэрэгжүүлэх явцад баримталбал зохих манай үндэсний хамгийн том ашиг сонирхол бол *газар зүйн хаагдмал байдлаас* гарах явдал мөн. Үүнийг шийдвэрлэх, цорын ганц ч байж магадгүй, ухаалаг арга зам бол бүс нутгийн эдийн засгийн интеграцид тодорхой стратегийн зорилго, зорилттой оролцох явдал юм. Бид эхлээд хоёр хөршийн эдийн засаг, худалдааны өсөн нэмэгдэх харилцааг түшиглэж ашигтай ажиллах ёстой. Ингэхийн тулд Монгол Улс *улс төрийн* нөлөөллөө өргөжүүлэх нь зүйтэй. Тиймээс Евразийн холбооны болон ШХАБ-ын гишүүн болох асуудлыг бид нухацтай авч үзэж, түүнийг жингийн туухай дээр тавиж үзэх, цэгнэх нь

зүйтэй юм. Дараагийн асуудал нь *зах зээлийнхээ хүрээг* тэлэх явдал байна. Ингэхийн тулд дотооддоо экспортын барааны төрөл зүйлийг нэмэгдүүлж, экспорт, импортынхоо орон зайг тэлэх учиртай. Үүнийг шийдвэрлэхэд л бүс нутагтай *холбогдох чадвар* өндөр ач холбогдолтой юм. Ийм учраас хоёр хөршийн бодит дэд бүтцэд өөрийн орны дэд бүтцийг хүрэлцээтэй бөгөөд ашигтай байхаар холбох учиртай болж байна. Бас бид гурав дахь хөрш рүү хязгаарлалтгүй нэвтэрч байхын тулд хоёр хөршийн *итгэлийг* олж авах хэрэгтэй болно. Энэ нь, магадгүй, евразийн улс төрийн харилцаанд бодитой оролцох замаар олж авах манай газарзүйн бодлогын эцсийн зорилго байж болно.

Хоёр хөршийн үндэсний болоод худалдаа, эдийн засгийн *ашиг сонирхолын тэнцвэрийг* хангах нь манай үндэсний ашиг сонирхолын нэг мөн. Одоо бид гадаад худалдааныхаа бараг 70 хувийг зөвхөн Хятадтай хийж байгаа бол нефть бүтээгдэхүүний 70 хувийг ОХУ-аас авч байгаа нь хамаарал ихтэй байгааг харуулна. Зөвхөн 2016 онд хийсэн экспортын 79.4%-ийг БНХАУ-тай хийсэн худалдаа эзэлж байгаа бол ОХУ-тай хийсэн худалдаа хятадтай хийсэн нийт худалдаанаас 69 дахин бага байгаа боловч нефть бүтээгдэхүүний 60 орчим хувийг тэндээс нийлүүлсэн байна [Гадаад худалдаа 2016, Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Улаанбаатар хот, 2017он]. Энэ бол бид хөрш хоёр орны аль алинаас нь бүрэн хамааралтай байгааг харуулж байна. Энэ талыг арилгах практик жишээ нь өөрийн нутгаас олборлосон нефтийг Хятадад гаргаж, олсон мөнгөөрөө Орсоос түүхий нефть импортлон нэрж, өөрийн хэрэгцээг хангах боломж байж болох юм. Энд өөрийн нефтэд суурилсан боловсруулах үйлдвэр нь дамжуулах хоолой байгуулж өртөг зардал өндөржүүлэх хүчин зүйл агуулдаг учраас ийм арга хэмжээ манайд ашигтай, хоёр хөршийн ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх үйл ажиллагаа болохсон билээ.

Эдийн засгийн бие даасан байдлыг хангах нь манай үндэсний эрх ашгийн тулгамдсан асуудал мөн. Дотооддоо эрчим хүчний найдвартай бөгөөд хүрэлцээтэй, өөрийгээ тохируулах чадвартай тогтолцоо бий болгох нь бодит дэд бүтэц, аж үйлдвэрлэл, хөдөө аж ахуй хийгээд бусад салбар хөгжих үндсэн хүчин зүйл болно. Энд шинэ хүчин чадал бий болгохдоо сэргээгдэх эрчим хүч, тухайлбал, усан цахилгаан станц байгуулах асуудлыг тэргүүн ээлжинд авч үзвэл зохино. Шатдаг хийн түлшинд суурилсан цахилгааны эх үүсвэрийг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн байгаль орчинд тавих шаардлагатай уялдуулан хөгжүүлэх хэрэгтэй байж болох юм.

Эдийн засгийн бодит дэд бүтэц барьж байгуулахдаа дотоодын

болон экспортын хэрэгцээг хангах аж үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй нягт уялдуулах шаардлагатай. Тухайлбал, зөвхөн эрдэс түүхий эд бус, түүнчлэн малын гаралтай бүтээгдэхүүн экспортлох эрэлт хэрэгцээ нэгэнт бий болсонтой уялдуулж мал төхөөрөх, мах, ноос, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг дэд бүтцэд хэрхэн холбох, малын тэжээл хэрхэн тээвэрлэж хүргэх зэрэг асуудлыг тооцох хэрэгтэй болно.

Өрийн хэт дарамтад орохгүй байх нь амин чухал. Гурван улс дамнасан эдийн засгийн коридорт хэрэгжүүлэх төслүүд манай эдийн засаг бараг даахгүй хэмжээний хөрөнгө оруулалт шаардах болно. Тухайлбал, зөвхөн Наушкаас Замын үүд хүртлэх төмөр замын шинэчлэл зарим нэг тооцоогоор 5-аас дээш тэрбум долларт хүрэх төлөвтэй гэнэ. Иймээс гадаад эх үүсвэртэй зээл ашиглах асуудал тавигдах байх. Ийм төсөл хэдэн арав байна. Тийм учраас санхүүгийн өөрийн эх үүсвэр бий болгох талд онцгой анхаарах ёстой. Ийм эх үүсвэрт ачаа дамжуулан өнгөрөөсний төлбөр хураамж, уул уурхайгаас орох орлогоос гадна экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг бий болгож түүний бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд зохистой байршуулах ажил хийгдэх нь зайлшгүй болно. Үүнийг бид зохистой хэмжээнд аж үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн түүхий эдийг бүрэн боловсруулж, бүтээгдэхүүн болгон гаргах явдал хэмээн үзэж байна. Эцсийн эцэстээ эдгээр төслүүд манай үндэсний ашиг сонирхолын үндэс болох *монголын ард түмний аж байдлыг дээшлүүлж*, тэдний хөгжих таатай нөхцлийг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх нь гол хэмжүүр байх болно.

ДҮГНЭЛТ БУЮУ ТӨГСГӨЛИЙН ҮГ

Евразийн бүс нутгийн эдийн засгийн тавцан дээр БНХАУ болон ОХУ гэсэн хоёр их гүрний тоглолт эхлэж байна. Үүнтэй уялдаад Евразийн холбоо хэмээх олон улсын байгууллага, Эдийн засгийн шинэ тогоны зам хэмээх Хятадын төсөл хооронд өрсөлдөөн өрнөх төлөвтэй. Энэ хүрээнд хэрэгжүүлэх түүний “Нэг бүс-Нэг зам” санаачлага бүс нутгийн орнуудын сонирхолыг татаж байгаагийн дээр түүний хүрээнд хэрэгжүүлэх эдийн засгийн 6 коридорын төсөл ихээхэн ач холбогдолтой юм. Ялангуяа, манай улс газарзүйн түгжигдмэл байдлаасаа гарч, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэн тэлэхэд энэ коридор чухал үүрэгтэй байж болох юм. Тиймээс энэ төсөл манай улсын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийн нэг байх боломжтой байна. Гагцхүү үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засгийн бие даасан байдал, зах зээлээ тэлэх зэрэг манай ашиг сонирхолд нийцэж байх ёстой байна.

Ашигласан ном, үгүүллийн зүүлт

1. Robert Kaplan, The return of Marko Polo's World and U.S. Military Response, CNAS, 2017;
2. Трубецкой Н.Наследие Чингис хана, 2007, стр. 307;
3. Michael Pillsbury, The hundred year marathon, 2015, pp 319;
4. Dr. Abdul Ruff. China's New Silk Road Project and South Asia – OpEd, Jun 2, 2017.
5. Наумов В.М. Евроазиатская экономическая стратегия России, 2005;
6. Воробьев А,Один путь: интересы КНР и РФ в центральной Азии, Институт востоковедения АН, РФ, 2017.
7. Covert Geopolitics, April 15, 2015.
8. Andrew Korybko. Immigrant Crisis 2.0: Target Russia, 2017.
9. Helga Zepp-LaRouch. Worldwide Spirit of Optimism over the New Silk Road, April 2017.
10. Alicia Campi. Transforming Mongolia-Russia-China Relations: The Dushanbe Trilateral Summit, 2014.
11. Гадаад худалдаа 2016 онд, Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Улаанбаатар, 2017.

МОНГОЛ-ОРОС-ХЯТАДЫН ТӨМӨР ЗАМЫН ХОЙД КОРИДОР

*Ё.Жаргалсайхан**

2016 оны 6 дугаар сард Ташкентэд болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын уулзалтын үеэр Монгол-Орос-Хятадын дээд удирдлагын түвшинд “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг баталсан билээ. Уг хөтөлбөрийн төслийн жагсаалтад 32 төсөл багтаж байгаагаас төмөр замын хойд коридор / Курагино-Кызыл-Цагаантолгой-Арцсуурь-Овоот-Эрдэнэт-Салхит-Замын-Үүд-Эрээн-Улаанцав-Жанчхүү-Бээжин-Тяньжин/-ын төмөр зам барих төсөл ач холбогдолоороо эхний 2-т багтаж байгаа юм.


Энэхүү төмөр замын хойд коридорын Курагино-Кызыл-Цагаантолгой-Арцсуурь-Овоот-Эрдэнэт хэсэгт төмөр зам огт баригдаагүйгээс гадна Монгол, Оросын хамгийн алслагдсан бөглүү, дэд бүтэц, аж үйлдвэр бараг хөгжөөгүй газар нутагт хамаарч байгаагаараа нилээд онцлог төсөл болох юм. Энэ хэсэгт Монголын талд байгаа гол бүтээн байгуулалт нь Австралийн “Аспайр майнинг” компаниас хэрэгжүүлж буй Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт орших Овоотын чулуун нүүрсний уурхайн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах төмөр замын төсөл юм.

“Аспайр майнинг” компани нь Австрали улсад хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2006 онд анх байгуулагдаж, 2007 онд Австралийн хөрөнгийн биржэд хувьцаагаа гаргаж, санхүүжилт босгосон байдаг. Анх Австрали улсад төвлөрч үйл ажиллагаа явуулж байсан тус компани, 2010-2011 онд үйл ажиллагаагаа манай улсад төвлөрүүлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гол төлөв өмнийн говийг зорьж, ашигт малтмал хайж байхад тус компани манай улсын алс хязгаар нутгаар хайгуул, судалгааны ажил хийн, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт олборлолтын нэг, хайгуулын гурван тусгай зөвшөөрлийг хамарсан 430 хавтгай дөрвөлжин км талбайд нүүрсний хайгуул хийж байгаа.

Одоогоор тус ордод JORC стандартаар 225 сая тонн нүүрс тогтоогоод байгаа ч цаашид нөөц нь нэмэгдэх боломжтой гэгддэг. Энэ ордоос жилд 15 сая тонн нүүрс олборлож хойд болон урд хөршид нийлүүлэхийн зэрэгцээ, баруун Европ, Зүүн хойд Азийн орнуудад төмөр замаар хүргэхээр төлөвлөж байгаа юм. Гэхдээ энэ ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад, төмөр зам юу юунаас илүү чухал болоод байгаа юм. Тиймээс “Аспайр майнинг”

* Доктор /Ph.D./

компани “Эрдэнэтээс-Овоот” хүртэл төмөр зам барьж, эзэмших, ашиглах зориулалт бүхий “Нортерн Рэйлвейс” салбар компани манай улсад байгуулсан байна. Уг салбар компани уг төмөр замын урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаар төмөр замын нийт урт нь 547 км байх бол, хөрөнгө оруулалтад 1.3 тэрбум америк доллар шаардлагатай гэсэн тооцоо гарсан байна. Инженерчлэлийн шийдэл эцэслэн гарсаны дараа бүтээн байгуулалтын ажлыг ойролцоогоо гурван жилийн дотор гүйцэтгэх боломжтой гэж “Нортерн Рэйлвэйс” болон түүний толгой компани “Аспайр майнинг” үзэж байна.



УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д баруун чиглэлийн төмөр замыг ирээдүйд ашиглах ордууд болон байгалийн тогтцыг нь бүс нутгийн хөгжлийн бодлого, хүн амын суурьшилтай уялдуулан авч үзэж нэн даруй төлөвлөх, 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжлүүлэх үндсэн чиглэл”-д “Могойн гол-Эрдэнэт 500 км” төмөр замын ажлыг төсвийн бус эх үүсвэр, концессоор хэрэгжүүлэх, 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-т Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замыг барих төсөл тусгагдсан байдаг. Энэ дагуу “Эрдэнэтээс Овоотын уурхай чиглэлийн төмөр зам төсөл”-ийн концессын гэрээ байгуулагдсан бөгөөд Концессын

гэрээнд төслийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлээр 1.3 тэрбум ам.доллар байх юм. Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор бий болгосон энэ хөрөнгөөр 5 жилийн дотор 547 км төмөр замын ажлыг барьж байгуулах ёстой юм. Концессын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулах юм. Энэ хугацаанд концесс эзэмшигч нь концессын зүйлийг 100 хувь эзэмшиж ашиглах бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болох үед төмөр замын суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх юм байна. Концессын гэрээ байгуулж, дээр дурдсан хугацаанд төмөр замаа баривал, Овоотын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой болох юм.

Эрдэнэт-Овоотын төмөр зам нь Монгол улсын Засгийн газрын “Талын зам” төлөвлөгөөний бүтэц хэсэг бөгөөд үндэсний төмөр замын сүлжээг Эрдэнэт хотоос “Аспайр” компанийн Овоотын коксжих нүүрсний төсөл рүү өргөтгөх, улмаар ОХУ-ын хил рүү Арцсуурийн боомтоор холбох төлөвлөлт болно гэж тус компани үзэж байна. Дараа нь ОХУ-ын Засгийн газар тус төмөр замыг Арцсууриас Транс-Сибирийн төмөр зам руу Кызыл хотын боомтоор холбож, тэгснээр Сибирь болон Монгол улсын хойд бүс нутгийг Хятадтай холбох олон улсын төмөр замын холбоос үүсгэхээр төлөвлөж байна.



Талын зам нь Монгол улсын хойд бүс нутагт төрөл бүрийн үйлдвэрүүд, жижиг, дунд бизнес хөгжих, орон нутгийн эдийн засаг бэхжих болон иргэд, олон нийтэд ач холбогдолтой, шинэ боломжуудыг нээх бөгөөд ОХУ-ын

транзит ачааг Хятадын зах зээлд шууд хүргэх зам болж, Сибирийн өмнөд нутгийн ачааг тээвэрлэх зайг 1,250 хүртэл км-ээр ойртуулах боломжтой хэмээн тооцогдож байна.

Талын зам нь ОХУ, Хятад, Монгол гурван улсын хоорондын болон Ази-Европын эдийн засгийг илүү өргөн хамрах худалдааны хэмжээг нэмэгдүүлэхийн тулд олон улсын Эдийн засгийн коридор байгуулах зорилгоор ОХУ-ын төмөр замын төлөвлөлт, Хятадын Торгоны зам болон Монгол улсын төмөр замын бодлогыг хооронд нь интеграци уялдаатай болгох зорилготой, бүс нутгийн томоохон төлөвлөлтийн бүтэц хэсэг болох юм.

Монгол-Орос-Хятадын дээд удирдлагын түвшинд байгуулсан “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т Тува улсыг Монгол, Хятадаар дамжин Номхон далай, Энэтхэгийн далайд гарах шинэ гарц болох төмөр замын хойд коридор /Курагино-Кызыл-Цагаантолгой-Арцсуурь-Овоот-Эрдэнэт-Салхит-Замын-Үүд-Эрээн-Улаанцав-Жанчхүү-Бээжин-Тяньжин/, баруун коридор /Курагино-Кызыл-Цагаантолгой-Арцсуурь-Ховд-Такишикен-Хами муж-Цонжийн хотхон-Өрөмч/ төслүүд орж байгаа. Энэ нь Оростой харьцангуй алс хязгаар, хөгжлөөр сул Тува Улсыг хөгжүүлэх талаар ОХУ-Засгийн газрын зүгээс гаргаж буй идэвхи санаачлага, томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн тодорхой алхам гэж харж байна. Тийм ч учраас төмөр замын баруун, хойд коридорыг байгуулах төслүүд дэмжигдэж, хэрэгжих магадлал өндөр байна.

Тува Улс нь 300,0 мянга орчим хүн амтай, нийслэл Кызыл хотод 160,0 мянга орчим оршин суугч амьдардаг. Хүн ам сийрэг оршин суудаг, үйлдвэрлэл, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл ч сул хөгжсөн, ажилгүйдэл өндөр, үндсэн үйлдвэрлэл нь мал аж ахуй байна. Байгал орчин сайтай ч газар нутаг нь уулархаг тул автозамын сүлжээг л хөгжүүлсэн. Нисэх буудлын хүчин чадал бага тул өргөтгөлийн ажлыг эхлүүлээд байна. Ахуйн хэрэглээ, бараа, бусад материалыг Абаканаар дамжуулан Красноярскаас татаж авдаг. 2015 оноос визийн хязгаарлалтгүй болсонтой холбогдуулан Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг Монголын томоохон хот болон Монголоор дамжин Хятад руу зорчиж, худалдаа наймаа хийх, амарч зугаалах явдал нилээд өргөн хүрээтэй болж байна.

ОХУ-ын Тува улсын хөгжлийн гол найдлага нь Кызыл орчимд 2700 км² талбайг хамран орших, 20 тэрбум тн-ын нөөц бүхий Улуг-Хемийн коксжих нүүрсний орд гэж үзэж болно. Энэ ордын бараг төв дунд нь Кызыл хот байрладаг. Гол уурхайнууд нь А+В+С1+С2 тогтоогдсон балансын

нөөцөөрөө Кызылээс хойш орших Центральный, баруун талд Ээрбек /97,0 сая тн/, урдуур Каа-Хем /305,0 сая тн/, Элегест /38,0 сая тн/, Межегей /213,0 сая тн/, Восточный уурхайнууд болно. Энэ ордын нүүрсийг анх 1883 онд мэдэж, 1914 оноос гар аргаар ашиглаж эхлээд, 1925 оноос үйлдвэрлэлийн аргаар олборлох болсон. 1951 онд Элегест, 1953 онд Ээрбек, 1960-аад оны үед Чадан, 1970 онд Каа-Хемийн уурхайг нээн ажиллуулж байсан бөгөөд нүүрсээ борлуулах тээвэрлэлтийн асуудлыг шийдэж чадаагүйн улмаас ихэнхдээ алдагдалтай ажиллаж ирсэн байдаг. 1990-ээд оноос хойш зах зээлд шилжиж, хувьцаат компаниуд болсон ч ихэнх нь дампуурч, том компаниудын мэдэлд шилжих болсон. Тухайлбал, Каа-Хемийн уурхай 2010 онд Олег Дерипаскагийн хяналтад байдаг “Тувагийн уул уурхайн компани” НХН-д худалдагдсан байна. Элегестийн уурхайн хяналтын багцыг 2002 онд “Енисейн аж үйлдвэрийн компани” мэдэлдээ оруулсан бөгөөд 2011 онд уг компанийн эзэмшил Игорь Алтушин, Руслан Байсаров нарын “Оросын зэсийн компани”-д шилжсэнээр уурхайн хүчин чадлыг жилд 18,0 сая тн-д хүргэх техник технологийн шинэчлэлийг хийж байна.

Тус улсын хөгжлийн гол бэрхшээл нь дэд бүтцийн сул хөгжил, ялангуяа нүүрсийг тээвэрлэж зах зээлд хүргэх төмөр зам огт хөгжөөгүй тул 2010 оноос Курагино-Кызылын төмөр зам барих төслийг хэрэгжүүлэх санаачлага эхэлсэн байдаг. Гэвч гол санхүүжүүлэгч Межпромбанк санхүүгийн хүндрэлд орсон тул уг төсөл зогсонги байдалд орсон. Уг төмөр зам нь Саяны нурууны өндөр уулсыг нэвтрэх шаардлагатай тул дэлхийн хамгийн өндөр өртөгтэй төсөл болоод байгаа юм. ОХУ болон Тувагийн талын зарим мэдээллээр Курагино-Кызылын төмөр замын төслийн санхүүжилтийг 2017 онд шийдвэрлэж, барилгын ажлыг эхлүүлэх яриа гарч байгаа боловч уг төмөр зам ашиглалтад орсон ч коксжих нүүрсний хэрэглээний зах зээлд хүрэх зам нь хол тул Монголоор дамжих тээврийн коридорын ач холбогдол өндөр байх юм.




Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува улсын Эдийн засгийн яамны захиалгаар Оросын Холбооны Улсын Шинжлэх ухааны академийн Сибирьдэх салбар “Байгалийн нөөцийг цогцоор ашиглах Тувагийн хүрээлэн” хэмээх холбооны төсөвт үйлдвэрийн газраас 2014 онд “Улуг-Хемийн чулуун нүүрсийн ордын ашиглалттай уялдуулсан Кызыл-Өрөмч олон улсын төмөр замын барилгын ажил” хөрөнгө оруулалтын төслийн санхүү, эдийн засгийн үндэслэлийг судалсан байдаг. Уг тооцооллоор ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улсын Кызылээс Монгол улсын нутгаар дамжуулан БНХАУ-ын Өрөмч хүртэл нийт 1810 км урт төмөр зам барих төслийг хэрэгжүүлэх нь Тувагийн болон бүс нутгийн хөгжилд эдийн засгийн төдийгүй нийгмийн чухал ач холбогдолтой гэсэн дүгнэлт гаргасан байдаг байна.

Оросын талд Тувагийн Улуг-Хемийн нүүрсний сав газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад Монгол улсын баруун бүс нутгаар дайрсан төмөр замыг байгуулах асуудлыг судалж үзэх хандлага байдаг ч эхэлж Кызылыг хойд зүгт Транссибирийн төмөр замтай холбосны дараагаар Кызылээс урагш Монголын тал руу төмөр зам барих бодлого, чиглэл ажиглагддаг.

Кызылээс Овооттой төмөр замаар холбогдсон тохиолдолд Тувагаас наад зах нь 30,0-50,0 сая тн нүүрсийг жилдээ Монголын нутгаар дамжуулан Хятадын зах зээл болон далайн боомтоор дамжуулан бусад орнуудад гаргах хэрэгцээ шаардлага бий болно.

Тэгэхээр Овоот-Эрдэнэтийн төмөр зам нь “Аспайр майнинг” компанийн 15,0 сая тн нүүрс дээр Тувагийн Улуг Хемийн ордын бүтээгдэхүүнийг нийлүүлээд жилдээ наад зах нь 50,0 сая тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай төмөр зам барих шаардлагатай болно гэсэн үг юм.



¹ Western endpoint of broad gauge track

Овоот-Эрдэнэтийн төмөр зам нь УБТЗ-ын Эрдэнэт өртөөнд холбогдоход тодорхой бэрхшээл гарч байсныг ЗТЯ, УБТЗ-ын ажлын хэсэг гарч ажиллан, үндсэнд нь шийдвэрлэсэн байна. Гэхдээ Салхит-Эрдэнэтийн төмөр зам нь налуугийн өндөржилт, тахир тойруу ихтэй, тээх нэвтрүүлэх хүчин чадал нь жилд 7,0 сая тн-оос хэтэрч чадахгүй тул хүчин чадлыг наад зах нь 20,0-30,0 сая, Оросын талын ачааллыг нэмэхээр 50,0 сая тн-д хүргэж нэмэгдүүлэх техник-технологи, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.

Тус компаниас Эрдэнэт-Овоотын төмөр замын бүтээн байгуулалтын үр ашгийг нэмэгдүүлж, сайжруулахын тулд Төмөр замын хойд коридорыг байгуулах төслийн хүрээнд урьдчилсан судалгааны (2015 оны 9 сар) үр дүнд Кызыл – Арц Суурийн хооронд 300-330 км-ийн урттай хэд хэдэн боломжит чигийн хувилбарыг тодорхойлсон байна. Төмөр зам барилга угсралтын зардал 675-775 сая ам.долларын хооронд хэлбэлзэх бөгөөд үүн дээр зарим тооцоолоогүй зардал нэмэгдэх магадлалтай гэж үзсэн байна.

“Нортерн Рэйлвейс” компаниас 2016 оны 10-р сард хийсэн судалгаанд төмөр замын хойд коридор нь Москва, Европ болон Бээжин, Тянжиний хооронд хийгдэх худалдаа, тээвэрлэлтийн хамгийн дөт, өртөг зардал хямд чиглэл болох тухай тодорхойлсон байна. Төмөр замын хойд коридор нь Улаанбаатар төмөр замын гол шугамтай холбогдсоноор Сүхбаатар-Улаанбаатарын хэсэгт тодорхой хэмжээгээр ачаалал нэмэгдэх тул мөн технологийн шинэчлэл, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай болно. Улаанбаатар төмөр замын өнөөгийн хүчин чадал жилд 28,0 сая тн ачаа тээвэрлэх боломжтой байгаа бөгөөд ойрын үед 35,0 сая тн-д хүргэхээр зарим ажил хийгдэж байгаа болно. Цаашид урт хугацаанд Улаанбаатар төмөр замын хүчин чадлыг 100,0 сая тн-д хүргэх стратеги төлөвлөлт хийгдэж байна.

Төмөр замын хойд коридор нь Замын-Үүд-Эрээн-Улаанцав-Жанчхүү-Бээжин-Тяньжин хүрэх үндсэн төлөвлөгөөтэй боловч Бээжин-Тяньжин хэсэг маш их ачаалалтай, бөглөрөлтэй, мөн уул уурхайн бүтээгдэхүүн-нүүрс тээвэрлэхэд зарим хүндрэл гарах магадлалтай. Монгол улсын “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд эхний ээлжинд хэрэгжих Тавантолгой-Сайншанд-Хөөт, мөн 2 дахь ээлжийн Хөөт-Бичигт чиглэлүүд баригдаж ашиглалтад орвол Төмөр замын хойд коридорын уул уурхайн бүтээгдэхүүн, коксжих нүүрсийг Зүүн хойд Хятадын далайн боомтууд, аж үйлдвэрийн томоохон хотууд буюу зах зээлд нь шууд хүргэх боломж бүрдэнэ гэж үзэж болно.

Эрдэнэт-Овоот-Арцсуурийн төмөр зам ашиглалтад орсноор Хөвсгөл, Завхан төдийгүй алслагдсан баруун аймгуудын орон нутгийн ачааг төмөр замаар хямд, шуурхай тээвэрлэх, логистикийн төв, терминал аж ахуй, боловсруулах төрөл бүрийн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих боломж бүрдэнэ. Түүнчлэн төмөр замын сүлжээ нь Монголын хамгийн үзэсгэлэнтэй байгал бүхий нутгаар өнгөрөх тул бүх улирлын турш үйл ажиллагаа явуулах аялал жуулчлал хөгжих таатай орчин бүрдэх юм.

ДҮГНЭЛТ

1. “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн төслийн жагсаалтад орсон төмөр замын хойд коридорын эхлэлийн хэсэг болох Овоот-Эрдэнэтийн төмөр зам барих төслийг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг орших Овоотын чулуун нүүрсний уурхайг ашиглаж буй Австралийн “Аспайр майнинг” компаниас хэрэгжүүлэхээр урьдчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Төслийн

техник-эдийн засгийн үндэслэлийг 2018 оны эхээр боловсруулж дуусгавал мөн ондоо барилгын ажил эхлэх боломжтой болох бөгөөд ойрын 4-5 жилд ашиглалтанд орно.

2. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд баригдахаар төлөвлөгдсөн эхний төслүүдийг төрөөс хариуцан хийхээр 7 жил гаруй хугацаанд багагүй хөрөнгө зарсан боловч өнөөг хүртэл 1 ч км төмөр зам баригдаагүй. Тэгвэл Овоот-Эрдэнэтийн 547 км төмөр замыг 1.3 тэрбум ам.долларын өртгөөр, өөрийн хөрөнгөөр 5 жилийн дотор барьж байгуулан, 30 жилийн хугацаанд 100 хувь эзэмшиж ашиглаад, концессийн гэрээний хугацаа дуусгавар болох үед төмөр замын суурь бүтцийг төрийн өмчлөлд шилжүүлэх юм. Цаашид Улсын төсөв хөрөнгө хомсдолтой, өр зээл ихтэй болсон өнөө үед бусад төмөр замыг барихад ч энэ схемээр санхүүжилтийг шийдвэрлэх зарчим барих нь зүйтэй байна.
3. Хэдийгээр Овоотын уурхай нь стратегийн хувьд өндөр ач холбогдолтой биш ч Эрдэнэт-овоотын төмөр зам цааш Кызыл-Курагинотой холбогдож чадвал дэлхийн хэмжээний аврага Улуг-Хемийн ордын бүтээгдэхүүн төмөр замын хойд коридороор тээвэрлэгдэж, Ази-Европыг холбосон бас нэг коридор бий болно.
4. Кызыл-Овоот-Эрдэнэтийн төмөр замаар холбогдсон тохиолдолд Төмөр замын хойд коридороор наад зах нь 30,0-50,0 сая тн нүүрсийг жилдээ Монголын нутгаар дамжуулан Хятадын зах зээл болон далайн боомтоор дамжуулан бусад орнуудад гаргах хэрэгцээ шаардлага бий болно. Үүнтэй холбоотойгоор Улаанбаатар төмөр замын Эрдэнэт-Салхит, Сүхбаатар-Улаанбаатарын хэсэгт тодорхой хэмжээгээр ачаалал нэмэгдэх тул технологийн шинэчлэл, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.
5. Энэхүү төмөр зам нь баруун аймгуудын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн Монголын хамгийн үзэсгэлэнтэй байгал бүхий нутгаар бүх улирлын турш үйл ажиллагаа явуулах аялал жуулчлал хөгжих таатай орчин бүрдэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”
2. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол.
3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө. УИХ-ын

2016.10.26-ны 121-р тогтоол.

4. “Монгол Улсын Эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр” ЗГ-ын 2015 оны 474-р тогтоол.
5. “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоол.
6. Үндэсний статистикийн хороо. “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал-2016” УБ. 2017.
7. Үндэсний статистикийн хороо. “Худалдааны салбар-2016” УБ. 2017
8. Үндэсний статистикийн хороо. “Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн” УБ. 2017.
9. Үндэсний статистикийн хороо. “Монгол Улсын хөдөө аж ахуй” УБ. 2017
10. Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Хараат бус судалгааны хүрээлэн. “Бүс нутгийн эдийн засгийн интеграци: Монгол Улсын боломж ба эрсдэл” УБ. 2016 он.
11. “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого”. УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол.

Интернет:

1. https://ru.wikipedia.org/wiki/Улуг-Хемский_угольный_бассейн
2. vnedra.ru
3. www.mining-enc.ru/u/ulug
4. mert.tuva.ru
5. www.mert.tuva.ru
6. tugrk.ru
7. <https://mining-media.ru/>
8. xpert.ru/expert/2010/42/navalilis_na_tuvu/
9. <https://www.tuva.asia/news/tuva/3500-ugli.html>
10. <https://aspiremininglimited.mn/?page>
11. <http://www.1212.mn/>
12. <http://news.gogo.mn>
13. <http://ikon.mn>
14. www.mfa.gov.mn
15. www.iltod.gov.mn
16. mofa.gov.mn
17. www.news.mn
18. embassymongolia.ru
19. www.mongolianshaman.com
20. www.montsame.mn

ЭКОНОМИЧЕСКИЙ КОРИДОР КИТАЙ-МОНГОЛИЯ-РОССИЯ: НАЦИОНАЛЬНЫЕ ИНТЕРЕСЫ И ИНФРАСТРУКТУРНЫЙ ТРАНСНАЦИОНАЛИЗМ

*Г.Тумурчулуун**

В эти дни слово “трилатерализм” или трехсторонние переговоры в моде в нашем азиатском регионе.

Наряду с саммитами лидеров Китай-Япония-Южная Корея, которые имеют место регулярно, в 2014 году заложена основа трехстороннего сотрудничества Россия-Китай-Монголия.

После первого трехстороннего саммита в сентябре 2014 года лидеры трёх стран и их замминистры иностранных дел встретились несколько раз. Недавно во время первого в истории Ехро Китай-Монголия, три страны подписали в общей сложности десять трансграничных соглашений о сотрудничестве в области туризма, которые были сформулированы в рамках продолжающихся усилий для создания экономического коридора, соединяющего три страны. В соглашения на \$220 млн., включены проекты по обучению персонала, разработка туристических маршрутов и строительство отелей и курортов. Однако, ясно, что развитие туризма и экономического сотрудничества предполагает создание транспортной инфраструктуры, как железнодорожной, так и автодорожной.

Транспортная инфраструктура: часть транснационализма

Как указывается в Программе создания экономического коридора, подписанной в июне 2016 г. в г.Ташкенте, целями создания экономического коридора являются обеспечение условий для развития и расширения трехстороннего сотрудничества между КНР, Монголией и РФ, путем реализации совместных проектов, нацеленных на увеличение торгового оборота, обеспечение конкурентоспособности продукции, облегчение трансграничных перевозок и развитие инфраструктуры.

Далее в Программе подчеркивается, что продвижение в создании Экономкоридора будет способствовать углублению региональной экономической интеграции, созданию условий для сопряжения стратегий развития и инфраструктурной взаимозависимости, стабильному и поступательному развитию торговли и инвестиций, а также координации

* Доктор политических наук, профессор, ИМО МонГУ

экономической политики и укреплению гуманитарных контактов²⁴. К Программе прилагается приложение-перечень совместных проектов, в том числе в области инфраструктуры²⁵. Их всего 13, в том числе:

- Комплексная модернизация и развитие Центрального железнодорожного коридора (Улан- Удэ – Наушки – Сухэ-Батор – Улан-Батор – Замын Удэ – Эрлянь – Уланчаб – Чжанцзякоу – Пекин – Тяньцзинь), изучение экономической целособразности строительства второго пути и электрификации.
- Изучить и при экономической обоснованности начать реализацию проекта Северного железнодорожного коридора (Курагино – Кызыл – Цаган толгой – Арц сурь – Овот – Эрдэнэт – Салхит – Замын-Удэ – Эрлянь – Уланчаб – Чжанцзякоу – Пекин - Тяньцзинь).
- Изучить и при экономической обоснованности начать реализацию проекта Западного железнодорожного коридора (Курагино - Кызыл – Цаган толгой – Арц сурь – Кобдо – Такешкен – район Хами – Чанцзи-Хуэйский автономный округ - Урумчи).
- Изучить и при экономической обоснованности начать реализацию проекта Восточного железнодорожного коридора (Борзя – Соловьевск – Эрэнцав – Чойбалсан – Хут – Бичигт – Шилин-Гол (Чжуэньгадабуци) – Чифэн – Чаоян/Чэндэ – Цзиньжоу/Паньцзинь).
- Изучить и при экономической обоснованности начать реализацию проекта расширения “Туманганского транспортного коридора”(“Приморье-2) (Чойбалсан – Сумбэр – Аршань – Улан-Хото – Чанчунь – Яньцзи – Муданьцзян – Суйфэньхэ – Владивосток - Находка).
- Изучение перспектив строительства высокоскоростной железнодорожной магистрали Москва – Пекин через территорию Монголии.
- Проведение совместных переговоров по вопросу учреждения трехсторонней логистической компании.
- Интенсивное использование в транспортных перевозках маршрута АН-3 сети Азиатских автодорог (Улан-Удэ – Кяхта – Алтанбулаг – Дархан – Улан-Батор – Сайншанд – Замын-Удэ/Эрлянь – Внешний Пекин - Тяньцзинь), изучение экономического обоснования строительства скоростной автомобильной дороги в этом направлении.

²⁴ Программа создания Экономического коридора Китай-Монголия-Россия. 2016 г. стр. 1

²⁵ Приложение к Программе стр. 1,2.

- Строительство и интенсивное использование в транзитных перевозках маршрута АН-4 сети Азиатских автодорог (Новосибирск – Барнаул – Горно-Алтайск – Ташанта/Улан байшинт – Ховд - Ярантай/Такешкен – Урумчи Каши – Хонкираф).
- Изучить и при экономической обоснованности начать реализацию проекта Восточного автодорожного коридора по маршруту (Борзя – Соловьевск – Эренцав – Чойбалсан – Барун Урт – Бичигт – Чжуэньгадабуци – Си – Уджимчмин - Чифэн/Силин-Хото – Чаоян/Чэндэ - Паньцзинь/Цзиньчжоу/Тяньцзинь).
- Содействие подписанию и реализации соглашения между правительствами Монголии, Китайской Народной Республики и Российской Федерации о международных автомобильных перевозках по Азиатским автомобильным дорогам (ЭСКАТО).
- Более активное создание телекоммуникационной инфраструктуры, создание площадок обеспечения безопасности управления технологическими процессами транзитных транспортных коридоров по направлению Улан-Удэ – Кяхта/Алтанбулаг – Дархан – Улан-Батор – Сайншанд – Замын-Удэ/Эрлянь – Уланчаб – Пекин - Тяньцзинь).

Экономический коридор призван создать инфраструктуру и торговую интеграцию в целом, в соответствии с индивидуальной политикой всех трех стран: Китай - «Один пояс-Одна дорога» (ОПОД), «Россия-Транс-Евразийский пояс развития (ТЕПР) и Степной путь Монголии. Ранее в этом году китайская государственная телекомпания CCTV окрестила трехсторонний коридор «Мост аорты ». Значимость трехстороннего коридора идет гораздо глубже, чем брак экономического удобства. Может быть основной причиной выхода за рамки простой географии является то, что эти три страны солидарны в том, что все хотят превратить социалистическую плановую экономику в рыночную и они нуждаются друг в друге для продвижения целей развивающихся стран в мире, где они все берут на себя более тяжелые глобальные обязанности.

Национальные интересы Монголии

Сотрудничество трёх соседей – это естественное состояние. Для Монголии установление регулярного формального диалога с ее двумя соседями укрепляет ее дипломатическую позицию в Азии и идеально подходит международным чаяниям Монголии, выраженным в Конституции

и Концепции внешней политики страны²⁶. Пройдя через значительный экономический спад в последние годы, Монголия нуждается в сильной экономической базе для утверждения гибкости в маневрах внешней политики с другими странами. Например, Монголия должна способствовать более прочным отношениям с Китаем, если она хочет, чтобы улучшить доступ к китайским портам и таким образом открыть новые рынки для экспорта Монголии.

Некоторые противники экономического коридора внутри Монголии сравнивают его с Кяхтинским русско-китайско-монгольским трёхсторонним Соглашением 1915 года. Монголия XX века несравнима с Монголией начала XXI века. В 1915 году капиталистический Китай и царская Россия вынудили Монголию отказаться от своей независимости, за которую веками боролись монголы и которая была объявлена 29 декабря 1911 года, провозглашено Богдханьское Монгольское государство.

Нынче не те времена. Да и не та Монголия, не тот Китай и не та Россия.

Сравнить нынешний экономический коридор с Кяхтинским соглашением – стопроцентный нонсенс. Противники экономического коридора - это люди, желающие экономической изоляции и вечной отсталости Монголии и монголов.

Национальные интересы КНР и РФ.

Экономический коридор отвечает и интересам России и Китая. Россия все больше смотрит на его южных партнеров для создания дипломатических союзов в свете недавнего отчуждения от Запада, и это помогает России для преодоления западного *cordon sanitaire*.

Несомненно, Китай ищет баланс интересов США в регионе путем разработки своих собственных геополитических сфер влияния. Здесь действует и геополитический аспект. Один факт, который касается некоторых китайских политиков, то, что Китай остается крупнейшим торговым партнером Монголии ввиду географической близости, длины общей границы, а США имеет значительные оборонные связи со страной.

Имеются также признаки возможного трехстороннего сотрудничества за пределами политики безопасности и экономики. На их первом

²⁶ “Китай, Монголия и Россия рассматривают развитие традиционно дружественных, взаимовыгодных экономических отношений в качестве одного из стратегических направлений внешней политики Сторон”. Программа создания экономкоридора, стр. 1.

трехстороннем совещании президент Си Цзиньпин говорил о важности и необходимости расширения трехстороннего сотрудничества между мозговыми центрами, СМИ, органами охраны окружающей среды, а также взаимодействия в области предотвращения стихийных бедствий и в случаях чрезвычайных ситуаций, помимо укрепления очевидных экономических механизмов.

Транснационализм и экономический коридор

На форуме в Давосе в январе с.г. , как и во время своей встречи с г-н Дональдом Трампом в ноябре прошлого года, президент Китая Си Цзиньпин выступал с речью о достоинствах свободной торговли, когда его коллега всячески защищал лозунг «Америка первая» и политику протекционизма или изоляционизма.

Пекин принял вызовы глобализации, чтобы найти свое место в мире после длительного периода затмения в XIX веке — из-за давления колониальных держав (Европейские и японская) и из-за внутренних проблем (голод, стихийные бедствия, бунты), и затем периода почти самоизоляции времен Мао Цзедуна с 1949 до 1976 гг.

Подобное положение Китая имеет два далеко идущих последствия для России, Монголии, для самого Китая, да и для международных отношений в целом.

Ныне Китай вновь занимает центральное место в глобальной экономике. КНР вернулась на самом деле, если принимать историческую перспективу, то эта позиция пропорциональна ее демографическому весу, который был у нее в восемнадцатом веке. Её появление имеет глубокие политические последствия и стратегический характер, что подтверждается утверждением ее суверенитета в Южно-Китайском море, ростом ее военного потенциала, созданием морского маршрута и наземных коридоров в мире. Это подтверждается также созданием новых финансово-экономических институтов развития и управления, таких как Азиатский Банк инфраструктурных инвестиций (Asian infrastructure investment bank) или Новый банк развития (НБР БРИКС), Межбанковское объединение Шанхайской организации сотрудничества и, наконец, Фонд Шелкового пути. Китай, в целом, оказался в центре так называемого феномена “ребалансинг равновесия” на планете, который изменяет существующий до сих пор порядок в мире. Это касается, прежде всего, международных финансовых институтов, возникших после второй мировой войны. Так, по

представлению Китая, МВФ будет заменен такими новыми структурами, как БРИКС, АСЕАН +3 и Форумом Чанг Май. Мировой Банк и Азиатский банк развития будут заменены Азиатским Банком инфраструктурных инвестиций, Банком Брикса и Фондом Шелкового Пути. Вместо G7 придут саммиты БРИКСа. Такие ныне существующие международные форумы как Давосский и Internet governance, например, будут заменены Боа Форумом и Мировой Интернет Конференцией .

Преобразование и повышение роли и места Китая в глобальном мире поднимает вопрос об относительной автономии Государства в контексте глобализации.

С точки зрения его масштабов и последствий, оно нарушает статус-кво крупных государств в последние десятилетия. Новая ситуация означает, что транснационализация экономических потоков в сочетании со временем и пространством, вызванных революцией в области коммуникации, понижает роль государства, лишая его суверенитет и его возможность для вмешательства. Этот тезис имеет несколько вариантов. Согласно его транснационально-либеральному варианту современная межгосударственная система, основанная Вестфальским договором 1648 г., и опирающиеся на нее национальные государства подходят к концу своего существования. Вестфальская модель будет заменена так называемой постмеждународной конфигурацией или постмодернистской системой, характеризующейся переходом власти к частным игрокам и транснациональным субъектам и учреждением «глобальной системы управления».

В этом я вижу возможные глобальные, международные последствия китайского преобразования, частью которого является экономический коридор «Китай-Россия-Монголия».

ОХУ, МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР: МОНГОЛЫН ХУВЬД БИЙ БОЛОХ БОЛОМЖ, ЭРСДЭЛ.

Б.Санжмятав*

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар ШХАБ-ын 2011 оны 9 дүгээр сард Душанбед болсон дээд хэмжээний уулзалтын үеэр ОХУ-Монгол-Хятадын гурван орны Ерөнхийлөгч нарын уулзалт анх удаа зохион байгуулагдсан нь хамтын ажиллагааны нэг шинэ механизмын үндэс суурь болсон.

Хөрш орнуудын 3 талт хамтын ажиллагааны асуудлыг нэлээд хэдэн жилийн өмнөөс эхлээд ГХЯ-ны газрын дарга, дараа нь дэд сайд нарын түвшинд ярилцаж ирсэн байдаг. Харин эл механизмыг дээд хэмжээнд болгон дээшлүүлэх саналыг Ц.Элбэгдорж гаргасан.

Гурван талт хамтын ажиллагааны үндсэн чиглэл бол эдийн засгийн хамтын ажиллагаа болохыг төрийн тэргүүн нараас тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “гурван орны улс төрийн харилцааны нэн таатай харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулах нь талуудын ашиг сонирхолд бүрэн нийцнэ”²⁸, БНХАУ-ын дарга Си Зиньпин “гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл бол эдийн засгийн хамтын ажиллагаа байх, гурван орон хөгжлийн стратегиа уялдуулах хэрэгтэй бөгөөд эл хамтын ажиллагаа нь ЗХА-динтеграцийг гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр болно”²⁹, В.В.Путин “газар зүйн хувьд хөрш байгаагийн хувьд дэд бүтэц, эрчим хүч, уул уурхайн салбарт урт хугацаанд хамтран ажиллахад таатай нөхцөл бүрдүүлэх болно”³⁰ гэж тодорхойлжээ.

Нэг. Гурван талт эдийн засгийн коридорыг байгуулах үзэл санаа үүссэн түүхээс

Хөрш зэргэлдээ гурван орныг холбосон зам харилцааг хөгжүүлэх асуудал нэлээд эртнээс яригдаж, хэрэгжиж ирсэн түүхтэй. Өнөөгийн 3 орны хамтын ажиллагааны эхлэл бол XVII зуунд Хятадаас гаралтай цайг Оросын нийслэл, мужуудад түгээх явдал байж, цайны замыг үүсгэжээ. Энэ ажил Орос, Хятадын хилийн заагийг тогтоосон 1727 оны Буурын гэрээний

* МУИС-ийн ОУХНУС-ийн зөвлөх профессор, Олон улсын эдийн засгийн ухааны доктор(Ph.D)

²⁸ Уфад 2015 онд болсон дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2015.07.10

²⁹ Уфад дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2015.07.10

³⁰ Мөн тэнд

дараагаар эхэлж, цайг Хятадын Хаалганаас Монголоор дамжуулан тэмээн хөсгөөр тээвэрлэж, Монголын хилийн хойд талын боомт болох Наймаачинд хүргэж оросуудад худалдах, оросууд худалдаж авсан цайгаа хил залгаа Хиагтад оруулан боловсруулж, хэвлээд цааш нь оросын нийслэл, бусад мужуудад түгээх болсон байна. Ийнхүү цайны худалдааны эл замыг дэлхийн түүхэнд «Их цайны зам» гэж хожим нь нэршиж заншжээ.

Төмөр зам нь өнгөрсөн зууны эхээр хамгийн дэвшилттэй, хамгийн хямд тээврийн хэрэгсэл байсан. XX зууны эхээр Хятадууд Монгол руу төмөр зам тавих замаар Монголын баялгийг Хятадын эх газар руу зөөх, Хятадын Өмнөд хэсгийн хүн амын суурьшлыг сийрэгжүүлэх зорилгоор төмөр зам дагуух нутагт Монголд хятадын суурингуудыг байгуулах асуудлыг нэлээд судлаж, төлөвлөгөө ч гаргаж байсан байдаг. Тухайлбал, Хятадын хувьсгалын удирдагчдын нэг болох Сун Ятсен 1912 онд «Үндэстнийг хөгжүүлэх стратеги»³¹ хэмээх номондоо төмөр замыг судастай зүйрлэж, Аугаа Хятад орныг цогцлооход төмөр зам барихыг санал болгож, ингэхдээ Монгол руу 7 чиглэлээр төмөр зам тавих зураг гаргаж байсан нь өнөөдөр Хятадаас Монголын хил рүү төмөр зам тавьж байгаа чиглэлтэй яг таарч байгаа юм.

Оросуудын хувьд Монголд нөлөөгөө нэмэгдүүлэхийг эртнээс мөрөөдөж, түүнийг хэрэгжүүлэх үндсэн арга зам бол төмөр зам байгуулах явдал гэж харж байсан. Тийм ч учраас Хаант Орос Улс 1870-1920 оны хооронд Монголд оросын 100 гаруй экспедицийг ажиллуулж, тэдний судалж явсан нэг зүйл нь төмөр зам барих асуудал байжээ. Оросын худалдаачдын судалгаагаар, хэрвээ Хүрээ рүү төмөр зам баривал орос барааны үнийн тээврийн зардлыг 500 дахин бууруулна гэж тооцож байсан мэдээ байна.

Хаант Орос Улсаас Атлантын далайг Номхон далайтай төмөр замаар холбох зорилгоор Транссибирийн төмөр замыг барихыг санаачилжээ. Оросын хаан Александр III 1891 онд Транссибирийн төмөр замыг барих тухай зарлигт гарын үсэг зурж, нийтдээ 350 сая алтан рублийг зарцуулахаар шийдвэрлэж байсан. Гэвч амьдрал дээр анх төлөвлөгдсөн хэмжээнээс хавьгүй их хөрөнгө зарцуулагдсан /1,5 тэрбум алтан рубль/ мэдээ байдаг. Ингээд Транссибирийн төмөр зам 1901 онд ашиглалтад орж, галт тэрэг явсан. Гэвч Оросын нийслэл Санкт-Петербург, Владивосток, Порт Артурын хооронд байнгын галт тэрэгний хөдөлгөөн 1903 оны 7 дугаар сарын 1-нээс эхэлсэн түүхтэй.

Транссибирийн төмөр замыг салаалан Хятадын Манжууртай холбох шийдвэр гарч газар шороо, барилгын ажил 1897 онд эхэлж, 1520 км

³¹ Sun Yat Sen(孙中山), The Scheme for Building Country(建国方略), 1912, Beijing,

замыг 1903 онд барьж дуусгаад ашиглалтад оруулжээ. Үүний хажуугаар Транссибирийн төмөр замыг Эрхүү, Улаан Үүдээр дайруулан Хүрээ хүртэл үргэлжлүүлэх асуудал яригдсаар ирсэн байдаг.

Тухайн үеийн монголчууд ч дэлхийн томоохон гүрнүүдийн төлөвлөгөөг мэдэж байсан төдийгүй, төмөр зам тавихыг өөрийн асуудлыг шийдвэрлэхэд ашиглахыг оролдож байсан түүхтэй. Намнансүрэн нар 1912 онд Петербург хүрч Хаант Орос Улсаас тусламж гүйхдаа, Монгол Улс оросын худалдаачдыг нь илүү таатай нөхцлөөр хүлээн авах, төмөр зам тавихыг зөвшөөрч байгаагаа хэлж байжээ³².

Тухайлбал, Богд хаан Монгол Улсын сайд нар болох Ханддорж, Намнансүрэн нар тусгаар улсын эзэн мэдэх эрх гэгчээр шалтгаалан төмөр зам барихад зөвшөөрөхгүй байсан тул хятадууд Хаалганаас жингийн цуваа гаргахыг хориглосон. Ийнхүү 3 жил бараагүй гачигдаж, Хятадаас авдаг бараа болох цай зэргийн үнэ 3 дахин өссөн нь бий. Тэр үед Монголын ноёд өөр хоорондоо ярихдаа, хоолтой хоолгүй явах нь бидний өнөөгийн явдал. Өнөөдрийн хоолны гачаалаас болж, хожим хойчийн үедээ цөв суулгах бий гэж эмээж байна гэж ярьдаг байсан тухай өвгөдийн хуучид бий. Тийнхүү түр зуурын ашгийг бус, алсыг харсан шийдвэр гаргаж байсан байдаг.

Харин 1913 оноос Хүрээний Засгийн газар зарим буулт хийж, тохиролцож чадсанаар 1913 оны 10 дугаар сард хятадууд жингийн цувааг илгээхийг зөвшөөрч байжээ. Тийм учраас ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн коридорыг байгуулах үзэл санаа нь нэлээд эртнээс гарч, зарим чиглэлээр хэрэгжиж ирсэн гэж үзэх үндэстэй болно.

Хоёр. Орос, Монгол, Хятадын эдийн засгийн коридор байгуулах

Монголын хувьд газар зүйн байрлалаараа Бээжин, Москваг холбох хамгийн дөт зам болохоос гадна магадгүй хамгийн аюулгүй, хамгийн найдвартай зам болох бололцоо бий. Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор бий болгох саналыг Хятадын ГХ-ийн сайд Ван И 2015 оны 4 дүгээр сарын 2-нд МУ-ын ГХ-ийн сайд Пүрэвсүрэнг Бээжинд хүлээн авах үеэрээ анх удаа дэвшүүлэн тавьсан. Тэрээр гурван орны эдийн засгийн коридорын ач холбогдлыг үнэлж хэлэхдээ, “энэхүү коридорыг байгуулах нь гурван ард түмний амьдралд ач тусыг, гурван орны эдийн засагт хөгжлийг, Евразийн хөгжилд шинэ хүчтэй эрч хүчийг авчрах болно. Орос, Хятад, Монголын хооронд хөгжлийн хамтын ажиллагааны томоохон орон зай бий»³³

³² Б.Санжмятав, Гурван улсын Хиагтын гэрээний тухай түүхэн үнэн, УБ, 1991.

³³ РИА новости, 2015.04.02

гэжээ.

Орос, Монгол, Хятадын гурван талт дээд хэмжээний II уулзалт 2015 оны 7 дугаар сарын 9-нд Уфад болж, эл хамтын ажиллагааны “замын зураг” буюу “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр боловсруулах тухай Санамж бичиг”-ийг байгуулж, мөн тээврийн сайд нар авто зам, төмөр замын коридорыг хөгжүүлэх, одоо байгаа төмөр замыг шинэчлэх зэрэг гурван талт тээврийн салбарын хамтын ажиллагааны асуудлуудаар яриа хэлэлцээ хийж, уулзалтын үр дүнд гурван яамдын хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурав.

ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын гурав дахь удаагийн уулзалт 2016 оны 6 дугаар сарын 23-нд ШХАБ-ын Ташкентийн дээд хэмжээний уулзалтын эхэнд болов. Энэхүү дээд хэмжээний уулзалтын үеэр талууд гурван орны хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр, зарим төрлийн бараанд хийсэн гаалийн хяналтын үзлэгийн дүнг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээрт тус тус гарын үсэг зурав. Дамжин өнгөрөх тээврийн асуудлаарх хэлэлцээрийн төслийг зарчмын хувьд тохиролцоод байсан боловч энэ удаа түр хойшлуулжээ.

Тэргүүн нар Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан 32 арга хэмжээ, төслөөс хэрэгжүүлэх дарааллыг тогтоох, түүний эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх ажлыг хариуцсан “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв”-ийг Улаанбаатарт байгуулахаар тохиролцсон нь туйлын чухал ач холбогдолтой болов.

“Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн баримт бичигт дурдсанаар хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх чиглэлүүд нь нэгд, Тээврийн дэд бүтцийн харилцан уялдаа бүхий хөгжлийг дэмжих, хоёрт, Хилийн боомтуудыг хөгжүүлэх, гаалийн болон хорио цээрийн хяналтыг боловсронгуй болгох, гуравт, Аж үйлдвэр болон хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг бэхжүүлэх, дөрөвт, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, тавд, Хүмүүнлэгийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх, зургаад, Хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх, долоод, Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Монголын талаас Гадаад хэргийн яам, БНХАУ-ын талаас Хөгжил, шинэтгэлийн хороо, ОХУ-ын талаас Эдийн засгийн хөгжлийн яам хариуцах юм.

ОХУ, Монгол Улсын ерөнхийлөгч нар мөн ОХУ, Монгол Улс, БНХАУ-

ын зүүн бүс нутагт дэд бүсийн гурван талын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хятадын талаас гаргасан саналыг дэмжиж байгаагаа илэрхийлжээ.

Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн ач холбогдлыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоос “Хөрш гурван улсын хооронд хамрах цар хүрээгээрээ урьд өмнө хэзээ ч байгаагүй томоохон хөтөлбөр болсон”, БНХАУ-ын дарга Си Зиньпинээс “Хөтөлбөр нь гурван тал харилцан хөрш орны давуу талд тулгуурлан нягт хамтран ажиллаж болно гэдгийг харуулж байна. Хөтөлбөр нь гурван улсын хөгжлийн стратегийг уялдуулсан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж, гурван талын бодит ажиллагааны эн тэргүүний чиглэлийг тодорхойлсон”, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинээс “Манай гурван улсын түншлэлийг хөгжүүлэх нөөц бололцоо бий. Энэхүү нөөц бололцоог гурван улсын ард түмний сайн сайхны төлөө цаашид идэвхтэй ашиглах нь зүйтэй³⁴” гэж үнэлжээ.

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын агуулга нь Хятадаас санал болгож буй “Нэг бүс, Нэг зам”, Монголоос санал болгож буй “Хөгжлийн зам (талын зам)”, Оросын талаас санал болгож буй “Ази, европын замын нэгдсэн сүлжээ”-ний санаачилгуудад тулгуурлах ёстой байна.

Гурав. Эдийн засгийн коридор байгуулснаас Монголын хувьд үүсэх бололцоо, эрсдэл.

Дэд бүтцийг хөрш орнуудтай холбож, зам харилцааг сайжруулах нь зах зээлийг тэлж, зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх учраас эдийн засагт ямагт шинэ боломжийг үүсгэдэг. Энэ утгаар авч үзвэл ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн коридорыг байгуулах нь Монголын эдийн засгийн хувьд дараах үндсэн **боломжуудыг** нээх болно гэж үзэж байна. Үүнд:

- 3 орны эдийн засгийн коридорыг байгуулахад газар зүйн байрлалын хувьд голд нь орших Монголын ач холбогдол гурван талт хамтын ажиллагаанд нэмэгдэх болно.
- Монголын нутгаар 3 орныг холбосон төмөр замын хүчин чадлыг нэмэгдүүлж, улмаар цахилгаанжуулах, хурдны авто замыг барьж ашиглалтад оруулах нь бүс нутагт хамтын ажиллагааны өгөөжийг нэмэгдүүлж, хөрөнгө, цаг хэмнэх, дэд бүтэц, ложистикийн нэгдсэн стандартуудыг нэвтрүүлэх таатай нөхцлийг бүрдүүлэх болно.

³⁴ ОХУ, МУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нараас оныТашкентын дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2016.06.26, Ташкент, www.mfa.mn

- Монголын нутгаар цахилгаан дамжуулах, хоолойн тээврийн шугамыг барих бол Монголд ажлын байрыг бий болгох, үйлчилгээний орлогыг бий болгохоос гадна тэдгээр шугамаас эрчим хүчний эх булгийг авч ашиглах, эсхүл өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх бололцоо үүснэ.
- Эдийн засгийн коридорын бүсэд эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк зэргийг байгуулах замаар хамтарсан объектуудыг байгуулах нь бүс нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, хангамжийн нэгдсэн сүлжээг байгуулах бололцоо гарна.
- Монголын дэд бүтэц, ложистикийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг хамтран гаргах, эдийн засгийн хөгжлийн стратеги, бодлогоо уялдуулах, интеграцид орох бололцоо гарч, хамтын ажиллагааны өгөөж сайжирна.
- Эдийн засгийн коридорыг байгуулах ажлын хүрээнд Улаанбаатарт «Хөрөнгө оруулалтын хамтарсан төв»-ийг байгуулах нь төслийн боловсруулалт, хөрөнгө босгох, хэрэгжүүлэх ажиллагаанд орос, хятадын туршлагаас суралцах, хамтран ажиллах бололцоог нэмэгдүүлнэ.
- Монголын эдийн засаг, зах зээл тэлснээр ГШХО-ыг татах бололцоо нэмэгдэж, уул уурхайн бус салбарт хөрөнгө оруулалт татах бололцоо нэмэгдэнэ.
- Хөрш орнуудад ногоон эдийн засгийг хөгжүүлж, байгаль орчинд муу нөлөөтэй үйлдвэрлэлийг гадаадад хийх болсноор Монголын экспортын түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, ОХУ-д зарим бүтээгдэхүүнийг экспортлох боломж гарна.

Бүс нутгийн хөгжлийн томоохон үйл явц нь дээрх боломжуудыг нээхээс гадна тодорхой хэмжээний эрсдэлийг давхар үүсгэж байдгийг нарийвчлан тооцож, сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээ авах нь Засгийн газрын үүрэг байдаг. Энэ талаар оросын бизнес, эдийн засагчдын төлөөлөл болох брокерийн FBS компанийн эдийн засагч Денис Тетюшин “Хятадын дээрх санаачилгыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хувьд гол ашгийг мэдээж Хятад, тэгээд ОХУ хүртэх, харин Монгол нь санаачилгатай ажиллаж чадахгүй бол, тэдний дунд түнш л байх болно, харин геополитикийн хувьд Хятадын эдийн засгийн хөгжлийг дэмжихэд ихээхэн хэрэгтэй байгаа Ази, Европыг холбох нэгэн замыг ашиглагдаж эхлэх, ОХУ-ын хувьд зам дагуу хөрөнгө оруулалт нэмэгдэх, Монголтой хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно³⁵” гэж бичсэн нь нэлээд бодитой дүгнэлт гэж үзэж болохоор

³⁵ *<http://expert.ru/2015/04/2/rossiya-pojdet-po-shelkovomu-puti-s-mongoliej/>

байна. Америкийн Монгол судлаач А.Кэмпби бичихдээ, “Монголын хүчирхэг хоёр хөрш нь хоорондынхоо тээвэр, эрчим хүчний хамтын ажиллагааны асуудлыг тохиролцохдоо Монгол Улсын ашиг сонирхлыг харгалзан үзэхгүй явж ирснийг онцлоод, 3 талт хамтын ажиллагаа нь Монголын асуудалд анхаарах нөхцлийг бүрдүүлэх болно. Харин Монголоос хоёр хөрштэйгээ харилцах талаар баримталж байгаа бодлогыг евразийн бусад орнууд, бүр ЕХ, АНУ ч тэр бүр ойлгодоггүй” гэжээ³⁶. Эндээс харахад эдийн засгийн коридорыг байгуулахад Монголын хувьд эдийн засгийн эрсдэлээс гадна бас улс төр, геополитикийн хувьд эрсдэл үүсэх нь тодорхой байна.

Энэ тохиолдолд Орос, Монгол, Хятадын эдийн засгийн коридорыг байгуулах нь Монголын хувьд дараах эрсдэлтэй байж болох юм гэж үзэж байна. Үүнд:

- Коридорыг байгуулах хүрээнд хийх бүтээн байгуулалтууд нь томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг шаардах тул хөрөнгийг босгох, төслийг хэрэгжүүлсний дараагаар дэд бүтцийг ашиглах талаар гурван орны хүрээнд урт хугацааны тохиролцоог байгуулах шаардлагатай. Тэгэхгүй бол зээлийн хөрөнгийг эргүүлж төлөхөд, Монголын хувьд хүлээж байсан үр ашгийг хүртэхэд томоохон эрсдэл үүсэх болно.
 - Хөрш орнууд Монголтой холбоотой төслүүдийн талаар нэгдмэл байр суурьтай оролцох тохиолдолд монголчуудад үндэсний эрх ашгаа хамгаалах, дарамтанд орох нөхцөл үүсч болзошгүй.
 - Монголын гадаад бодлогод «гурав дахь хөрш» гэж тодорхойлогдсон өрнө, дорнын түнш орнуудад эл бодлогыг сайтар тайлбарлан ойлгуулж байхгүй бол харилцан ойлголцохгүй зүйлүүд гарч болно.
 - Монголын хөрш орнууд нь улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө мөнгөний хэмжээ, боломж нэлээд ялгаатай байгаагаас шалтгаалан хамтын ажиллагааны тэнцвэргүй байдлыг улам нэмэгдүүлэх боломжтой.
- Аль нэг талаас бараа бүтээгдэхүүнд хийсэн хил, гаалийн үзлэгийн үр дүнг нөгөө талууд нь хүлээн зөвшөөрөх болсноор монголын талын хяналт суларч, хууль бус наймаа, улс дамжсан гэмт хэргийн гаралт нэмэгдэх бололцоотой.

³⁶ Alicia Campi, Transforming Mongolia-Russia-China Relations: The Dushanbe Trilateral summit, 3 Nov. 2014, p 1 www.arslan.mn

**Гурван орны хооронд эдийн засгийн коридорыг байгуулснаас
Монголын хувьд үүсч болох нөхцлийн СВОТ шинжилгээ**

Монголын хувьд үүсэх давуу тал	Монголын хувьд үүсэх сул тал
-Гурван орны дэд бүтцүүд холбогдож , тэдгээрийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол Улсын ач холбогдол нэмэгдэнэ. -Монголоор дамжин өнгөрөх тээврийн хэрэгсэл, ачаа нэмэгдэж, ложистикийн төв бий болно. -“Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төв” байгуулагдснаар гурван талт хамтын ажиллагааны төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд шууд оролцох, илүү мэдээлэлтэй байх бололцоо гарна. -Гурван орны итгэлцлийн түвшин нэмэгдэж, Монголын нутгаар зарим хоолой, цахилгаан дамжуулах шугам тавигдах бололцоо гарна.	-Монгол Улс өнөөдөр хуримтлал багатай, цөөн хүн амтай тул төслүүдийг хэрэгжүүлэхэд хөршүүдийн царайг харах нөхцөл үүсч болно. -Эдийн засгийн коридор байгуулах явцад дэд бүтэц холбох, үйлдвэрийн парк байгуулахад ажиллах хүч дутагдаж, гаднаас авахад хүрнэ.
Монголын хувьд үүсэх боломж	Монголын хувьд үүсэх эрсдэл
-Гурван орон хөгжлийн бодлогоо уялдуулж, хамтарсан төслүүд хэрэгжүүлэх нь бүс нутгийн үйлдвэрлэл, хангамжийн сүлжээ үүсэх нөхцлийг бүрдүүлнэ. -Эдийн засгийн коридорын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг илүү таатай нөхцлөөр олох бололцоотой болно. -Хөрш орнуудад ногоон эдийн засгийг хөгжүүлж, байгаль орчинд муу нөлөөтэй үйлдвэрлэлийг гадаадад хийх болсноор Монголын экспортын түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, ОХУ-д зарим бүтээгдэхүүнийг экспортлох боломж гарна. -Гурван орны дэд бүтцүүдийг холбож, зардлыг бууруулах, хүнд суртлыг багасгах боломж гарна. -ОХУ, БНХАУ-ын хөгжлийн хил залгаа муж, газруудын хөгжлийн стратеги, боломжийн талаар илүү мэдээлэлтэй болж, хамтын ажиллагаа өргөжих бололцоо гарна. -Гурван орны хэмжээнд юуны өмнө гаалийн хамтын ажиллагаа, зам тээврийн салбарт олон улсын стандартууд нэвтэрч, бизнесийг хөнгөвчлөх болно. -Хамтын ажиллагааг урт хугацаанд хөгжүүлэх, улмаар эдийн засгуудыг интеграцид оруулах бололцоо нэмэгдэнэ. -Хөршүүдтэй хил залгаа газарт чөлөөт худалдааны бүс байгуулах замаар зардлыг хямдруулах, шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөл үүснэ.	-Гурван орны хэмжээнд томоохон төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд нөгөө хоёр орон нэгдсэн байр сууринаас оролцох нөхцөлд Монголын нөлөө багасч, шахалтад орох нөхцөл үүсч болно. -Гурван талт хамтын ажиллагааны эхний шатанд монголчуудын мэдээлэл дутуу, судалгаа муу байгаагаас шалтгаалан үйл ажиллагаа нь хангалттай идэвхтэй байж чадахгүй байх нөхцөл үүсч болно. -Аль нэг талаас бараа бүтээгдэхүүнд хийсэн хил, гаалийн үзлэгийн үр дүнг нөгөө талууд нь хүлээн зөвшөөрөх болсноор монголын талын хяналт суларна. -Хяналт шалгалт суларснаар хууль бус наймаа, улс дамжсан гэмт хэргийн гаралт нэмэгдэх бололцоотой.

Шинжилгээнээс үзэхэд гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлж, тэдгээрийн хооронд эдийн засгийн коридорыг байгуулах нь Монголын хувьд ашигтай болох нь харагдаж байна. Харин сул тал, эрсдэл болж гарсан хүчин зүйлүүдийн нөлөөг багасгах талаар тодорхой ажиллах шаардлагатай байна

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖҮҮД

1. Гурван талт хамтын ажиллагаа, гурван орны эдийн засгийн коридорт оролцох монголын оролцооны асуудлаар өөрийн байр суурийг боловсруулахын тулд төрийн албаны холбогдох яамд, эрдэмтэд, судлаачдаас бүрдсэн ажлын хэсгийг даруй байгуулан ажиллуулах, энд дэд бүтцийн томоохон төслүүдийг хөрш орнуудын засгийн газрын хөнгөлөлттэй зээл (олон улсын зах зээлээс босгох арилжааны зээлээс хамаагүй бага хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй), тусламжаар санхүүжүүлэх асуудлыг боловсруулах шаардлагатай байна
2. Хөрш орнууд монголчуудад хэрэгтэй бүх зүйлийг, хямд үнээр хоёр хилийн боомтууд дээр авчирч бэлдээд байгаа нь Монголд дотоодод үйлдвэр хөгжихгүй байх, эдийн засаг, худалдааны хувьд гадаадаас хамаарах, валют дутагдсан хэвээр байх нөхцлийг бүрэлдүүлж байгааг өөрчлөх хэрэгтэй юм. Ингэхийн тулд бид зам дагуу дундад азийн орнуудын жишгээр эдийн засгийн чөлөөт бүсүүд байгуулах, аж үйлдвэрийг дотооддоо тууштай хөгжүүлэх, ингэхдээ иж бүрнээр нь хөгжүүлэх шаардлагатай байна.
3. Шинэ торгоны замын санаачилгын хэрэгжилт нь дэлхийн геополитикийг үндсээр нь өөрчлөх төлөвтэй байна. Энэ замын хамтын ажиллагаанд оролцогч орнуудын хувьд зөвхөн өөрийнхөө хүчинд илүү тулгуурлах эрмэлзлийг нь батжуулж, атлантын цаадах нөлөөг багасгахад хүрэхээс гадна дэлхийн бодлогын төв Еврази руу аажмаар шилжих үйл явц өрнөж байна. Мөн Еврази руу Энэтхэг, Пакистан, Иран, Ойрхи Дорнод, Африк хандаж эхлээд байна. Олон улсын харилцааны тогтолцооны шинэ нөхцөлд Монгол Улс Евразид өөрийн байрыг эзлэх шаардлагатай болж байна.
4. 2015 онд байгуулагдсан гурван орны эрдэмтдийн «Think Thank» уулзалт нь хамтын ажиллагааны үндэслэл (онолын)-ийг гаргах үүрэгтэй болох тул монголын талын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн бүрдүүлж чадваржуулах, бүлгийн зохицуулалтыг МУИС-д төвлөрүүлэх,
5. Гурван орны “Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хамтарсан төв”-ийг Улаанбаатарт хүлээн авч нөхцөл бүрдүүлж, төвийг аажмаар гурван талт хамтын ажиллагааны НБДНГ болгон өргөжүүлэх чиглэлээр ажиллах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Sun Yat Sen (孙中山), The Scheme for Building Country (建国方略), 1912, Beijing,
- *Alicia Campi, Transforming Mongolia-Russia-China Relations: The Dushanbe Trilateral summit, 3 Nov. 2014, www.arslan.mn*
- Б.Санжмятав. Гурван улсын Хиагтын гэрэний тухай түүхэн үнэн, УБ, 1991.
- ОХУ, МУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нараас дээд хэмжээний уулзалт дээр хэлсэн үг, 2015, 2016 www.mfa.mn
- Бүс нутгийн интеграци: Монголын хувьд үүсэх боломж, эрсдэл, 2016 судалгаа.

Вэб:

- <http://expert.ru>

ОХУ, БНХАУ-ЫН ХАРИЛЦААНД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ЗӨРЧИЛДӨӨН

*Ж. Баттөр**

Орос, Хятад хоёр орон анх хоорондоо 1689 онд албан ёсоор “Нэрчүүгийн” хэмээх Гэрээ байгуулан харилцаж эхлэснээс хойш тооцвол эдүгээ хүртэл дөрвөн зуу гаруй жилийн баялаг түүхэн харилцаатай орнууд агаад өнөөг хүртэлх түүхээ ерөнхийд нь дөрвөн том үе шатанд хуваан авч үзсэн байдаг. Үүнд:

Нэгд, “Харилцааны үндэс тавигдсанаас 1917 он хүртэл” (Энэ үеийг бас Тэнцвэрээс колончлол хүртэлх үе ч гэдэг.)

Хоёрт, “Иргэний дайнууд хийгээд хувьсгалын эрин үе. ЗХУ ба Бүгд Найрамдах Хятад улс, 1917-1949 он”.

Гуравт, “Найрамдалаас зөрчилдөөнийг дамжин харилцаагаа хэвийн болгосон үе. Зөвлөлт-Хятадын харилцаа, 1949-1991 он”.

Дөрөвт, “Харилцаа хэвийн болгосоноос стратегийн түншлэл рүү. ЗХУ задарсан хийгээд Орос-Хятадын харилцааны үе” гэж тус тус ангилсан байдаг.¹

Орос-Хятадын харилцааны өвөрмөц шинжийг судлаачид дараах байдлаар илэрхийлжээ. Нэгд, Орос, Хятад хоёр орон бол Евразийн эх газрын хамгийн аварга том, хамгийн хүчирхэг хил залгасан орнууд юм. Хоёрт, Орос, Хятад хоёр нь хэдийгээр хилийн мөргөлдөөн, үзэл суртлын маргаан тэмцэл өрнөж байсан ч томоохон хэмжээний дайн байлдаан хийж байсан түүх байхгүй улсууд. Гуравт, ялангуяа өнгөрсөн түүхэнд харагдсан шиг, аливаа томоохон сорилт тулгарахад нэг бол хоёуланд нь ашиг тустай, эсвэл хоёуланд хохиролтой байдаг онцлог бүхий харилцаатай явж иржээ. Жишээлбэл, дэлхийн 2-р дайны үед хоёр улс бие биедээ тусласнаар аль аль нь хожсон бол 1960-1970-аад оны үзэл суртлын дайн дэгдсэнээр хоёр орон хоёулаа хохирсон юм. Дөрөвт, ялангуяа сүүлийн үед тодорхой харагдах болсон нэг үзэгдэл бол хоёр орны үндэсний амин чухал ашиг сонирхол, олон улсын тавцан дахь үндсэн үйл явцад ижил төстэй байр суурь баримталж байгаа явдал юм.²

Гэхдээ энэхүү харилцааг хэт өөдрөгөөр авч үзэн, ямар нэг асуудалгүй, цаашдаа улам бүр ойртон нягтарч өргөжин тэлнэ гэсэн өөрөөр хэлбэл, ихээхэн найдвар тээсэн гэмээр төсөөллүүд нэлээд газар аваад байгааг

* Д-р (Ph.D.) дэд профессор, МУИС-ийн ОУХНУС.

үгүйсгэх аргагүй юм. Орос, Хятадын төрийн бодлогын хүрээнд энэхүү харилцааг ихээхэн сайшааж байгааг ойлгож болно.

Мөн хоёр орны ашиг сонирхлыг авч үзэж буй судлаачид ерөнхийдөө болж, өрнөж буй үйл явц, хоёр орны удирдагчдын хэлж буй үгс, байгуулж буй гэрээ хэлэлцээр, бичиг баримт зэрэгт илүү их ач холбогдол өгч, харин улс орнуудын харилцаанд илэрч болзошгүй, илрэх магадлалтай зарим нэг эрсдэлтэй үзэгдлүүдийг тооцоолохгүй байгаа тал харагдаж байна уу даа гэсэн бодол төрөх болсон учраас тус өгүүлэлд энэ санаагаа илэрхийлж байгаа юм.

Аливаа улс орны гадаад бодлогод “Үндэсний ашиг сонирхол” (заримдаа Үндэсний эрх ашиг ч гэж орчуулдаг. Ж.Б.) буюу “National Interest” гэсэн ойлголт байдгийг бид мэднэ. Улс орнуудын Үндэсний ашиг сонирхол нийцсэн тохиолдолд хамтын ажиллагаа өргөжин тэлдэг бол Үндэсний ашиг сонирхол алдагдсан нөхцөлд зайлшгүй сөргөлдөөнд ордог. Орчин үеийн үндэстний төрт улс (Nation-state) нь үндэсний ашиг сонирхолоо олж авах, хадгалах, өргөтгөх зорилгоор л дийлэнх бодлогоо явуулдаг. Тиймээс ихэнх улсын дотоод, гадаад бодлого нь нэг үгээр өөрийн улсын ашиг сонирхолыг тэргүүнд тавьж түүнийгээ бодлого болгон хэрэгжүүлэхэд оршдог.³ Улс орны ашиг сонирхол нь аливаа улсын тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлт, аюулгүй байдлаа хамгаалах, сайн сайхан байдал гэх мэт улс орны оршин тогтнохуй хийгээд хөгжил дэвшилд туйлын хэрэгтэй, тухайн үндэстний хүсэл эрмэлзлэл гэж хэлж болно. Эндээс үндэстний хүсэл эрмэлзлэл газарзүйн, стратегийн байрлал, байршил, түүх, уламжлал болон амьдралын хэв маяг зэрэг тухайн нэгэн үндэстний үнэ цэнэт зүйлсийн тогтолцооны нийт зүйлсийг өөртөө агуулсан байдаг тул аливаа нэгэн улс орны ард иргэдийн аж төрж буй нөхцөл байдал, хүсэл эрмэлзлэлээс шалтгаалаад улс орны ашиг сонирхлын тодорхой утга агуулга өөрчлөгдөн байж болно. Ханс Моргентау “ашиг сонирхол гэдэг бол улс төрийн үндсэн үзэл санаа (idea)” гэсэн байдаг.⁴ Тиймээс Хятад ч бай, Орос ч бай, аль ч улсын явуулж буй бодлого нь мөн чанартаа тухайн улсын ашиг сонирхол болохоос бусад улсын төлөө, бусад орны тусын тулд хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа, стратеги биш гэж ойлгож болно.

Түүнчлэн Олон улсын харилцааны шинжлэх ухаанд улс орнуудын хоорондын харилцааг нэг талаас ихээхэн хамааралтай байдаг ч, нөгөө талаас тухайн орны ашиг сонирхолын бүс буюу “Нөлөөний бүс” (Sphere of Influence) байдаг тухай тун тодорхой авч үздэгийг бид мэднэ. Ихэвчлэн их гүрнүүд болон хуучин их гүрэн байсан улсуудад энэ бодлого байнга оршсоор

ирсэн гэж хэлж болно. Энэхүү “Нөлөөний бүс” нь тухайн их гүрэнтэй олон арван жил ойр нягт харилцаатай байсан юм уу, хэл соёл, бичиг үсэг, шашин шүтлэгээс авахуулаад эдийн засгийн хамтын ажиллагааны асар урт түүх, харилцааны баялаг өв уламжлал зэргээр ялгардаг гэж хэлж болно.

Орос-Хятадын харилцааны цаана аль алиных нь эрх ашиг, нөлөөллийн бүс, ашиг сонирхлын бүсээ хамгаалах, бусдад алдахгүй байх гэсэн зорилго бий. Мөн Орос, Хятад хоёр орны аль алиных нь ашиг сонирхолд нийцэж буй зүйл үйл ажиллагааны талбарууд гэхэд юуны түрүүнд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (Цаашид ШХАБ гэж товчилов. Ж.Б.) байна. 2001 онд албан ёсоор байгуулагдсанаа зарласан энэ байгууллага Төв Азид хил залгаа орнуудын хоорондын улс төр, худалдаа, тагнуулын мэдээлэл, аюулгүй байдал, цэрэг батлан хамгаалахын чиглэлд итгэлцэл болон хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө чармайн ажиллаж тодорхой үр дүнд хүрээд байна.

Мөн БРИКС-ийн хүрээнд бас ихээхэн нягт хамтран ажиллаж байгааг бид харж байна. Энэ мэтчилэн ОХУ, БНХАУ-ын харилцаа ялангуяа олон улсын тавцан дээр бие биенээ дэмжиж байна. Эдийн засаг, хөрөнгө оруулалт, банк санхүү, худалдаа гээд БРИКС-ийн орнуудын хамтран ажиллаж буй салбаруудыг цааш нь нэрлэж болно. Нөгөөтэйгүүр, БНХАУ-ын дэлхийд улам бүр хүчирхэгжиж буй байр суурь, түүний бодит илрэл болсон “Нэг бүс, нэг зам” санаачилга зэрэг аварга том төслүүд нь ирээдүйд Орос, Хятад хоёр орны хооронд маргаан, зөрчил, зөрчилдөөн үүсгэж болзошгүй байгааг энэ өгүүлэлд төсөөлөл, магадлал дэвшүүлэх маягаар илэрхийлж байгаа бөгөөд энэ таамаглал нь зөвхөн судлаач миний хувь хүний үзэл болохыг тунгаан соёрхоно уу.

Орос-Хятадын хооронд үүсэн гарч болзошгүй зөрчил дараах хэдэн бүс нутагт өрнөж байна гэж хэлж болохоор байна. Гэхдээ энэ өрсөлдөөн голлон Оросын эзэнт гүрэн болон хуучин ЗХУ-аас улбаатай, өнөөгийн ОХУ-ын уламжлалт нөлөөллийн бүсэд өрнөж байгаа билээ.

1) Төв Ази

Юуны түрүүнд Төв Азийн бүс нутаг яах аргагүй Орос, Хятадын далд өрсөлдөөний талбар болох нь тодорхой байна. Хятад улс энэ бүсэд “Нэг бүс, нэг зам” санаачилгаа хэрэгжүүлж, Төв Азийн таван “стан” улсыг идэвхтэй хамруулж байгаа билээ. Гэхдээ Төв Азийн энэ бүс нутагт “Нэг зам, нэг бүс” санаачилгыг зарласны дараагаас Орос, Хятад хоёр үнэхээр Төв Азид хамтран ажиллаж чадах уу гэсэн асуултыг судлаачид тавьж эхэлсэн.⁵Гэтэл

Төв Ази бол яах аргагүй сүүлийн 150 гаруй жилийн Оросын нөлөөллийн бүс байсаар ирсэн юм.

19-р зууны дунд үеэс Оросууд Төв Ази руу хүчтэйгээр тэлж эхэлсэн юм. 1853 онд Оренбургийн амбан захирагч Перовский Сыр-Дарья мөрнөөр хэсэгхэн өгсөж Перовск хэмээх түшиц газрын (бэхлэлт гэж хэлж болно.) суурийг тавьсан ба 1854 онд Балхаш нуураас урагш орших Илийн хязгаарт Оросууд Верный (Үнэнч) хэмээх бэхлэлт байгуулсан нь яваандаа Алма-Ата нэртэй болсон.⁶ Энэ үеэс эхлээд Оросын Засгийн газар Төв Ази дахь байлдан дагууллаа эрс эрчимжүүлсэн гэж хэлж болно. 1864 онд Перовск, Верный зэрэг түшиц газруудын завсар өөр бусад бэхлэлт, түшиц газруудыг байгуулж хооронд нь холбох тушаалыг Засгийн газраас генерал Черняевт албан ёсоор өгсөнөөр тэлэлт эрчимжсэн байдаг. Черняев Туркестан, Чимкент хотуудыг байлдан эзэлж энэ зорилтыг биелүүлээд, цаашилж 1865 онд Ташкентыг эзэлж авав. Бухараг 1868 онд, Хиваг 1873 онд тус тус байлдан дагуулсан юм.⁷ Оросын эзэнт гүрний зүгээс Төв Ази буюу Оросуудын хэлдгээр Дундад Азийг байлдан дагуулсан тухай ихээхэн ном судалгаа байдаг.⁸

Юуны түрүүнд энэ бүс нутагт бүр 19-р зуунд Их Британи болон Оросын Эзэнт гүрний хооронд “Их Тоглоом” гэж нэрлэгдсэн геополитикийн том өрсөлдөөн өрнөсөн байдаг. Энэ том өрсөлдөөнд Орос ялж, Төв Ази буюу Оросуудын хэлдгээр Дундад Азид нөлөө, байр суурь, хяналтаа тогтоож чадсанаар өндөрлөсөн гэж хэлж болно. 1917 оны Октябрийн хувьсгалаас хойш дээрх Дундад Азийн орнууд болон хуучин Оросын Эзэнт гүрний нэг хэсэг орнуудыг эгнээндээ багтаасан ЗСБНХУ буюу товчоор ЗХУ байгуулагдсан. Харин 1990 онд ЗХУ задарч Зөвлөлтийн их гэр бүлийн арван таван улс бие даахад тэдний нэг хэсэг болох Төв Азийн таван стан тусгаар тогтнолоо зарласны дараагаас БНХАУ энэ бүс рүү орж ирсэн юм. Түүнчлэн АНУ, Энэтхэг, Турк, Европын Холбоо ч энэ бүс нутагт улс төр, эдийн засаг аюулгүй байдлын ашиг сонирхолоо илэрхийлэх болсон юм. Тиймээс энэ бүс нутагт болж буй их гүрнүүдийн өрсөлдөөнийг олон судлаач нар “Шинэ Их тоглоом” гэж нэрлэх болсон билээ.⁹

БНХАУ 2008 он гэхэд ОХУ-ыг ардаа орхин Төв Азийн хамгийн том гадаад худалдааны түнш, ялангуяа эрчим хүчний салбар дахь хамгийн том зээлдүүлэгч, хамгийн том хөрөнгө оруулагч болж чадсан юм. 2001 онд гадаад худалдааны хэмжээ 1.5 тэрбум байсан бол 2013 он гэхэд 50 гаруй тэрбум ам. доллар болсон бол ОХУ-ын Төв Азийн орнуудтай хийж байсан 31 орчим тэрбум ам. доллар болсон байв. 2016 оны тооцоогоор Хятадын компаниуд Казахстаны газрын тосны үйлдвэрлэлийн 25 орчим хувийг, Туркменистаны

байгалийн хийн үйлдвэрлэлийн 50 хувиас илүүг эзэмшиж байгаа тооцоо гарсан. Мөн Узбекистантай байгалийн хий, ураны салбарт 15 тэрбум ам долларын гэрээнд гарын үсэг зурсан.¹⁰

Энэ мэт томоохон эрчим хүчний төслүүдээс гадна дэд бүтцийн бүтээн байгуулалтанд ихээхэн ач холбогдол өгч анхаарлаа хандуулж байгаа билээ. Тухайлбал, БНХАУ болон Төв Азийн орнуудад хөрөнгө оруулалт хийхээр тохиролцсон эсвэл ажил хэрэг болгохоор эхлүүлсэн томоохон дэд бүтцийн бүтээн байгуулалтууд гэвэл, Кыргызстаны өмнөд хойд хэсгийг холбосон хурдны зам болон Кыргызстан болон Узбекистаныг холбосон хурдны зам, Узбекистан дахь “Ангрэн-Пап” төмөр замын туннель, Туркменистан-Узбекистан-Кыргызстаны байгалийн хийн хоолой болон Тажикистан дахь “Душанбе-Куляб-Кулма-Каракурум”-ын хурдны замуудыг нэрлэж болно.¹¹ Гэтэл Төв Ази бол ОХУ-ын хувьд мөн л амин чухал бүс нутаг гэж хэлж болно. Энэ бүс нутаг өмнө өгүүлсэнчлэн хаант Оросын үеэс Оросын нөлөөний бүс болсон, ЗХУ-ын асар их хөрөнгө оруулалт хийгдсэн, ОХУ-аас одоо ч туйлын их анхаардаг бүс нутаг билээ. ОХУ-ын санал санаачилгаар энэ бүс нутгийн орнуудаас эгнээндээ багтаасан Евразийн эдийн засгийн холбоо, Хамтын аюулгүй байдлын Гэрээ байгууллагыг байгуулсан.

1995 онд ОХУ, Беларусь, Казахстан гурав Гаалийн Холбоо байгуулснаа зарласан бөгөөд 2011 онд албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн болно. Эдгээр гурван орон Нийтийн эдийн засгийн орон зай гэдгийг байгуулан 2012 оноос “Евразийн Эдийн засгийн Комисс” хэмээн нэрлэж байгаад 2015 оноос “Евразийн эдийн засгийн холбоо”-г байгуулсан билээ. Үндсэндээ ОХУ-ын бүс нутгийн интеграчлалын хамгийн том байгууллага бодит үр дүн нь энэхүү ЕЭХ юм. Мөн ОХУ хийгээд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд хамтран 1992 онд Хамтын аюулгүй байдлын Гэрээг үзэглэсэн юм. Улмаар 2002 онд ОХУ, Беларусь, Армени, Казахстан, Кыргызстан, Тажикистан улсууд нэгдэн “Хамтын аюулгүй байдлын гэрээний Байгууллага”-ыг байгуулсан юм.

2) Алс Дорнод

Хоёрдахь далд өрсөлдөөний талбар бол ОХУ-ын Алс Дорнодын хэсэг буюу Дорнод Сибирийн нутаг гэж үзэж болохоор байна. Орос, Хятад хоёр хуурайн газрын хилийн урт 4300 км урт үргэлжилдэг. Энэ урт хилийн дийлэнх хэсгийг Оросын Алс Дорнод, БНХАУ-ын Манжуурын хэсэг, Приморийн хязгаар зэрэг нутаг эзэлдэг билээ. Орос, Хятад хоёр улс анх 1689 онд Нерчүүгийн гэрээгээр хилээ тогтоосон юм. Улмаар илүү

хүчирхэгжсэн Орос улс 19-р зууны дундуур цус урсгалгүйгээр Приморийн хязгаарын 165,9 мянган хав.дөр км нутгийг өөрийн болгож авсан агаад үүнийгээ 1858 оны зургаан сарын нэгний “Тяньжиний Гэрээ”, 1860 оны арван нэгэн сарын “Бээжингийн Гэрээ”-гээр хүчин төгөлдөр болгосон.¹² Энэ хавийн нутгийн хилийн маргаан, зөрчлийн асуудлаар хоёр улс удтал маргалдсаар 1924, 1963 онуудад тус хилийн асуудлаар хоёр орны эрх мэдэл бүхий хүмүүс уулзаж байсан ч тодорхой үр дүнд хүрээгүй байсаар 1969 онд Орос, Хятадын хооронд Даманы арлын зэвсэгт мөргөлдөөн үүссэн билээ. (Оросоор Даманский конфликт гэдэг. Ж.Б)

Мөн онд ЗХУ Алс Дорнодын хил рүү 30 орчим дивиз байрлуулсан бол БНХАУ 59 дивиз байрлуулж байсан билээ. 1990 онд хоёр орны удирдагчид холбогдох хүмүүс энэ асуудлыг шийдэхээр хөдөлмөрлөж, удаа дараагийн уулзалт гэрээ байгуулснаар 2001 онд “*Сайн хөрш, найрамдал, хамтын ажиллагааны Гэрээ*” (“*Договор о добрососедстве, дружбе и сотрудничестве*”) байгуулж чадсан билээ.

Өнөөдөр гол нь Алс Дорнод, Зүүн Сибириэс оросууд баруун тийш их хэмжээгээр нүүж хүн ам цөөрч байгаа, энэ бүсэд хятадууд ихээхэн нэмэгдэж байгаа, худалдаа хөрөнгө оруулалтын дийлэнхийг хятадууд хийж байна гэхчилэн Оросын хэвлэлүүдэд ихээхэн бичдэг. Орост “*Китайская экспансия*” буюу “**Хятадын тэлэлт**” гэдэг нэр томъёо хүртэл гарч ирсэн. Гэхдээ энэ үгийг илүү өргөн утгаар хэрэглэж байна. Ерөнхийдөө ингэж тодорхойлж байна:

1. Бусад улс орнуудыг эдийн засгийн болон улс төрийн хувьд ноёрхолдоо оруулах, нөлөөний хүрээгээ тэлэх, бусдын газар нутгийг булаан авах зорилго бүхий бодлого”¹³
2. Анх байсан зах хязгаар, хүрээнээс цааш дэлгэрэх, өргөжих, тархах.

3) Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан бусад улсууд

Хятад улсын тэлэлт мөн хуучин ЗХУ-ын улсын бүрэлдэхүүнд багтаж байсан улсууд, тухайлбал, Беларусь, Азербайжан, Армени, Гүрж, Молдав, Украин улсуудад ч хүчтэй өрнөж байгаа юм. Эдгээр улсуудыг Оросууд “*постсоветские страны*” гэж нэрлэдэг. Дээрх бүх улсууд газарзүйн байршлын давуу талаа ашиглан газар нутаг дээгүүрээ Хятадын “*Нэг бүс, нэг зам*” санаачилгын Европ руу нэвтрэх зам, тээврийн чухал транзит зангилаа болгох зорилго тавиад байгаа юм. Тийм ч учраас 2017 оны тавдугаар сарын 13-16-нд Бээжинд Хятадын зохион байгуулсан “Нэг бүс, нэг зам”-форумд Беларусийн Ерөнхийлөгч А. Г. Лукашенко-гоос гадна, Азербайжан, Армени,

Гүрж, Украины өндөр албаны хүмүүс оролцсон билээ.

Хятад улс эдгээр улсуудтай хамтран ажиллах талаар нэлээд ажил өрнүүлээд байгаа билээ. Юуны түрүүнд зээл, грант, буцалтгүй тусламжаа нэмэгдүүлж байна. Цөөн жишээ дурдахад, Беларусьт гэхэд 15 тэрбум долларын зээлийн шугам (кредитная линия) нээгээд байгаа бол, Арменийн 9.8 сая долларын өртөгтэй 200 түргэн тусламжийн унаа, Украины дунд сургуулиудад 23, 5 мянган шинэ компьютерийг олгосон байна.¹⁴

Мөн банк-санхүүгийн чиглэлд дээрх орнуудтай нэлээд идэвхитэй хамтран ажиллаж байна. Хятадын талаас энэ чиглэлд нэлээд шургуу чармайлт гаргаж байгаа байдал харагдаж байна гэж хэлж болно. Тухайлбал, Гүрж улсад 1 тэрбум долларын үндсэн хөрөнгө бүхий Гүржийг хөгжүүлэх банк нээсэн бол Украины Шинэчлэл, хөгжлийн банк (Український банк реконструкції та розвитку) -ны хувьцааг дуудлага худалдаагаар 99,9%-ийг нь худалдан аваад байна. Үүнээс гадна Хятад Украинд үнэт цаас худалдан авч байгаа бөгөөд голчлон Украины хөдөө аж ахуй, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүдийн хувьцаа, үнэт цаас (облигация)-ыг худалдан авахад одоогоор 7 тэрбум илүү доллар зарцуулаад байгаа юм.¹⁵

Бас нэгэн өвөрмөц хамтын ажиллагаа нь эдгээр орнуудтай тус тусад нь хамтарсан “Чөлөөт худалдааны бүс” байгуулахаар зорьж буй явдал юм. Энэ нь ч эхнээсээ ажил хэрэг болоод явж байна. Гүрж улс хуучин Зөвлөлтийн улсуудаас анхны ийм гэрээг БНХАУ-тай байгуулсан бол Молдова удахгүй ийм гэрээ байгуулах гэж буйгаа мэдэгдэж, Украин, Азербайжан улсууд мөн хүсэлт, сонирхлоо илэрхийлээд байна.¹⁶

4)Европ.

Хятад улс Орос улстай уламжлалт харилцаатай Зүүн, Зүүн-хойд Европын орнуудтай худалдаа, эрчим хүчний дэд бүтэц, цөмийн эрчим хүч, тээвэр, дэд бүтцийн салбарууд руу маш эрчтэй орж байна.

Европын орнуудаас юуны түрүүнд Грекийг дурдмаар байна. Грек бол Оростой адилхан Үнэн алдартны шашинтай, түүх соёлын олон зуун жилийн уламжлалт харилцаатай, мөн Оростой адилхан Барууны орнууд, бүр тодорхой хэлбэл Европын Холбоотой өр шир, зээл гэх мэт байнгын зөрчилтэй байдаг. Нэг ёсондоо Оростой нэлээд зүйл дээр ашиг сонирхол нэгтэй гэсэн үг. Гэтэл энэ улсын Пираеус боомтыг 2017 онд Хятадын Коско компани 500 сая еврогоор 35 жилийн хугацаатай эзэмшиж, ашиглах гэрээ байгуулж, маш хурдан шинэчилж байна.¹⁷Мөн Болгар, Румын, Польш, Чех зэрэг орнуудад цөмийн цахилгаан станцын салбар хийгээд цөмийн дэд бүтцийн салбаруудад

өрсөлдөж байгааг энд дурдах хэрэгтэй.

Барууны нэгэн судлаачийн хурцаар шүүмжилж бичсэнээр “Ерөнхийлөгч Владимир Путин Өрнөдийг сорьж (тэмцэлдэж) байх зуур Ерөнхийлөгч Си Жинпингээр удирдуулсан Хятад түүнийг тойрон чимээгүй урагшилж байгаа нь Оросын эдийн засгийн эмзэг цаг үе дэх түүний (Путины) стратегийн харалган байдлыг (strategic shortsightedness) харуулж байна” гэж хүртэл бичиж байна.¹⁸ Оросын гадаад бодлогын судалгааны RIAC байгууллагын 2018 оны таамаглалд ч “Орос, Хятадын улс төр эдийн засгийн харилцаанд өсөн нэмэгдсээр буй “asymmetric” буюу “тэгш бус (өрөөсгөл, тэнцвэргүй) байдлыг ирэх жилүүдэд Оросын гадаад бодлогод тулгарч мэдэх “Сорилт ба Аюул занал” гэж үзсэнийг бас бид нухацтай анхаарах хэрэгтэй гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Орос, Хятад хоёр улс хэдийгээр зарим судлаачдын үзэж байгаагчлан түүхийнхээ бүх цаг үе дэх хамгийн сайн харилцаатай, бие биенээ дэмжиж, бүх талаар хамтран ажиллаж байгаа ч энэ нь хоёр орны харилцаанд бүх зүйл өөгүй, зөрчилгүй, саад бэрхшээлгүй гэсэн үг биш агаад хэрвээ Хятад улс ОХУ-ын нөлөөний бүс, Үндэсний эрх ашиг руу улам бүр лавшран халдах тусам ОХУ-ын зүгээс хариу арга хэмжээ авахаас өөр аргагүй байдалд хүрэх болно гэсэн таамаглал дэвшүүлж байна.

НОМ ЗҮЙ

1. Дипломатическая Академия МИД России “Россия и Китай: Четыре века взаимодействия”. История, современное состояние и перспективы развития Российско-Китайских отношений. Под редакцией А. В. Лукина. Издательство “Весь мир”, Москва, 2013. стр. 5.
2. Там же. стр. 8
3. Пак Гуан Соб, “Understanding of Modern International Politics”, Сөүл, Дэгён хэвлэлийн газар, 2012, 53-р тал. (Солонгос хэлээр).
4. Мөн тэнд.
5. Тухайлбал, Nyshka Chandran, “Can China and Russia co-operate in Central Asia” US-China Perception Monitor, <https://www.uscnpm.org/blog/2015/12/15/can-china-and-russia-co-operate-in-central-asia/>
6. Гюнтер Штөкл, “Оросын түүх”. Герман хэлнээс орчуулсан Дархан Д. Моононцагаан. Монсудар хэвлэлийн газар, 2011, 420-р тал.
7. Мөн тэнд.

8. Тухайлбал, Е. А. Глущенко “*Россия в Средней Азии: Завоевания и преобразования*”. М., Центрполиграф, 2010.
9. Yu Xichao. “*China’s Rise in Central Asia: Implication for EU Interests*”. March 2014. European Institute for Asian Studies, EU-Asia at a Glance.
10. <http://www.heritage.org/asia/commentary/chinas-huge-one-belt-one-road-initiative-sweeping-central-asia>
11. <http://www.businessinsider.com/china-economy-silk-road-world-trade-2017-4/>
12. Тодруулж үзье гэвэл дараах сайтаас харна уу: <http://primamedia.ru/news/471676/>
13. Ожеговын “*Орос хэлний тайлбар толь*”-ноос тодруулан үзнэ үү.
14. А. Ч. Мокрецкий, /ЦИПРКО ИДВ РАН/ “*Реализация проекта “Экономического пояса Шелкового пути” как механизм геополитики КНР в постсоветских странах*”. Журнал “Проблемы Дальнего Востока”, 5/2017. Российская Академия наук, Институт Дальнего Востока. Стр. 23.
15. Там же.
16. Там же.
17. <http://www.nytimes.com/2012/10/11/business/global/chinese-company-sets-new-rhythm-in-port-of-piraeus.html>
18. Robert D. Kaplan, “*The Quiet Rivalry between China and Russia*”, The New York Times International Edition, November 4-5, 2017. Pp. 6-7.
19. <http://russiancouncil.ru/en/activity/digest/longreads/russia-s-foreign-policy-looking-towards-2018-summary/>

ОРОСЫН ГЕО-ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ДАХЬ МОНГОЛ УЛС.

*С.Баясгалан**

Хураангуй: ОХУ нь Европ, Ази тивийг дамнан оршдог дэлхийн хамгийн том газар нутагтай орноос гадна геополитикийн ашигтай байрлалтай улс юм. Үүний зэрэгцээ байгалийн баялаг, нэн ялангуяа эрчим хүчний эх үүсвэр болох газрын тос, байгалийн хийгээр маш баян улс юм. Энэ нөхцөл байдал нь ОХУ-д их боломж, мөн давуу байдлыг бий болгож байгаа юм. Одоогоор ОХУ энэхүү байдлаа ашиглан нийт төсвийн 50 орчим хувийг газрын тос, байгалийн хийн экспортоос олсон орлогоороо бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл ОХУ газар доорх баялгаа экспортонд гаргах замаар төсвөө бүрдүүлдэг. Энэ нь ОХУ-ын эдийн засгийг гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай болгодог ч хөрш зэргэлдээ орнуудыг ч мөн хэмжээнд Оросоос хамааралтай болгодог.

ОХУ газрын тос, байгалийн хийгээ үндсэн хоёр чиглэл болох Европ болон Ази руу экспортолдог. 2014 оноос ОХУ Барууны орнуудын тавьсан хоригоос үүдэн, мөн Алс дорнодын мужуудаа хөгжүүлэх зорилгоор Ази рүү түлхүү хандах болсон. Оросын хувьд Ази дахь хамгийн том зах зээл нь тус бүс нутгийн бусад орнуудын нэгэн адил Хятад улс юм. Орос Азид маш их ач холбогдол өгч, байгалийн хий гаргахын зэрэгцээ дэд бүтцээ Хятадын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөгжүүлэх замаар АНД-н бүс нутаг руу гарахыг эрмэлзэж байна.

Оросын гео-эдийн засгийн бодлого Хятад руу чиглэж байгаа ч гэсэн Монгол улсыг тойрч гарна гэсэн үг биш юм.

Оросын хувьд Монгол улс нь геополитикийн ашигтай байршилтай орон учраас гео-эдийн засгийн бодлого явуулах замаар тус улсыг хараандаа байлгахыг хичээж ирсэн, өнөөдөр энэ хандлага сэргэж байхыг үгүйсгэхгүй. Монгол Улс эрчим хүчний тал дээр ОХУ-аас 80 орчим хувь хараат байдаг.

Харин Монгол улсын хувьд хоёр хөршийн харилцаа, хамтын ажиллагаанаас өөрсөддөө ашигтай, бидний ашиг сонирхолд нийцсэн, хоёр хөрш орны ашиг сонирхолд үл харилах аливаа төсөл хөтөлбөрийг авч ашиглах нь чухал байна. Үүний тулд ОХУ-ын Ази руу чиглэсэн гео-эдийн засгийн бодлогод Монгол улсын талаар ямар

* Доктор (Ph.D) МУИС-ийн ОУХНУС.

байр суурьтай байгаа болон үүнийг нь бид хэрхэн ашиглаж болохыг судлах хэрэгтэй юм.

Түлхүүр үг: *ОХУ-ын гадаад бодлого, Монгол улсын гадаад бодлого, геополитик, эдийн засаг, гео-эдийн засаг, гурван улсын харилцаа, эрчим хүчний аюулгүй байдал, байгалийн хийн дипломат ажиллагаа.*

Оросын гео-эдийн засгийн бодлого

2000 оноос өмнө ОХУ-ын гадаад бодлогын гол чиглэл нь АНУ болон Европын орнууд байсан. 2000 онд ОХУ-ын Ерөнхийлөгчөөр В.В.Путин сонгогдсоноос хойш гадаад бодлогын чиглэлд өөрчлөлт гарч, Ази руу анхаарлаа хандуулах болов.

Энэ нь хэд хэдэн учир шалтгаантай байсан.

Нэгд, олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдлаас үүдэн АНУ болон Европын орнуудын зүгээс ОХУ-д ирэх шахалт нэмэгдсэн. Үүнд гол нөлөөлсөн хүчин зүйл нь хойд Кавказд Ичкерийн бүгд найрамдах Чечен улс гэдгийг тунхаглан зарласан нь ОХУ-ын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд шууд аюул учруулах болсон ба чеченчүүдийг Барууны орнууд дэмжиж тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэгчид хэмээн үзэж байсан. Орос үүнийг дотоод хэрэгт оролцлоо хэмээн эгдүүцэж байсан. Мөн 1999 онд Югослав улс задарснаас үүдэлтэй угсаатнуудын хооронд мөргөлдөөн гарч НАТО Серб рүү дайрсан зэрэг үйл явдал ОХУ-ыг гадаад бодлогын чиглэлээ эргэн харахад хүргэсэн байдаг.

Хоёрт, ОХУ Алс дорнодын “орхигдсон мужуудаа” гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар хөгжүүлэх шаардлагатай байгааг харсан.

Гуравт, Дундад Азид сулраад байсан нөлөөгөө бэхжүүлэх шаардлагатай болсон.

Чухамдаа энэ үеэс эхлэн ОХУ ганц Европын орнуудтай харилцах бус Азийн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа сэргээх бодлого руу шилжсэн байна. В.В.Путин Европ болон Азийн чиглэл рүү нэгэн зэрэг ижил түвшинд харилцах бодлого баримтлах болжээ. Ингээд Орос бол зөвхөн Европын орон биш бас Азийн орон гэх бодлого явуулж эхлэв.

ОХУ-ын геополитикт суурилсан бодлого нь Алс дорнодын хил орчмын мужууд төвөөсөө хэт хол байдаг учраас тэдгээрийг хил залгаа орнуудын хөрөнгө оруулалтыг татах замаар, мөн тухайн улс орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх замаар хөгжүүлэх бодлого баримтлах болсон. Тухайлбал, Байгаль нуур орчмын мужуудыг (Кемерово, Эрхүү, Алтай, Тува,

Буриад г.м.) Монгол улстай харилцаа тогтоох замаар хөгжүүлэх, Ар Байгаль, Амар мөрний орчмын мужууд болон Хабаровскийг Хятадтай харилцаа тогтоох замаар хөгжүүлэх, Алс дорнод дахь Владивосток болон Находка боомт хотуудыг эдийн засгийн чөлөөт бүс болгох замаар хилийн чанадын ЗХА-ын бүс нутгийн орнууд, тэр дундаа Японы хөрөнгө оруулалтыг татах замаар хөгжүүлэхийг эрмэлзэж ирсэн нь одоо хүртэл үргэлжилж байна.

Энэхүү бодлогын хүрээнд 1990 оноос хойш “унтаа” байдалд байсан Монгол-Оросын харилцааг сэргээж 2000 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин анх удаа Монгол Улсад айлчилж байв. Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагаагаа сэргээхийн тулд ОХУ 2000 онд Улаанбаатарын тунхаглалыг байгуулсан.

2000 оноос хойш ОХУ-ын Европ руу түлхүү чиглэж байсан худалдаа, эдийн засгийн харилцаа Европ, Азийн чиглэлд тэнцвэртэй байсан бол 2014 онд болсон Украйны хямрал, үүний үр дүнд Барууны орнуудаас Оросын эсрэг тавьсан хориг арга хэмжээ зэргээс үүдэн ОХУ гол анхаарлаа Ази руу хандуулахад хүрэв.

ОХУ-ын хувьд байгалийн хий нийлүүлэх тал дээр Европоос (500 сая хэрэглэгч) илүү том зах зээл Азид байсан нь БНХАУ (1,3 тэрбум хэрэглэгч) юм. Өөрөөр хэлбэл Орос хохироогүй, харин ч хожиж байв.

Хятадын хувьд өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээгээ хангахын тулд Оросоос байгалийн хий авахаар болсны зэрэгцээ, өөрийн эдийн засгаа тэлэхийн тулд Европыг Хятадтай холбосон “шинэ торгоны зам” төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь ОХУ-ын хувьд таатай нөхцлийг бий болгов. Учир нь Ази, Европыг холбосон энэхүү төсөл нь Оросын Алс дорнодын төмөр зам, дэд бүтэц, ложистикийн асуудлыг ямар нэгэн хоосон зардалгүйгээр шийдэх боломжийг олгож байв.

Орос Азид, тэр дундаа Хятадад маш их ач холбогдол өгч байгааг бүх түвшний судлаачид, шинжээчид болон эрх бүхий хүмүүсийнх нь байр сууринаас харж болохоор байна. Тухайлбал Виталий Монкевич³⁹ Хятадын эдийн засаг хөгжиж байна, Торгоны зам төсөл хөгжихтэй зэрэгцэн Евразийн [Оросын] хэсэг ч гэсэн хамт хөгжинө. 2017 оны эхний хагаст Хятад гаднаас 8.5 сая баррель газрын тос импортолж анх удаа АНУ-ыг давсан байна, мөн 95 сая тонн төмрийн хүдэр импортолсон байна⁴⁰. Хятадын нийт импортын 60 хувийг буюу ойролцоогоор 140 тэрбум ам.долларын өртөгийг газрын тос болон байгалийн хийн импорт эзэлж байна. Хятадад хамгийн ашигтай

³⁹ Орос, Азийн хамтын ажиллагааны байгууллагын Ерөнхийлөгч.

⁴⁰ “Геоэкономика”: глобализация по-китайски. От 18.10.17 - Россия 24.

бөгөөд тогтвортой эрчим хүчний эх үүсвэрийг нийлүүлэгч нь Орос байх бүрэн боломжтой. Орост эрчим хүчний нөөц их байгаа. Орос Хятадтай харилцахад ямарч саад байхгүй, магадгүй дамжин өнгөрөх ганц орон нь Монгол байж болох юм, өөр ямарч улс байхгүй. Монгол энэ хоёр улстай аль алинтай нь сайн харилцаатай учраас ямар нэгэн хүндрэл гарахгүй. Тиймээс Хятад руу байгалийн хий нийлүүлж Хятадын торгоны зам төслийг Оросууд дэмжвэл Орос Алс Дорнодын эрчим хүчний асуудал бүс нутаг дахь төмөр зам болон дэд бүтцийн асуудлаа илүү хялбар шийдвэрлэх боломжтой болж байгаа талаар ярьжээ.

Үүгээр ч хязгаарлагдахгүй 2014 онд Орос, Хятадын хооронд Хятадад 30 жилийн хугацаанд 400 тэрбум ам.долларын байгалийн хий нийлүүлэх гэрээ байгуулагдав. Уг гэрээгээр хоёр орны худалдааны эргэлтийг 2020 он гэхэд дор хаяж 200 тэрбум ам.доллар хүргэхээр зорьж байна. Үүний зэрэгцээ ОХУ Алс дорнодын бүс нутгаа хөгжүүлэх зорилгоор жил бүр 100-110 тэрбум ам.долларыг төсөвлөхөөр “2025 он хүртэлх Алс дорнод, Байгаль нуур орчмын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан байна⁴¹.

Өнөөдөр үүсэн бий болоод байгаа Баруунтай харилцах ээдрээтэй харилцаа нь Оросыг анхаарлаа улам бүр дорно зүгрүү чиглүүлж Хятад, Энэтхэг, Өмнөд Солонгостой харилцах харилцааг эрчим хүч, ложистик төдийгүй өндөр технологи, сансар судлалыг ч хамран харилцааг улам өргөжүүлэхэд хүргэж байна⁴².

ОХУ-ын Монгол Улсын талаарх гео-эдийн засгийн ашиг сонирхол нь геополитикийн ашиг сонирхол дээр тулгуурладаг. Дээр хэлсэнчлэн Байгаль нуурын орчмын мужуудыг Монгол Улстай харилцаа тогтоох замаар хөгжүүлэхийн зэрэгцээ ОХУ Монгол улсын төдийлөн сайн хөгжөөгүй эрчим хүчний салбар болон дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхолтой байна. Эрчим хүч, дэд бүтэц нь аливаа улсын хөгжлийн суурь билээ. Дашрамд дурьдахад Монгол Улсын бүх бүтээн байгуулалт орос технологи дээр суурилсан байдаг нь Орост давуу талтай юм.

ОХУ-ын хувьд Монгол улсын газар зүйн байршил, мөн стратегийн шинж чанартай ашигт малтмалын ордууд түүний анхаарлыг зүй ёсоор татдаг учраас бусдын гарт оруулахгүй байх нь чухал юм.

Монголын талаарх Оросын судлаачдын байр суурийг авч үзвэл

⁴¹ Сотрудничество с Монголией-Важное звено восточной политики России, Российский институт стратегических исследований, <https://riss.ru/analitics/6819/>

⁴² Мөн тэнд

Монгол улс нь Оросын хувьд стратегийн чухал ач холбогдолтой. Монгол улсад болж байгаа асуудал ЗХА-ийн бүс нутагт өрнөж буй үйл явцын нэгэн адил чухал юм. Тиймээс Орос, Монголын харилцаа нь Оросын дорныг чиглэсэн гадаад бодлогын нэг чухал хэсэг, Ази тивийн гүнд геополитик, геостратегийн маш чухал байрлал эзэлдэг улс юм⁴³.

ОХУ-ын хувьд Монгол дахь ашиг сонирголоо алдахгүй байх төдийгүй улам бэхжүүлэхэд стратегийн ач холбогдолтой гол “судаснуудыг” барих нь чухал юм. Үүнд таван чиглэлийг авч үзье.

1. Төмөр замаар дамжсан гео-эдийн засгийн бодлого

2014 онд В.В.Путинийг Монгол Улсад дахин айлчлахад түүнийг дагалдаж ирсэн албаны хүмүүсийн дотор Эрчим хүчний сайд Александр Новак, Алс дорнодын хөгжлийн сайд Александр Галушка, төрийн өмчийн РЖД буюу “Оросын төмөр замууд” нийгэмлэгийн ерөнхийлөгч Владимир Якунин болон бизнесийн салбарыг төлөөлж Оросын шууд хөрөнгө оруулалтын сангийн ерөнхий захирал Кирилл Дмитриев, “Роснефть” компанийн тэргүүн Игорь Сечин, хөнгөн цагааны үйлдвэрлэлийн “Русал” компанийн тэргүүн Олег Дерипаска нарын хүмүүс багтжээ⁴⁴. Дагалдаж ирсэн төлөөлөгчдөөс харвал ОХУ нь Монгол Улсын дэд бүтцийн салбарыг сонирхож байгааг харж болохоор байв.

В.В.Путины геополитикийн бодлогоо хэрэгжүүлэх гол хэрэгсэл нь төмөр зам юм. Төмөр замаар дамжуулан хэрэгжүүлэх бодлогыг Оросын төрийн өмчит “Оросын төмөр замууд” нийгэмлэг хэрэгжүүлж байгаа. “Оросын төмөр замууд” нийгэмлэгийн явж буй төмөр зам хүрсэн газар нутгийг өөрөөр “1520 мм царигийн орон зай” гэж бас нэрлэдэг. Мөн худалдааны эргэлтийн ихэнх нь төмөр замаар явдаг учраас зарим судлаачид “Евразийн эдийн засгийн холбоо” ч гэж нэрлэх нь бий.

⁴³ Сотрудничество с Монголией-Важное звено восточной политики России. Российский институт стратегических исследований, <https://riss.ru/analitics/6819/>

⁴⁴ ОХУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилж байна, 2014.09.03, <https://www.news.mn/?id=172830>



В.В.Путин төмөр замаар хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудыг, мөн Монгол мэт социалист хамтын нийгэмлэгт байсан орнуудыг нэгдсэн сүлжээнд оруулахыг эрмэлзэж байна. Энэ бодлогын илрэл нь тухайлбал Армений төмөр зам хэдийгээр “Өмнөд Кавказын төмөр зам” нэртэй боловч “Оросын төмөр замууд” нийгэмлэг концессоор эзэмших болсон явдал юм. Үүний зэрэгцээ Хятад Кыргызд төмөр зам тавьж өгье гэхэд нь Орос шатахууны нийлүүлэлтдээ хориг тавина гэж сүрдүүлснээс уг төсөл зогсов. Өөрөөр хэлбэл төмөр зам бол геополитикийн бодлогыг геоэдийн засгийн хөшүүргээр хэрэгжүүлэх гол аргуудын нэг юм. Энэхүү “1520 мм царигийн орон зай”-д Монгол улс ч багтдаг. Монгол Улсын дэд бүтцийг ЗХУ-ын үед барьж байгуулсан оросын техник, технологи учраас⁴⁵ үүнд багтахуас ч өөр аргагүй юм.

Оросын зүгээс харвал Монгол улсад нүүрс, уран гэсэн стратегийн хоёр ашигт малтмалын орд газруудтай. Оросын хувьд Монголд байгаа эдгээр стратегийн орд газар бусдын гарт орох нь ашиг сонирхолд нь нийцэхгүй. Энэхүү ашиг сонирголоо хамгаалахад төмөр зам чухал үүрэгтэй юм.

Жишээ нь 2007 онд ОХУ Монголын Таван толгойн нүүрсний ордыг сонирхож байгаагаа илэрхийлж байсан. Таван толгойн орд нь нүүрс гаргадаг гол зах зээл болох Хятадад маш ойрхон, Монголын төмөр замыг Таван толгойн нүүрсний ордтой холбосноор Орос хяналт тогтоох боломжтой байгаа.

Оросын нүүрс Монголын нүүрстэй өрсөлдөхөд хүрээд байна гэж үзэх судлаачид ч байдаг. Энэ өнцгөөс Ерөнхийлөгч Х.Баттулгыг төмөр

⁴⁵ Монголия-страна особого Путинского внимания, 2014, <http://asiarussia.ru/news/4178/>

замын төслийг гацааж, Орост ашигтай байдал бий болгосон гэж буруутгах хүн цөөнгүй. Харин одоо Оросууд Хятад руу тонн, тонноор нь нүүрс гаргаж байгаа төдийгүй Орост Хятад руу нүүрс экспортлох үйлдвэр хүртэл баригдаад байна, тиймээс энэ асуудал Оросын явуулга гэж хардах хүн ч байна.

Дээрх асуудлуудаас гадна Оросын гео-эдийн засгийн бодлогын хүрээнд ОХУ Монголын ураныг маш их сонирхдог. Эрчим хүчний салбарт тэргүүлэх зорилготой ОХУ-ын хувьд стратегийн ач холбогдолтой Монгол улсад орших ураны орд газрыг гадаадын бусад хөрөнгө оруулагчдад алдахыг хүсэхгүй байна. ОХУ Монголтой хамтран ураны хайгуул, олборлолт хийх “Дорнод уран” компанийг байгуулж, хамтран ажиллахыг оролдсон боловч энэ нь бүтээгүй билээ.

2. Цахилгаан эрчим хүчний асуудал.

ОХУ Монгол Улсыг Сэлэнгэ мөрөн дээр усан цахилгаан станц барих нь Байгаль нуурын экосистемд гамшгийн нөлөөтэй учраас эсрэг байр суурьтай байгаагаа Оросын байгалийн нөөцийн сайд С.Донской хэлсэн байна⁴⁶. Оросын зүгээс Монголын эрчим хүчний өөр эх үүсвэрүүдээр тусалж болохыг хэлсэн байдаг. Олон хувилбар байгааг товч дурьдвал: нэгт Буриадын Галуут нуур-Дарханы чиглэлээр өгдөг цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх, хоёрт, Оросоос Хятад руу Монголоор дамжуулан цахилгаан эрчим хүч гаргах⁴⁷; гуравт Галуут нуураас татсан цахилгааны шугам Увсаар дамжин Тува руу явж Кызылтэй холбогдсоноор эрчим хүчний тойрог үүсгэх, дөрөвт, цөмийн цахилгаан станц барих гэх мэт арга замуудыг санал болгодог. Энэ хувилбар ч гэсэн Монгол улсыг эрчим хүчний хараат хэвээр байлгахаар байна.

3. Хятадын “Нэг бүс, нэг зам” төсөл ба Орос

Хятадын өдрөөс өдөрт тэлж буй эдийн засаг, түүхий эдийн хэрэгцээ нь Хятад улсыг шинэ торгоны зам төслийг хэрэгжүүлэхэд хүргэж байна. Хятадыг Европын зах зээлтэй холбох зам нь ОХУ-ын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа нь Орост олдож байгаа маш том боломж юм. Хятадын шинэ торгоны зам төслийг хэрэгжүүлэх төсөл нь “Нэг бүс, нэг зам” билээ.

⁴⁶ РФ предлагает Монголии отказаться от ГЭС, губительной для Байкала. Известия 2017, <https://iz.ru/625837/2017-07-29/rr-predlagaet-mongolii-otkazatsia-ot-ges-gubitelnoi-dlia-baikala>.

⁴⁷ Вместо Шурэнской ГЭС в Монголии можно построить АЭС или угольные электростанции. EastAsia, 2016, <https://www.eastrussia.ru/news/vmesto-shurenskoy-ges-v-mongolii-mozhno-postroit-aes-ili-ugolnye-elektrostantsii-sergey-levchenko/>.

Энэхүү төсөл нь ОХУ-ын нутаг дэвсгэрээр хоёр газраар явж байгаагийн нэг нь шууд Алс дорнодоор, нөгөөх нь Казахстангаар дамжин Орос руу орж байна. Хэдийгээр Монголоор дамжин Орос руу орох хувилбар байгаа ч явцын хувьд бусад хувилбаруудыг бодвол хэрэгжиж эхлээчгүй байна. Монгол Улс энэхүү төсөлд оролцох замаар Орос, Хятадыг холбосон зам харилцаа, дэд бүтцээ хөгжүүлэх боломжтой юм.

Оросын зүгээс Монголд “Талын замыг” хэрэгжүүлснээр Монгол Улсын дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах, оросын компаниудыг оруулах боломжтойг илэрхийлсэн байгаа.

4. Түлш, эрчим хүч

Орос Монголын хоорондын худалдаанд эрх тэгш бус байдал байна, худалдааны эргэлтийн 88 хувийг Оросын экспорт эзэлж байна, Монголын экспортын гол бүтээгдэхүүн нь ашигт малтмал, харин Оросын хувьд өөрөө байгалийн баялагтай учраас Монголоос авах нь ач холбогдол багатай. Оросоос экспортлох барааны 60 хувийг шатах, тослох материал эзэлдэг⁴⁸. Монгол руу гаргадаг нэг төрлийн бүтээгдэхүүн Монгол дахь Оросын эдийн засгийн эзлэх байр суурийг сулруулж байна гэсэн дүгнэлтийг Оросын тал хийж байна.

Монголд газрын тос боловсруулах үйлдвэр байгуулагдсан тохиолдолд Оросын байр суурийг нэлээд сулруулна⁴⁹ гэж үзэж байгаа учраас хяналтаа сайжруулах зорилгоор Оросын түлш эрчим хүчний компаниудыг Монголд хөрөнгө оруулахыг дэмжих нь ойлгомжтой юм. Тухайлбал 2008 онд Оросын газрын тосны компани “Роснефть” нь Монгол улсад шатахуун түгээх станц болон нефть бааз барих санал тавьж байсан ба энэхүү саналаа 2011 онд дахин тавьсан байдаг⁵⁰. Харин “Роснефть” бол Оросын төрийн өмчит компани билээ. Энэхүү алхам нь нэгт, үндэсний нефть импортлогч компаниудыг дампууралд хүргэх ба, хоёрт, Монгол улс дахь шатахууны зах зээлийг, шатхуунаар дамжин Оросын эдийн засгийн бүрэн хараат болох магадлал өндөр юм.

5. Хий дамжуулах хоолойн бодлого

Орос хэтдээ эрчим хүчний экспортоор тэргүүлэгч гүрэн болохыг

⁴⁸ Д.Н.Александрова, Экономические интересы России в Монголии и роль приграничных регионов, [://cyberleninka.ru/article/n/ekonomicheskie-interesy-rossii-v-mongolii-i-rol-prigranichnyh-regionov](http://cyberleninka.ru/article/n/ekonomicheskie-interesy-rossii-v-mongolii-i-rol-prigranichnyh-regionov)

⁴⁹ Мөн тэнд

⁵⁰ “Роснефть” Монголын зах зээлд 30 хувь хямд шатахуун борлуулах санал тавьжээ, <http://www.setguulch.mn/p/33671>

зорьдог талаар дээр дурьдсан. Гэхдээ ОХУ-ын хувьд эдийн засгаа тогтвортой байлгах хамгийн найдвартай эх үүсвэр нь байгалийн хийг гадагшаа экспортлох явдал юм. ОХУ Европын орнуудтай харилцаа муудах хүртлээ байгалийн хийг голчлон Украйнаар дамжуулан нийлүүлдэг байсан.



Украины хямралаас үүдэн Европын орнууд байгалийн хийгээ авч чадахгүйд хүрсний зэрэгцээ Украин дундаас нь завшдаг болсон зэрэг нь хий нийлүүлэх өөр гарц хайхад хүргэсэн ба Европын орнуудын хэрэгцээ шаардлагын улмаас өндөр өртгөөр хойгуур (Балтын тэнгисийн ёроолоор Герман руу) болон урдуур (Хар тэнгисийн ёроолоор Турк руу) хий дамжуулах хоолойг тавих болов. Үүнээс гадна Украины хямралаас үүдэлтэй эдийн засгийн хориг арга хэмжээнээс болж Азийн чиглэлд шинээр хийн хоолой тавих болов. Гэхдээ энэ тохиолдолд хэрэглэгч нь ч их, захиалга нь ч өндөр учраас урт хугацаанд Орост ашигтай юм. Орос ч үүнийг ойлгож өөрийн зардлаар хийн хоолойг цаг алдалгүй шуурхай тавьж байна.


ОХУ нь Хятадад маш их ач холбогдол өгч, их найдвар тавьж байгааг Оросын судлаачдын дүгнэлтээс харж болохоор байна. Тэд өнөөгийн даяаршлын гол төв нь Хятад болж, дэлхийн хөгжил Баруунаас Зүүн рүү шилжиж байна гэж үзэж, Оросын хувьд Хятад руу илүү анхаарал хандуулах болсон шалтгаан нь, нэгт, Хятад эдийн засгийн талаар дэлхийд тэргүүлэх бодлого баримталж байна, хоёрт, дэлхийн эдийн засаг Хятадын эдийн засгаас хамаарч байна, эцсийн дүндээ Оросын хувьд хамгийн чухал болох Хятад нь эрчим хүчний хамгийн том хэрэглэгч юм.



ОХУ-ын хувьд эрчим хүчний хэрэгцээ нь жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа Хятад улс руу хийн хоолой татах асуудал тогтвортой бөгөөд бэлэн валют орж ирэх боломжийг бий болгож байгаагийн зэрэгцээ аливаа үр өгөөжгүй бүтээн байгуулалт хийхгүй байх асуудал чухал юм. Өөрөөр хэлбэл, ОХУ Хятадын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор хийн хоолойг барьж байгаагийн зэрэгцээ эдгээр хийн хоолойг Алс дорнодын эрчим хүчний сүлжээнд хамрагдаагүй бүс нутгуудаар дамжуулан явуулж байгаа нь тус бүс нутгийн хөгжилд чухал хувь нэмэр болохыг давхар бодолцсон хэрэг юм.

Монгол Улсын хувьд Оросын “Сибирийн хүч” төсөл хэлэлцэх шатанд явж байхад нь Монголын нутаг дэвсгэрээр дайруулан явуулах боломж байгааг илэрхийлж байсан боловч Хятадын тал Монголын талыг хүсэлтээ хэтэрхий оройтож тавьсан, энэхүү асуудал өмнө нь аль хэдийнэ шийдэгдсэн байсан⁵¹ гэдэг шалтгаанаар татгалзсан байдаг. Оросын хувьд хийн хоолойн асуудлыг хэлэлцэхэд татгалзах зүйлгүй гагцхүү захиалагч тал л шийднэ гэсэн хариу өгөхийн зэрэгцээ Монгол Улс руу хийн хоолой татахад боломжгүй зүйл байхгүй болохыг хэлж байв.

⁵¹ Монголия не получит российский газопровод, Полная версия: <http://gazeta-n1.ru/news/35513/>, БНХАУ-ын Худалдааны яамны Евразийн хэлтсийн Ерөнхий захирал Лин Чжи.



ДҮГНЭЛТ

Бусад орнуудын нэгэн адил ОХУ-ын аюулгүй байдлыг хангах суурь хүчин зүйл нь эдийн засаг юм. Үүний зэрэгцээ ОХУ хуучин ЗХУ-ын орон зайд өөрийн нөлөөгөө хэвээр хадгалахын тулд эдийн засгийн хөшүүргийг хэрэглэх нь хамгийн оновчтой арга зам болох нь нэгэнт тодорхой юм.

Украины хямралаас үүдэн ОХУ Ази руу чиглэсэн худалдаа, эдийн засгийн харилцаанд гол анхаарлаа хандуулж байна. Хятад Улсын эдийн засгийн тэлэлт ОХУ-ын гео-эдийн засгийн бодлоготой ашиг сонирхолын хувьд давхцаж байгаа нь тус хоёр улс хамтран ажиллахад чухал суурь болж байна.

ОХУ-ын гео-эдийн засгийн бодлогын хүрээнд ОХУ Монголын төмөр замыг шинэчилж, цахилгаан эрчим хүч, дэд бүтцэд хуучин ЗХУ-ын материал бааз дээр тулгуурлан хөрөнгө оруулах сонирхол байгаа юм. Энэ талын асуудлыг ч Монголын талд санал болгосон. Үүнд “Талын зам” гэх төслөөр өндөр хурдны зам барих асуудал яригдаж байсан. Үүний зэрэгцээ Хятад Улс ч гэсэн “Нэг бүс, нэг зам”-ын хүрээнд Монгол Улсын дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах боломжтой юм. Хоёр хөрш Монгол Улсын нутаг дэвсгэрээр бараа бүтээгдэхүүн богино хугацаанд саадгүй явах нөхцлийг бүрдүүлэх нь тэдгээрийн ашиг сонирхолд нийцэж байгаа. Гэхдээ бид удаашралтай хандах юм бол тэд биднийг хүлээхгүй.

Монгол Улсын хувьд хоёр хөршийн ашиг сонирхол дээр тулгуурлан, тэдний хөрөнгө хүчийг ашиглах нь тус улсын хөгжилд их хэрэгтэй юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндэсний аюулгүй байдалын үзэл баримтлал, 2010
2. Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011
3. «Геоэкономика»: глобализация по-китайски. От 18.10.17 - Россия 24
4. Монголия-страна особого Путинского внимания, 2014, <http://asiarussia.ru/news/4178/>
5. Дорно зүгт хандсан Оросын бодлогын чухал сэжиг бол Монгол <http://mongolcom.mn/read/17889>
6. Монголия не получит российский газопровод, Полная версия: <http://gazeta-n1.ru/news/35513/>
7. Сотрудничество с Монголией-Важное звено восточной политики России, Российский институт стратегических исследований, <https://riss.ru/analitics/6819/>
8. Д.Н.Александрова, Экономические интересы России в Монголии и роль приграничных регионов, [://cyberleninka.ru/article/n/ekonomicheskie-interesy-rossii-v-mongolii-i-rol-prigranichnyh-regionov](http://cyberleninka.ru/article/n/ekonomicheskie-interesy-rossii-v-mongolii-i-rol-prigranichnyh-regionov)
9. ОХУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилж байна, 2014.09.03, <https://www.news.mn/?id=172830>